



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.08.19 № АТ/2207

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуулгын хариу хүргүүлэх  
тухай

Танаас боловсролын хууль тогтоомжийн зарим заалтын хэрэгжилтийн талаар тавьсан асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255010315



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛЫН САЙД**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,  
Цахим шуудан: letter@moe.gov.mn,  
Цахим хуудас: www.moe.gov.mn

2025.08.06 № 1/3446  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнээс 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Боловсролын хуулийн зарим заалтын хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарт гаргасан асуулгыг Монгол Улсын хэрэг эрхлэх газрын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн ХЭГ/1982 дугаартай албан бичгээр чиг үүргийн дагуу манай яаманд уламжилсан байна.

Асуулгатай танилцаж, хариуг хавсралтаар хүргүүлж байна, хүлээн авч танилцана уу.

Хавсралт ... хуудастай.



П.НАРАНБАЯР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.БАТ-ЭРДЭНЭЭС ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

**1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлын явц, үр дүнг Боловсролын үндэсний зөвлөлд танилцуулсан эсэх болон зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг шинэчилсэн хөтөлбөрт тусгасан эсэх талаар**

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.8-д “Энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх хугацаа нь суралцагчийн ерөнхий боловсрол эзэмших хугацаанаас багагүй байх бөгөөд хэрэгжилтийн явцад сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцүүлэн сайжруулж болно” гэж, мөн хуулийн 4.1-д “Сургуулийн өмнөх боловсролыг дөрөв, бага боловсролыг тав, суурь боловсролыг ес, бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшинэ” гэж тус тус заасан тул сургалтын хөтөлбөрийг 12 жилээс багагүй хугацаагаар тогтвортой мөрдөх юм.

Одоо мөрдөгдөж байгаа сургалтын хөтөлбөрийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/240 дүгээр тушаалаар баталж, 2014-2015 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн.

Дээрх хуулийн 10.8 дахь заалтын дагуу сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг 2024 онд эхлүүлж, Боловсролын ерөнхий хуулийн 14.3-д заасны дагуу сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулан хэлэлцүүлж, 2024 оны 04 сарын 09-ний өдөр Боловсролын үндэсний зөвлөлд танилцуулж, дэмжсэн байна.

Үндэсний зөвлөлөөр дэмжигдсэн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан.

Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/311 тоот тушаалаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх төлөвлөгөөг анх баталсан бөгөөд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (цаашид “БҮСХ” гэх)-гээс төлөвлөгөөг Боловсролын сайдын 2025 оны А/270 тоот тушаалаар шинэчлэн батлуулсан байна.

Дээрх төлөвлөгөөний дагуу сургуулийн өмнөх болон бага ангийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, турших ажлыг Боловсролын ерөнхий хуулийн 17.4, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.4-т тус тус заасны дагуу БҮСХ хариуцан ажиллаж эхэлсэн байна.

Үүний дагуу БСҮХ-ээс ирүүлсэн саналд үндэслэн Боловсролын сайдын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/06 дугаар тушаалаар сургуулийн өмнөх, бага боловсролын сургалтын хөтөлбөрийн төсөл, туршилтын үед хэрэглэх суралцагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийг боловсруулах багийг байгуулан ажилласан (багийн зарим гишүүд ажиллах боломжгүй болсонтой холбогдуулан БҮСХ-ээс 2025 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 227 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу

A/06 тоот тушаалд Боловсролын сайдын 2024 оны 12 сарын 16-ны А/250 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан).

Шинэчлэн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага, дасгал ажлын дэвтрийн туршилтыг зохион байгуулах зорилгоор "Туршилтын сургалтын төлөвлөгөө батлах тухай" Боловсролын сайдын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/57 дугаар тушаалыг баталж, түшиц 27 сургууль, 18 цэцэрлэгт тус тус туршсан.

Туршилтын үр дүнд үндэслэн БСҮХ-гээс 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 133 тоот албан бичгээр сургуулийн өмнөх болон бага ангийн монгол хэл, математик, байгалийн шинжлэл, зураг урлал, хөгжим, биеийн тамир, миний Монгол, эрүүл мэнд, компьютерын ухаан, үндэсний цөөнхийн суралцагчдад зориулсан казах хэл, тува хэл, ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан нийгэм ахуйн баримжаа гэсэн нийт 12 төрлийн сургалтын хөтөлбөрийн төслийг ирүүлсэн.

БСҮХ-гээс ирүүлсэн сургуулийн өмнөх боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн төслийг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (100 хувийн ирцтэй)-д танилцуулсан. Зөвлөлөөс гарагсан шинэчилсэн хөтөлбөрийн төслийг сайжруулах саналын дагуу холбогдох сайжруулалтыг хийсэн.

Энэ хөтөлбөрийн төслийг боловсруулах явцад хэд хэдэн удаа холбогдох байгууллага, мэргэжлийн судлаачидтай хисэн хэлэлцүүлгийн дүнд гарсан саналыг тухай бүр тусган сайжруулалт хийсэн. Түүнчлэн, хөтөлбөрийн төслүүдийг Монгол хэлний үндэсний зөвлөлд хүргүүлж холбогдох саналыг авч тусгасан болно.

Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу сургуулийн өмнөх боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн төслийг 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдөр Боловсролын үндэсний зөвлөлд танилцуулж, дэмжсэн тул Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 01-ний А/404 тоот тушаалаар баталсан.

Шинэчилсэн хөтөлбөрийг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор багш нарт зориулсан сургалтыг энэ оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн бүсчлэн зохион байгуулж байна.

Бага боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн төслийг холбогдох хуульд заасны дагуу Ерөнхий боловсролын мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн цахим хуралд, Боловсролын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдөр танхимаар зохион байгуулсан хуралд тус тус танилцуулж, зөвлөлийн гишүүдээс гаргасан саналын дагуу сайжруулах ажил хийгдэж байна.

Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/270 дугаар тушаалаар бага боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг 2026-2027 оны хичээлийн жилээс эхлэн үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан 2025-2026 оны хичээлийн жилд шинэчилсэн сурах бичгийг турших ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

## **2.Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлтэй холбогдох тайлбар**

Боловсролын ерөнхий хуулийн 26.1.5-д заасны дагуу Боловсролын сайдын 2025 оны А/87 дугаар тушаалаар “Сурах бичгийн эх зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.

Боловсролын ерөнхий хуулийн 27.1.1-д “сурах бичиг зохиох, хэвлэх, ханган нийлүүлэх **ажлыг зохион байгуулах**, сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж бодисоор хангах, төлөвлөгөө хэрэгжүүлэх” боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг байхаар заасан. Боловсролын ерөнхий хуульд ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт ороогүй болно.

### **3.Хувьсах зардлыг санхүүжүүлэх, зарцуулах заавартай холбоотой асуудлын талаар**

Засгийн газрын холбогдох шийдвэрээр сургалтын байгууллагын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээг тогтоож, түүний хэрэгжилтийг хангах зорилгоор хувьсах зардлыг санхүүжүүлэх, зарцуулах зааврыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170, Боловсролын сайдын 2024 оны А/279 тушаалаар тус тус баталж, мөрдүүлэн ажиллаж байна.

Эдгээр зааврууд хувьсах зардлаар санхүүжих “багшийн хөгжил”, “эрүүл мэндийн үйлчилгээ”, “цахим хэрэглээ”, “хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал”, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалт” гэсэн бүрэлдэхүүн зардлыг хэрхэн санхүүжүүлж, зарцуулах тухай заавар бөгөөд Засгийн газрын 2024 оны 39, 53 дугаар тогтоолоор энэ хувьсах зардлын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулалгүйгээр итгэлцүүрийг шинэчилж, шинээр “хүүхэд хамгаалал”-ын бүрэлдэхүүнийг нэмсэн.

Захиргааны ерөнхий хуулийн 49.5-д “Захиргааны байгууллагаас өөрөөр заагаагүй бол захиргааны акт цуцлагдсанаар хүчин төгөлдөр бус болно.” заасны дагуу Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаал гарах хүртэл А/170 дугаар тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан.

“Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны журам”-тай уялдуулан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зардлыг зарцуулах зааврыг батлах шаардлагатай болсон тул Боловсролын сайдын 2024 оны А/279 дүгээр тушаал гарах хүртэл багагүй хугацаа зарцуулсан болно.

Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зардалд 2024 онд ерөнхий боловсролын сургуулиудад нийт 11.2 тэрбум төгрөг хуваарилагдсан бөгөөд 7.8 тэрбум төгрөгийг зарцуулж 70 хувийн гүйцэтгэлтэй, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 2.0 тэрбум төгрөг хуваарилагдаж 1.5 тэрбум төгрөгийг зарцуулж 75.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

### **4.Боловсролын сайдын зарим албан бичигтэй холбогдох асуудлын талаар**

“Чиглэл хүргүүлэх тухай” Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1/1536, “Чиглэл хүргүүлэх тухай” 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/554, мөн “Тодруулга хүргүүлэх тухай” 2025 оны 02 дугаар 27-ны өдрийн 1/861 тоот албан бичгүүдээр Таны асуулгад дурдсан дараах чиглэлийг хүргүүлж ажилласан байна:

-2022 оноос сургалтын байгууллагууд гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилтын хэлбэрт шилжсэнтэй холбоотой санхүүжилт болон менежментийн хагас бие даасан тогтолцоотойгоор холбогдох хууль, журамд нийцүүлэн төсвийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах эрхийг хэрэгжүүлэх талаар;

-цалин хөлсний нэмэгдэл, нэмэгдэл хөлсний хувьд ялгаатай хэрэгжиж байсныг боловсролын салбарын нийт албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу тэгш үйлчлэх зарчмын хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэх.

Нэг хүүхдэд ногдох хувьсах зардалд үндэслэн гүйцэтгэлээр санхүүжиж байгаа тохиолдолд 2024 болон 2025 оны төсөвт нөлөөгүй гэж тооцсон бөгөөд эдгээр чиглэлийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлсэн учир нийт төсвийн зарцуулалтад өөрчлөлт гараагүй байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын багш, ажилчдын цалин хөлсөд 1.3 гаруй тэрбум, нийгмийн даатгал, эрүүл мэндийн шимтгэлд 160 орчим сая төгрөгийн зарцуулсан бөгөөд энэ нь 2024 онтой харьцуулахад өссөн дүнтэй байгаа нь дараах 2 шалтгаантай:

1.2024 оны 04 дүгээр сард төрийн албан хаагчийн цалинг 10 хувь нэмж, орон нутгийн нэмэгдлийг 20 болон 40 хувиар олгосон;

2.2025 оны 01 дүгээр сараас үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд төсвийн ерөнхийлөн захирагч батлагдсан төсөвтөө багтаан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй гэж заасны дагуу эх үүсвэр тодорхойгүй зардлыг санхүүжүүлээгүй болно.

#### **5.Багш мэргэжлээр суралцагчид олгодог тэтгэлэг болон Багшийн хөгжлийг дэмжих төвийн үйл ажиллагаа, зохион байгуулсан сургалтын талаар**

Боловсролын ерөнхий хуулийн 12.7-д "Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг төрөөс үзүүлнэ", 12.10-т "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сул орон тоонд аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ", 13.3.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батлах" гэж тус тус заасан.

Энэ хүрээнд Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 103 дугаар тогтоолын хавсралтаар “Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам” баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Журмын 2.1.1-д Боловсролын ерөнхий хуулийн 12.2-т заасан ерөнхий боловсролын сургуулийн багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч, 2.1.2-д багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч, 2.1.3-д боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч, 2.1.4-д Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.3-т заасан хөдөө орон нутагт багш мэргэжлээр дадлагажигч, 2.1.5-д Боловсролын ерөнхий хуулийн 12.10-д заасан орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш, 2.1.6-д Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан багш, ажилтны нэг хүүхэд тус тус дэмжлэгт хамрагдахаар тусгасан бөгөөд 2025 онд 5211 суралцагчид нийт 10,398,190,350 төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

-Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/164 дүгээр тушаалаар Багшийн хөгжлийг дэмжих төвийн жишиг бүтэц, орон тоог баталж, Монгол Улсын Багшийн их сургуулийг түшиглэн Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв, Монгол Улсын Багшийн их сургуулийн Архангай аймаг дахь Багшийн сургууль, Монгол Улсын Их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, Дорнод аймаг дахь салбар сургуулийг түшиглэн Багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвийг тус тус байгуулах эрх зүйн орчин бүрдсэн.

Багшийн хөгжлийг дэмжих төвийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор Кэмбрижийн багшийн мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрийн удирдагч (program leader)-аар бэлтгэх олон улсын сургалтад нийслэл, 13 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн багш, боловсролын газрын арга зүйч, мэргэжилтэн, Боловсролын ерөнхий газар, Боловсролын их сургуулийн төлөөллөөс бүрдсэн нийт 28 багш хамрагдаж, 21 нь Кембрижийн сертификатаа 2025 оны 05 дугаар сарын 02-ний өдөр гардан авсан байна.

Монгол Улсын Багшийн их сургуулийн дэргэдэх Багшийн хөгжлийг дэмжих төв анх 2025 оны 02 дугаар сараас эхэлсэн ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд зориулсан анхан шатны сургалтыг 10 дугаар сараас үргэлжлүүлэн зохион байгуулна.

Одоогийн байдлаар Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 тоот тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг зохицуулсан журам”-д заасан сургалтыг зохион байгуулах чиглэлээр сургуулиудтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус төвөөс 2025 оны 02 дугаар сарын 24-нөөс 05 дугаар сарын 30-ны өдөр хүртэл зохион байгуулсан танхимын болон цахим, хосолсон анхан шатны сургалтад ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежер, багш 692, Боловсролын газрын 87 арга зүйч, нийт 779 албан хаагч хамрагдсан байна.

## **6. Гүйцэтгэлийн үнэлгээг шинэчлэх Ажлын хэсгийн ажлын явц, үр дүнгийн талаар**

Боловсролын сайдын 2024 оны А/114 дүгээр тушаалаар хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран гүйцэтгэлийн үнэлгээний журамд өөрчлөлт оруулан, шинэчилсэн журмыг турших ажлыг 12 дугаар сарын эхний 7 хоногт нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт, 3 дахь 7 хоногт орон нутгийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгт зохион байгуулсан байна.

Туршилтаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт болон зохион байгуулалтад оруулсан өөрчлөлтүүдийн тохирц, нийцлийг шалгасан бөгөөд туршилтын үр дүнд үндэслэн зарим шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулж, зохион байгуулалтыг орон нутагт хийх, ингэхдээ үйлдвэрчний эвлэлийн оролцоог хангах зохицуулалтыг нэмж тусгасан.

Энэ өөрчлөлтийг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолд тусгаж, Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/992 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газраар хэлэлцүүлэхийг хүсэлтийг хүргүүлсэн.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Засгийн газрын хуралдаанд уг тогтоолын өөрчлөлтийг Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр товлогдсон боловч Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолын өөрчлөлттэй хамтатган оруулахаар хойшлогдсон.

Ийм учраас 2025 онд багшийн гүйцэтгэлийн үнэлгээг “Журам батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 115 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам”-ын дагуу цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2025 оны 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж, 995 цэцэрлэг, 7290 багш хамрагдсан. Ерөнхий боловсролын сургууль болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2025 оны 05 дугаар сарын 12-23-ны өдрүүдэд зохион байгуулж 700 сургууль, 29689 багш хамрагдсан.

Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг цахимаар анх удаа амжилттай зохион байгуулж, улсын хэмжээнд баг, сум, аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 600 сургууль дээр 6-12 дугаар ангийн давхардсан тоогоор 303,431 сурагч, 513,121 хүн/шалгалтыг цахимаар амжилттай зохион байгууллаа.

## **7. Харьяа байгууллагуудын удирдлагын томилгоотой холбоотой асуудлын талаар**

“Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/404 дүгээр тушаалаар Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын, “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” Боловсрол,



соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны Б/41 дүгээр тушаалаар Боловсролын үнэлгээний төвийн захирлын, Б/56 дугаар тушаалаар Боловсролын зээлийн сангийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг тус тус баталсан.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал нь доктор, түүнээс дээш боловсролын зэрэгтэй, Боловсрол судлал /0111/, багш мэргэжилтэй, боловсролын болон төрийн удирдлагаар мэргэшсэн, боловсролын салбарт 10-аас доошгүй жил, сургалт, эрдэм шинжилгээ байгууллагын хүрээлэн, төв, лаборатори бусад нэгжийн удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан, шинжлэх ухаан технологийн төсөл, суурь болон хавсарга судалгааны сэдэвт ажил, олон улсын судалгааны хамтарсан төсөл, хөтөлбөрт баг удирдаж байсан туршлагатай байх шаардлагатай.

Тус байгууллагын захирлын үүрэг гүйцэтгэгч Лхагвын Лхагвасүрэн доктор бөгөөд түүнээс дээш боловсролын зэрэгтэй, боловсролын салбарт 10-аас доошгүй жил, сургалт, эрдэм шинжилгээ байгууллагын хүрээлэн, төв, лаборатори бусад нэгжийн удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх, шинжлэх ухаан технологийн төсөл, суурь болон хавсарга судалгааны сэдэвт ажил, олон улсын судалгааны хамтарсан төсөл, хөтөлбөрт баг удирдаж байсан туршлагатай байх гэсэн шаардлагыг хангаагүй бөгөөд тухайн албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж, дүн гарч шийдвэрлэгдэх хугацаагаар түр томилогдсон.

Боловсролын үнэлгээний төвийн захирал нь магистр ба түүнээс дээш зэрэгтэй, Боловсролын шинжлэх ухаан /0111/, Боловсрол судлал /011101/, компьютерийн хэрэглээ /0611/, програм хангамж, хөгжүүлэлт ба шинжилгээ /0613/ мэргэжилтэй, мэдээллийн системээр мэргэшсэн, төрийн албанд 3-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх шаардлагатай.

Тус байгууллагын захирлын үүрэг гүйцэтгэгч Г.Гантуяа програм хангамж, хөгжүүлэлт цахим технологийн чиглэлээр бизнесийн байгууллагад олон жил ажиллаж байсан туршлагатай хэдий ч төрийн албанд 3-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх гэсэн шаардлагыг хангаагүй бөгөөд тухайн албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж дүн гарч шийдвэрлэгдэх хугацаагаар түр томилогдсон. Г.Гантуяа 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр чөлөөлөгдөх хүсэлтээ Боловсролын яаманд гаргасан тул ойрын хугацаанд албан тушаалаас нь чөлөөлнө.

Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны дарга магистр түүнээс дээш зэрэгтэй, нягтлан бодох бүртгэл /041101/, санхүү, эдийн засаг /342800/ мэргэжилтэй, санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн, мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, үнэлгээчин, татварын мэргэшсэн зөвлөх мэргэшилтэй, боловсролын салбарт 8-аас дээш жил ажилласан байх, үүнээс удирдах албан тушаалд 2-оос дээш жил ажилласан байх шаардлагатай.

Тус байгууллагын Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Сийлэгмаа албан тушаалын тодорхойлолтын шаардлагыг хангаж байгаа бөгөөд

Дэлгэрийн Гардийг албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх шийдвэр хүчингүй болох хүртэлх хугацаанд түр томилогдсон.

## **8. Сургуулийн менежментийн төслийн санхүүжилттэй холбогдох асуудлын талаар**

-Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18.7-д "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаандаа өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа, суралцагчийн хөгжил, сурлагын амжилтын чанар, үр дүнг тасралтгүй сайжруулна." гэж заасан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/01 дүгээр тушаалаар 2023 оны "Сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил болгон зарласантай холбогдуулан, "Удирдамж, багийн бүрэлдэхүүн батлах тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/49 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар "Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах арга хэмжээний удирдамж"-ийг, хоёрдугаар хавсралтаар тус удирдамжийг хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан.

Энэ Ажлын хэсэг байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, аймаг, нийслэлийн Боловсролын газрын саналд үндэслэн дэмжлэг шаардлагатай ерөнхий боловсролын сургуулиудыг сонгож, зөвлөн туслах үйл ажиллагааг 2023 онд зохион байгуулсан. Энэ үйл ажиллагаанд Баян-Өлгий аймгаас бусад аймаг тус бүрээс 2, Баян-Өлгий аймгаас 6, нийслэлээс 37, нийт 83 ерөнхий боловсролын сургууль хамрагдсан.

Эдгээр 83 сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд анализ хийж үзвэл 76 сургууль буюу 91.5% нь гүйцэтгэлийн үнэлгээний хувь ахисан, 28 сургууль буюу 33.7% нь индексийн түвшин ахисан үзүүлэлттэй гарсан байна.

Дээрх зөвлөн туслах үйл ажиллагааны явцад илэрсэн асуудал, шийдлийн хувилбар, туршлага, сургамжид үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Нийслэлийн боловсролын газар хамтран "Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмж"-ийг боловсруулж, ерөнхий боловсролын сургууль тус бүрд хүргэсэн.

Боловсролын ерөнхий газар, Азийн хөгжлийн банкны "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-тэй хамтарч сургалтын байгууллагын менежментэд арга зүйн дэмжлэг үзүүлэх мониторинг, зөвлөн туслах үйл ажиллагааг 21 аймгийн 163 сургуульд 2024 онд хэрэгжүүлсэн байна.

Эдгээр сургуулиудын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд 102 сургууль буюу 62.6% нь өмнөх оноос гүйцэтгэлийн хувь ахисан, 44 сургууль буюу 33.0% нь индексийн түвшин ахисан үр дүн гарсан байна.

Боловсролын сайдын 2024 оны А/72 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах хөтөлбөр, арга хэмжээг 2024-2025 оны

хичээлийн жилд ерөнхий боловсролын 120 сургуульд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Боловсролын ерөнхий газраас энэ үйл ажиллагаанд хамрагдах ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, сургуулийн хүсэлт болон санал /Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ний 01/4414 дугаар албан бичиг/-д үндэслэн "Жагсаалт батлах тухай" Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/136 дугаар тушаалаар сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдах ерөнхий боловсролын 120 сургуулийн жагсаалтыг батлуулсан байна.

Боловсролын ерөнхий газраас эдгээр сургуулийг нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар дүүрэг, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулиудаас санал ирүүлснээс 62 хувийг гүйцэтгэлийн үнэлгээгээр 4, 5 дугаар түвшинд үнэлэгдсэн сургуулиас сонгож, бусад сургуулийг 1, 2, 3 дугаар түвшинд үнэлэгдсэн сургуулиас төлөөлөл болгож сонгосон байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/01 дүгээр тушаал, А/49 дүгээр тушаалын хүрээнд зохион байгуулсан ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг үргэлжүүлэн, хамрах хүрээг өргөтгөн зохион байгуулах үүднээс Боловсролын сайдын 2024 оны А/72, А/136 дугаар тушаалын тус тус батлан хэрэгжүүлж Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/14 дугаар тушаал, Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/18 дугаар тушаалын дагуу дараах байдлаар зарцуулсан:

1. сургалт зохион байгуулах 193,917.0 сая төгрөг;
2. зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх - 22,012.0 сая төгрөг;
3. эцэг эхийн хурал зохион байгуулах 12,662.0 сая төгрөг;
4. мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах 771,409.0 сая төгрөг.

-Сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жилийн хүрээнд авч хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулалт, удирдлагаар хангаж хэрэгжүүлэх байгууллага нь Боловсролын ерөнхий газар бөгөөд тус газраас Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/101 дугаар тушаал, Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/276 дугаар тушаалыг үндэслэн 800,000.0 сая төгрөгийг 6 аймаг болон нийслэлийн 80 ерөнхий боловсролын сургуульд 2024 оны 12 дугаар сард шилжүүлсэн байна.

Сургуулиуд тус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан менежментийг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

**9. Дээд боловсролын тухай хуулийн 6.2 дахь хэсгийг хангуулах асуудлын талаар**

Дээд боловсролын тухай хуулийн 6.2-т “Монгол Улсын” болон “Үндэсний” гэсэн үг, түүний англи хэл дээрх орчуулга, барааны тэмдгийг зөвхөн төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад хэрэглэнэ” гэж заасан байдаг.

Уг зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор дээд боловсролын сургалтын байгууллагуудад салбарын сайдын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 1а/3963 тоот албан бичгийг хүргүүлж ажилласан байна.

Дээд боловсролын байгууллагын ангиллыг тогтоох чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу Үндэсний биеийн тамирын дээд сургууль, Эдийн засгийн үндэсний их сургууль, Эм Ай Ю дээд сургуульд дээрх хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мэдэгдсэн болно.

#### **10. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох асуудлын талаар**

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Боловсролын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, мөн Дээд боловсролын тухай хуулийн 6.1-д заасны дагуу дээд сургуулийг их сургууль эсхүл, коллеж болгон шилжүүлэх үйл ажиллагааг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар хуульчилсны дагуу Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж, дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тогтоох ажлыг зохион байгуулсан.

Ажлын хэсэг нийт 34 дээд боловсролын байгууллагын ангиллыг шинэчлэн тогтоох дүгнэлт гаргасан бөгөөд уг дүгнэлтийг Дээд боловсролын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Боловсролын сайдын тушаалаар 10 сургуулийг мэргэжлийн сургуулийн ангилалд, 22 сургуулийг коллежийн ангилалд тус тус хамааруулахаар шийдвэр гарсан.

Ажлын хэсэг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийг “ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь салбар сургууль” болгон, Чингис хаан дээд сургуулийг “Монгол-Хятадын хамтарсан Олон улсын дээд сургуулийн бүрэлдэхүүн сургууль” болгож өөрчлөх дүгнэлт санал гаргасан.

#### **11. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох асуудал олон нийтэд танилцуулсан, мэдээлсэн байдлын талаар**

Дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг шинэчлэн тогтоох ажил нь холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 оны 06 дугаар сард албан ёсоор дууссан.

Гэвч зарим сургуулиуд Ажлын хэсгийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, маргаантай байр суурь илэрхийлсэн бөгөөд уг үйл явц элсэлтийн ерөнхий шалгалт болон их, дээд сургуулиудын элсэлтийн үе шаттай давхацсан тул олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулах боломж хязгаарлагдсан.

Иймд нэгдсэн сурталчилгааг сургалтын байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр, зохих шат дараатайгаар үе шаттайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

## **12. Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэтэй холбогдох асуудлын талаар**

Дээд боловсролын тухай хуулийн 12.9-д "Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран 2 жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ." гэж хуульчилсны дагуу төрийн болон төрийн өмчийн их, дээд сургуулийн төлөөлөл бүхий Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн "Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/240 дүгээр тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын шалгуур үзүүлэлт, сургалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болон тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд их, дээд сургуулийн үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тус тус баталсан.

Боловсролын яамны харьяа Боловсролын үнэлгээний төвөөс дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг 2023 оны 06-08 дугаар сард зохион байгуулж, Боловсролын чанарын судалгааны хүрээлэнгээс арга зүйн зөвлөгөө авч их, дээд сургуулийн үндэсний эрэмбэ, чансааг анх удаа урьдчилсан байдлаар тогтоож 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр олон нийтэд нээлттэй зарласан.

Улмаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх Ажлын хэсэг байгуулж 2024 оны 02 дугаар сарын 25-наас 04 дүгээр сарын 22-ны өдрүүдэд их, дээд сургуулиуд дээр ажиллаж, байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хянан баталгаажуулсан.

"Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/343 дугаар тушаалаар Боловсролын үнэлгээний төв дээд боловсролын сургалтын байгууллагаас шалгуурын дагуу өгөгдөл мэдээллийг цуглуулсан.

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ, үндэсний эрэмбийг эцэслэн тогтоох үйл ажиллагааг зохион байгуулж, тайланг Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/347 тоот албан бичгээр Дээд боловсролын чанарын үнэлгээний тайланг ирүүлсэн (Тайланг хавсаргав).

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ, үндэсний эрэмбийг танилцуулах хурлыг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Боловсролын яамны 400 тоот танхимд зохион байгуулсан.

## **13. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбийн үнэлгээний "сургалт" хэсэгт 50-аас дээш хувийн үнэлгээ авсан сургалтын байгууллагад суралцагчид олгосон санхүүжилтийн талаар**

Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу 2024 онд журмын 4.5.3-т заасан шалгуурыг хангасан 285 суралцагчид нийт 1.8 тэрбум төгрөгийн Засгийн газрын тэтгэлэг, 6.2.3-т заасан шалгуурыг хангасан 929 хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид нийт 2.04 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж, 7.3.3-т заасан шалгуурыг хангасан 3504 зарим эрэлттэй мэргэжлээр суралцагчид нийт 6.2 тэрбум төгрөгийн тэтгэлэг, 8.4.3-т заасан шалгуурыг хангасан 4 856 зорилтот бүлгийн суралцагчид нийт 14.0 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж, мөн 10.3.3-т заасан шалгуурыг хангасан дотоодын сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр суралцаж буй 2108 суралцагчид нийт 4.3 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Үндэсний Аудитын газраас тус санд “Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн шалгалт одоогоор хийгдэж байгаа бөгөөд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4.1.7-д “хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх” гэж заасан холбогдох байгууллагын шалгалттай зэрэгцэн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж болохгүй байгаа тул тус зээл, тэтгэлэг журмын дагуу хийгдсэн эсэхийг шалгаж, тайлбар мэдээлэл өгөх боломжгүй байгаа болно.

Аудитын дүгнэлт болон журмын хэрэгжилтэд хяналт хийсний дараагаар Танд дүгнэлт холбогдох материалыг гарган хүргүүлье.

#### **14. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлттэй холбогдох асуудлын талаар**

Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлэх журмыг баримтлан 2024-2025 оны хичээлийн жилд 5.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Боловсролын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тогтмол зардлын зарцуулалтад хяналт шалгалт хараахан хийгээгүй байгаа тул 2025 оны 3, 4 дүгээр улиралд хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнгийн тайланг Танд хүргүүлэх болно.

---oOo---



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/101


Улаанбаатар хот

Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.10 дахь хэсэг, Засгийн газрын "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 176 дугаар тогтоол, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэлийн 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 152 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтэд тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх, тохирцыг шалгах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2030 он)-г хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн "Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" А/101 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



САЙД

П.НАРАНБАЯР

Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 02-ны өдрийн /2025/ тушаалын хавсралт

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх, турших, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, 2025-2030 он

Түвшин, анги, бүлэг	Он Сар	2025												2026												2027												2028												2029-2030											
		I-IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII															
Сургуулийн өмнөх боловсрол	Бага	Сургалтын хөтөлбөрийг нийт цэцэрлэгт хэрэгжүүлэх																																																											
	Дунд	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тусгах																																																											
	Ахлах	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтын хэрэглэгдэхүүн, тогтосмоор хангах																																																											
	Бэлтгэл	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтын хэрэглэгдэхүүн, тогтосмоор хангах																																																											
Багш, удирдах ажилтны сургалт	Сургалтын багц бэлтгэх	Багш хөгжлийн төвөөр дамжуулан ажлын байранд нь сургах, дэмжлэг үзүүлэх																																																											
Бага боловсрол	I	Сургалтын хөтөлбөрийг ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлэх																																																											
	II	Унэлгээ хийх, үр дүнг тусгах																																																											
	III	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, лабораториор хангах																																																											
	IV	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, лабораториор хангах																																																											
Багш, удирдах ажилтны сургалт	Сургалтын багц бэлтгэх	Багш хөгжлийн төвөөр дамжуулан ажлын байранд нь сургах, дэмжлэг үзүүлэх																																																											
Суурь боловсрол	V	Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, турших, батлуулах																																																											
	VI	Сургах бичиг, багшийн номын бх зохиох, санал, дүгнэлт гаргуулах, турших, хэлэлцүүлэх, эцэслэн боловсруулах, хэвлэх түүгээх																																																											
	VII	Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, турших, батлуулах																																																											
	VIII	Сургах бичиг, багшийн номын эх зохиох, санал, дүгнэлт гаргуулах, турших, хэлэлцүүлэх, эцэслэн боловсруулах, хэвлэх түүгээх																																																											
Багш, удирдах ажилтны сургалт	Сургалтын багц бэлтгэх	Багш хөгжлийн төвөөр дамжуулан ажлын байранд нь сургах, дэмжлэг үзүүлэх																																																											
Бүрэн дунд боловсрол	IX	Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, турших, батлуулах																																																											
	X	Сургах бичиг, багшийн номын эх зохиох, санал, дүгнэлт гаргуулах, турших, хэлэлцүүлэх, эцэслэн боловсруулах, хэвлэх түүгээх																																																											
	XI	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, турших, батлуулах																																																											
	XII	Сургах бичиг, багшийн номын эх зохиох, санал, дүгнэлт гаргуулах, турших, хэлэлцүүлэх, эцэслэн боловсруулах, хэвлэх түүгээх																																																											
Багш, удирдах ажилтны сургалт	Сургалтын багц бэлтгэх	Багш хөгжлийн төвөөр дамжуулан ажлын байранд нь сургах, дэмжлэг үзүүлэх																																																											
Бүрэн дунд боловсрол	X	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, турших, батлуулах																																																											
	XI	Сургах бичиг, багшийн номын эх зохиох, санал, дүгнэлт гаргуулах, турших, хэлэлцүүлэх, эцэслэн боловсруулах, хэвлэх түүгээх																																																											
	XII	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, турших, батлуулах																																																											
	Багш, удирдах ажилтны сургалт	Сургалтын багц бэлтгэх	Багш хөгжлийн төвөөр дамжуулан ажлын байранд нь сургах, дэмжлэг үзүүлэх																																																										





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Ерөнхий боловсролын сургуулийн  
бага ангийн туршилтын сургалтын  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны "Үзэл баримтлал батлах тухай" 176 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, турших явцад түшиц сургуульд мөрдөх Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн туршилтын сургалтын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу бага ангийн сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичиг, дасгал ажлын дэвтрийг туршин тохирцыг шалгах, сайжруулах үйл ажиллагааг түшиц сургуулиудыг сонгон зохион байгуулах, сургууль зохицуулах цагт Эрүүл мэндийн агуулга бүхий модуль боловсруулж туршихыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (М.Итгэл)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын газарт, туршилтын сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, туршилт зохион байгуулах түшиц сургуулийн багш нарт нэмэгдэл хөлс тооцож олгох тооцооллыг хийж 2024 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх, 2025 оноос эхлэн улсын төсөвт тусгаж, санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж ажиллахыг Хяналт, шинжилгээ, дотоод, аудитын газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

САЙД

П.НАРАНБАЯР

14241 0193

Боловсролын сайдын  
2024 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн  
А/СЗ дугаар тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГА АНГИЙН  
ТУРШИЛТЫН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Суралцахуйн хүрээ	Хичээлийн нэр	Хичээлийн цаг					Нийт цаг
			I анги	II анги	III анги	IV анги	V анги	
1	Монгол хэл	Монгол хэл	224	224	231	231	231	1141
2	Математик	Математик	160	160	165	165	165	815
3	Байгалийн ухаан	Түмэн бодис	32	32	66	66	66	262
4	Нийгмийн ухаан	Би Монгол хүн	64	64				128
		Миний эх орон			66	66	66	198
5	Урлаг	Хөгжим	64	64	66	66	66	326
		Зураг, урлал	64	64	66	66	66	326
6	Технологи, ICT	Компьютерийн ухаан	32	32	66	66	66	262
7	Эрүүл мэнд, биеийн тамир	Биеийн тамир, эрүүл мэнд	64	64	66	66	66	326
8	Гадаад хэл	Англи хэл			66	66	99	231
9	Сургууль зохицуулах цаг	Хүүхдийн хөгжлийн цаг	32	32	33	33	33	163
		Жилийн нийт цаг	736	736	891	891	924	4178
		Долоо хоногийн дундаж цаг	23	23	27	27	28	
		Өдрийн дундаж цаг	4.6	4.6	5.4	5.4	5.6	
		Хичээлийн тоо	8	8	9	9	9	

Тайлбар:

1. Энэхүү сургалтын төлөвлөгөөг түшиц ерөнхий боловсролын сургуулийн туршилтад хамрагдаж буй анги, бүлэгт хэрэгжүүлнэ.
2. Хүүхдийн хөгжлийн цагт суралцагчийн бие даан суралцах, хамтран ажиллах, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварыг хөгжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, үйл ажиллагааг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр зохион байгуулна.



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/317


Урьанбаатар хот

Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4 дэх хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.10 дахь хэсэг, Засгийн газрын "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 176 дугаар тогтоол, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 56 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх, тохирцыг шалгах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2030 он)-г хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Төлөвлөгөө, зардал батлах тухай" 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/317 дугаар тушаалын 2 дахь заалт болон нэгдүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



П.НАРАНБЕЯР

Боловсролын сайдын 2025 оны 25 сарын  
13-ний өдрийн тушаалын хавсралт

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх, тохирцыг шалгах,  
хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, 2025-2030 он

Түвшин	Анги	2025					2026					2027					2028			2029-2030
		III	IV	V	VI-VIII	IX	X-XII	I-II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X-XII	I-VI	VII-VIII	IX-XII	
Бурал дунд боловсрол	12											Сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном шинэчлэх		Сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном турших, хэлэлцүүлэх, эцэслэн боловсруулах, хэвлэх, түгээх			Ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлэх			
	11																			
	10																			
	Сургалт	Багш, удирдах ажилтны сургалт, шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх																		
Сүүрх боловсрол	9			Сургалтын хөтөлбөр шинэчлэх		Сурах бичиг, багшийн ном боловсруулах		Сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном турших, хэлэлцүүлэх, эцэслэн боловсруулах, хэвлэх, түгээх			Ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлж эхлэх									
	8																			
	7																			
	6																			
Сургалт					Багш, удирдах ажилтны сургалт, шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх															
Бага боловсрол	5			Сургалтын хөтөлбөр эцэслэн боловсруулах		Сурах бичиг, багшийн ном боловсруулах, турших, хэлэлцүүлэх, үр дүнг тусгах, хэвлэх, түгээх		Ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлж эхлэх												
	4																			
	3																			
	Сургалт					Багш, удирдах ажилтны сургалт зохион байгуулах														
	2			Сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном турших, хэлэлцүүлэх, эцэслэн боловсруулах, хэвлэх, түгээх		Ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлж эхлэх														
Сургалт					Багш, удирдах ажилтны сургалт зохион байгуулах															
Сургуулийн өмнөх боловсрол	Бэлтгэл бүлэг			Сургалтын хөтөлбөр, багшийн ном, дадлага ажлын дэвтэр турших, хэлэлцүүлэх, эцэслэн боловсруулах, хэвлэх, түгээх		Нийт цэцэрлэгт хэрэгжүүлж эхлэх														
	Ахлах бүлэг																			
	Дунд бүлэг																			
	Бага бүлэг																			
	Сургалт					Багш, удирдах ажилтны сургалт зохион байгуулах														



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/049

Улаанбаатар хот

Заавар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.24 дэх заалт, Засгийн газрын 2024 оны "Хувьсах зардлын дундаж хэмжээ, журам батлах тухай" 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны "Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай" 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал төлөвлөх, хуваарилах зааврыг нэгдүгээр, цахим хэрэглээний зардал төлөвлөх, хуваарилах зааврыг хоёрдугаар, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх зааврыг гуравдугаар, хүүхэд хамгааллын зардал төлөвлөх, хуваарилах зааврыг дөрөвдүгээр, багшийн тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагаа, сургалтын зардлын санхүүжилт, түүнийг зарцуулах зааврыг тавдугаар, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах зааврыг зургаадугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг)-т, сургалтын байгууллагын санхүүжилтийг холбогдох дүрэм, журмын хүрээнд хуваарилан хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170, А/259 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

П.НАРАНБАЯР





МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот

Төвийн нэгжийн бүтэц, орон тоо батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.11, 12.13 дахь хэсэг, Багшийн хөгжлийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн "Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 326 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багшийн мэргэжлийн хөгжлийн сургалт, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд холбогдох талуудтай хамтран зохион байгуулах чиг үүрэг бүхий Багшийн хөгжлийн дэмжих үндэсний төвийн нэгжийг Монгол Улсын Боловсролын их сургуулийг түшиглэн 2024 оны II дугаар улиралд багтаан байгуулахыг Монгол Улсын Боловсролын их сургууль (Ж.Батбаатар)-д, Багшийн хөгжлийн орон нутаг дахь бүсийн төвийн нэгжийг Монгол Улсын Боловсролын их сургуулийн Архангай аймаг дахь Багшийн сургууль, Монгол Улсын Их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, Монгол Улсын Их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургуулийг тус тус түшиглэн 2024 оны III дугаар улиралд багтаан байгуулж ажиллахыг Монгол Улсын Боловсролын их сургууль (Ж.Батбаатар), Монгол Улсын Их сургууль (Д.Бадарч)-д үүрэг болгосугай.

2. "Багшийн хөгжлийг дэмжих төвийн нэгжийн бүтэц, орон тоо"-г хавсралтаар баталсугай.

3. Багшийн хөгжлийг дэмжих төвийн үл ажиллагааны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, нийслэл, дүүргийн Боловсролын газар, хэлтэс, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газруудад тус тус үүрэг болгосугай.

4. Багшийн хөгжлийг дэмжих үндэсний болон орон нутаг дахь бүсийн төвийн үйл ажиллагааны зардлыг 2024 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийж, мөн 2025 оны төсөвт тусгаж санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг)-т даалгасугай.

САЙД

Л. ЭНХ-АМГАЛАН

14241 0553

**БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨВИЙН ЖИШИГ БҮТЭЦ, ОРОН ТОО**

Нэг. Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвийн жишиг бүтэц, орон тоо

№	Албан тушаал	Орон тоо	Үүнээс:
1.	Эрхлэгч	1	Үндсэн
2.	Багшийн сургалт, арга зүй хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
3.	Боловсролын удирдлагын манлайллын сургалт, арга зүй хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
4.	Багш, удирдах ажилтны магистрын хөтөлбөр хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
5.	Сургуулийн өмнөх, бага боловсролын судалгаа, арга зүй хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
6.	Суурь боловсролын судалгаа, арга зүй хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
7.	Судлагдахууны зөвлөх багш	9	Үндсэн 2, болон гэрээт 7
8.	Төвийн зохицуулагч	1	Үндсэн
9.	Сургалтын контент, цахим сан, хэрэглэгдэхүүн хариуцсан мэргэжилтэн	1	
	НИИТ	17	

Хоёр. Багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвийн жишиг бүтэц, орон тоо

№	Албан тушаал	Орон тоо	Үүнээс:
10.	Эрхлэгч	1	Үндсэн
11.	Багшийн сургалт, арга зүй хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
12.	Боловсролын удирдлагын манлайллын сургалт, арга зүй хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
13.	Багш, удирдах ажилтны магистрын хөтөлбөр хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
14.	Сургуулийн өмнөх, бага боловсролын судалгаа, арга зүй хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
15.	Суурь боловсролын судалгаа, арга зүй хариуцсан хөтөлбөрийн зохицуулагч	1	Үндсэн
	НИИТ	6	

Гурав. Боловсролын сургалтын байгууллагын  
Багшийн хөгжлийн төвийн жишиг бүтэц, орон тоо

№	Албан тушаал (хавсран гүйцэтгэх)	Орон тоо
1.	Багшийн хөгжил хариуцсан сургалтын менежер/ арга зүйч буюу мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрийн зохицуулагч	1
2.	Заах аргын нэгдлийн ахлагч	тоогоор

3.	Мэргэжлийн бүлгийн ахлагч	тоогоор
4.	Анги нэгдлийн бүлгийн ахлагч	тоогоор
5.	Ментор багш	тоогоор
6.	Зөвлөх багш	тоогоор

--oOo--





МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журмыг нэгдүгээр, Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа болон мэргэжил дээшлүүлэх сургалтад улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган, батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг)-т, хувьсах зардлыг санхүүжүүлэх зааварт үндэслэн төсвийн хуваарилалтыг цаг тухай бүрт хийж, гүйцэтгэл гаргах боломжоор ханган хяналт тавьж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нар тус тус даалгасугай.

4. Журмын хэрэгжилтэд 2 жил тутамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

САЙД

Т.НАРАНБАЯР



Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
БАГШ, АЖИЛТНЫ МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмаар хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль /цаашид "цэцэрлэг, сургууль" гэх/-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагаа нь тэдний хөгжих хэрэгцээнд суурилсан, тэгш хүртээмжтэй, практик хэрэглээтэй, уян хатан, талуудын хамтын оролцоо, түншлэлд тулгуурласан байна.

1.3. Мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагаа нь багш, ажилтан албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэнэ.

1.4. Энэ журмын 1.3-д заасан сургалт, үйл ажиллагаанд цэцэрлэг, сургуульд ажиллаж байгаа доор дурдсан албан тушаалтан хамрагдана:

1.4.1. багшийн албан тушаалд ажиллаж байгаа багш /цаашид "багш" гэх/;

1.4.2. цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн захирал, сургалтын менежер /цаашид "удирдах ажилтан" гэх/;

1.4.3. нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрын багш, эмч, номын санч, хоол зүйч, багшийн туслах, тогооч /цаашид "ажилтан" гэх/.

**Хоёр. Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих  
сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт**

2.1. Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа нь багшийг дадлагажуулах болон мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаа гэсэн 2 хэлбэртэй байна.

2.2. Багшийг дадлагажуулах үйл ажиллагаа нь цэцэрлэг, сургуульд ажиллаж байгаа багшийг багшлах ажилд дагалдуулан сургах, зөвлөн туслахад чиглэсэн нэг хичээлийн жилийн турш хэрэгжүүлэх ажил байна.

2.2.1. Багшийг дадлагажуулах үйл ажиллагаа нь багшлах онол, арга зүйн мэдлэг, чадварыг дэмжих, сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх, эргэцүүлэн дүгнэлт хийхэд дэмжлэг үзүүлэх агуулга бүхий цогц хөтөлбөртэй байна.

2.2.2. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь багшийг дадлагажуулах үйл ажиллагааны жишиг хөтөлбөрийг энэ журмын 2.2.1-т заасан агуулгын хүрээнд боловсруулж, батална. Жишиг хөтөлбөр боловсруулахад багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв болон холбогдох мэргэжлийн холбооны оролцоог тэгш хангана.

*Тайлбар: Боловсролын ерөнхий хуулийн 12.13-д заасан нэгж гэдэгт "Багшийн хөгжлийг дэмжих үндэсний/бүсийн төв"-ийг хамааруулна.*

2.2.3. Цэцэрлэг, сургуульд анхны жилдээ ажиллаж байгаа багш болон Боловсролын ерөнхий хуулийн 12.16-д заасан дагалдан багш энэ журмын 2.2-д заасан үйл ажиллагаанд хамрагдана.

2.2.4. Багшийн чадамжийн стандартад хүрсэн түвшин, ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан 2, 3 дахь жилдээ ажиллаж байгаа болон сүүлийн 5-аас доошгүй жил багшаар ажиллаагүй багшийг энэ журмын 2.2-д заасан үйл ажиллагаанд тус тус хамруулж болно.

2.2.5.Багшийг дадлагажуулах үйл ажиллагааг тухайн цэцэрлэг, сургуульд ажиллаж байгаа, мэргэжлийн мэдлэг, багшлах ур чадвараараа бусдыг манлайлан ажилладаг багш, мэргэжлийн багш нарын бүлгийн ахлагч, эсхүл арга зүйч, сургалтын менежер /цаашид "чиглүүлэгч багш" гэх/ удирдан чиглүүлнэ. Чиглүүлэгч нэг багшид 3-аас илүүгүй багш дадлагажуулахаар тооцно.

2.2.6.Энэ журмын 2.2.1-д заасан цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавх бүхий, тогтоосон хуваарийн дагуу ажиллах боломжтой, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон багшийг чиглүүлэгч багшаар ажиллуулж болно.

2.2.7.Чиглүүлэгч багшийг мэргэжлийн багш нарын бүлгээс санал болгож, тухайн цэцэрлэг, сургуулийн багш нарын зөвлөлийн хурлаар нээлттэй хэлэлцэж, журмын 2.2.11-д заасан эрхлэгч, захирал томилж ажиллуулна.

2.2.8.Чиглүүлэгч багшийг арга зүйгээр хангах ажлыг аймаг, нийслэлийн боловсролын газар багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвтэй хамтран төлөвлөж зохион байгуулна.

2.2.9.Энэ журмын 2.2.3, 2.2.4-т заасан үйл ажиллагаанд хамрагдаж байгаа багш, чиглүүлэгч багшийн ажлын ачааллыг багшийн ажлын норм, нормативтай уялдуулан зохицуулна. Дадлагажуулах хөтөлбөрт хамрагдаж байгаа багш мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаанд хамрагдана.

2.2.10.Чиглүүлэгч багш нь ажлын үр дүнгээ улирал тутам мэргэжлийн багш нарын бүлэгт, арга зүйч, сургалтын менежер чиглүүлэгч багш нарын ажлын үр дүнг нэгтгэн хичээлийн жилийн төгсгөлд багш нарын зөвлөлийн хуралд тус тус танилцуулна.

2.2.11.Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь чиглүүлэгч багштай гэрээ байгуулан ажиллах бөгөөд дадлагажигч багшийн тоо, дадлагажуулах үйл ажиллагааны чанар, үр дүнгээс хамааруулан чиглүүлэгч багшид үндсэн цалингийн 10-20 хувьтай тэнцэх урамшууллыг сар бүр тооцож, улирал тутам олгоно.

2.2.12.Багш дадлагажуулах үйл ажиллагаанд хамрагдсан нь түүний ажилласан жил, нэмэгдэл, нэмэгдэл хөлс бууруулах үндэслэл болохгүй, багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд нөлөөлөхгүй.

2.3. Мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаа нь багшлахуй, суралцахуйд тулгамдаж байгаа асуудлыг хамтран шийдэх, харилцан туршлага солилцох, хамтран суралцах, сургалтад шаардлагатай нэмэлт хэрэглэгдэхүүн бэлтгэж хэрэглэх, явцын үнэлгээ хийх замаар мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлж, суралцахуйн үр дүнг сайжруулахад чиглэнэ.

*Тайлбар: Энэ журмын 2.3-д заасан мэргэжлийн багш нарын бүлэг нь багшлахуй, суралцахуйд тулгамдаж байгаа асуудлыг нотолгоонд суурилан илрүүлж шинжлэн судлах, шийдлийг хамтдаа эрэлхийлэн ярилцах, шийдлийн хувилбар, багшлах, суралцах үйл ажиллагаанд гарч байгаа ахиц, өөрчлөлт, үр дүнг бусадтай хуваалцах замаар тасралтгүй суралцах багш нарын нэгдэл, харилцан бие биеэсээ суралцах талбар байна.*

2.4.Энэ журмын 2.3-т заасан үйл ажиллагааг сургалтын байгууллага болон орон нутгийн түвшинд зохион байгуулна.

2.5.Цэцэрлэг, сургуулийн түвшинд мэргэжлийн багш нарын бүлгийг багш нарын саналд үндэслэн байгуулах бөгөөд нэг бүлэгт 5-10 багш хамрагдана. Бүлгийн ахлагчийг гишүүд сонгоно.

2.5.1. Мэргэжлийн багш нарын бүлэгт тухайн цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрын багш хамрагдаж болно.

2.5.2.Тухайн цэцэрлэг, сургуулийн багш, удирдах ажилтны тоо 5-аас цөөн байх тохиолдолд нэг мэргэжлийн багш нарын бүлэг ажиллах, эсхүл цэцэрлэг, сургууль дундын бүлэг үүсгэн ажиллаж болно.

2.6.Сургалтын байгууллагын түвшинд мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааг тухайн цэцэрлэг, сургуулийн багшийн хөгжлийн төв удирдан чиглүүлнэ.

2.6.1. Мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааг энэ журмын 2.3-т заасан чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.6.2. Энэ журмын 2.6-д заасан төв болон мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаанд тухайн цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллана.

2.7. Багш дадлагажуулах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас баталсан "Багшийн ажлын норм, норматив"-т заасан тэдний мэргэжлийн хөгжлийг дэмжихэд зориулсан цагаас 7 хоногт 4 хүртэлх цагт багтаан зохион байгуулна.

2.8. Аймаг, нийслэлийн боловсролын газар/хэлтэс нь орон нутгийн түвшинд цэцэрлэг, сургуулийн байршил, багш, ажилтны ажилласан жилээс үл хамааран тэгш хамруулан сургах арга зүй, цэцэрлэг, бага анги, судлагдахууны чиглэлээр болон дотуур байрын багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн мэргэжлийн бүлгийг үүсгэн, энэ журмын 2.3-т заасан үйл ажиллагаа, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр онол арга зүйн сургалт, үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар төлөвлөн багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвтэй хамтран зохион байгуулна.

2.8.1. Сургалт, үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, багшид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн захирал, сургалтын менежерийн мэргэжлийн бүлгийг тухайн аймаг, нийслэлийн боловсролын газар/хэлтэс үүсгэн ажиллуулна.

2.9. Энэ журмын 1.4.2, 1.4.3-д заасан албан тушаалтны ажил үүргээс хамаарсан мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн боловсролын газар, үндэсний түвшинд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус зохион байгуулна.

2.9.1. Энэ журмын 2.9-д заасан албан тушаалтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад холбогдох их, дээд сургууль, мэргэжлийн байгууллага, тухайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж болно.

2.10. Энэ журмын 2.3, 2.8, 2.9-д заасан сургалт, үйл ажиллагааг танхимын, цахим болон эдгээрийн хосолсон хэлбэрээр, онол-дадлага хослуулан зохион байгуулна.

2.11. Багш бүр энэ журмын 2.5, 2.8-д заасан бүлгийн үйл ажиллагаанд заавал хамрагдах бөгөөд энэ үйл ажиллагаанд хамрагдсанаар гарсан ахиц, өөрчлөлт, үр дүнгийн талаарх дүгнэлт, үр нөлөөг мэргэжлийн багш нарын бүлэгт улирал тутам тайлагнана.

2.12. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18.5-д заасан цэцэрлэг, сургууль нь журмын 2.3-д заасан үйл ажиллагаанаас гадна бусад цэцэрлэг, сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжлийн бүлгийн үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. Энэ ажлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

2.13. Энэ журмын 2.9-д заасан сургалт, үйл ажиллагааны агуулга, зохион байгуулах хуваарийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жил бүрийн 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Боловсролын ерөнхий хуулийн 12.12-т заасан цахим системд нээлттэй байршуулна.

2.13.1. Сургалт, үйл ажиллагааны агуулга нь хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцүүлэн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, мэргэшүүлэхэд чиглэсэн байна.

2.13.2. Сургалт, үйл ажиллагаа нь онол, дадлага ажлын чиглүүлэг/удирдамжийн дагуу хамтран суралцах, ажлын байранд хэрэгжүүлэх, эргэцүүлэн дүгнэх үе шаттай байх бөгөөд цэцэрлэг, сургууль, орон нутаг, үндэсний түвшинд шатлан гүнзгийрсэн агуулгатай байна.

2.14. Журмын 2.8, 2.9-д заасан сургалт, үйл ажиллагааг зохион байгуулагч нь оролцогчдын мэдлэг, чадварын түвшнийг сургалт, үйл ажиллагааны өмнө болон дараа үнэлж, ахицыг тооцон энэ журмын 2.13-д заасан цахим системд бүртгэх бөгөөд ажлын байранд хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн боловсролын газар удирдлага, арга зүйгээр хангана.

2.15. Аймаг, нийслэлийн боловсролын газар энэ журмын 2.13-д заасан хуваарьт үндэслэн орон нутгийн түвшинд зохион байгуулах сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийг агуулгын хамт хуваарь байршуулснаас хойш 10 хоногийн дотор цэцэрлэг, сургууль бүрд хүргэж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

2.16. Цэцэрлэг, сургуулийн багшийн хөгжлийн төв нь мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөөг багш нарын хөгжих хэрэгцээ, саналд үндэслэн энэ журмын 2.13-д заасан хуваарь, 2.15-д заасан төлөвлөлттэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.

2.17. Энэ журмын 2.6-д заасан багшийн хөгжлийн төв нь багшийг дадлагажуулах болон мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаа, түүний үр дүнг байгууллагын түвшинд нэгтгэн хянаж, үр дүнг сургалтын чанарт гарсан ахицыг баталгаажуулан журмын 2.13-т заасан цахим системд бүртгэнэ.

2.18. Орон нутгийн түвшний мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааны хэрэгжилтэд аймаг, нийслэлийн боловсролын газар/хэлтсийн тухайн асуудал хариуцсан албан хаагч хяналт тавьж, ахиц, үр дүнг баталгаажуулан энэ журмын 2.13-т заасан цахим системд бүртгэнэ.

2.18.1. Журмын 2.18-д заасан ахиц, үр дүнг нь мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааг төлөвлөх үндэслэл болно.

2.19. Багшийн хөгжлийг дэмжих үндэсний болон бүсийн төв нь журмын 2.6-д заасан төвийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, төв хариуцсан ажилтан, чиглүүлэгч багшид зөвлөн туслах, бүсийн түвшинд бий болсон сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг аймаг, нийслэлийн боловсролын газартай хамтран зохион байгуулна.

2.20. Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв нь энэ журмын 2.1-д заасан сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтэд шинжилгээ хийх, аймаг, нийслэлийн боловсролын газар болон журмын 2.19-д заасан бүсийн төвийг чадавхжуулах, арга зүйн удирдлагаар хангах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулна.

2.21. Үндэсний болон орон нутгийн түвшний сургалтыг энэ журмын 2.13-д заасан цахим системээр зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд цахим систем нь нээлттэй, үнэ төлбөргүй байна.

### **Гурав. Сургалт, үйл ажиллагааны санхүүжилт**

3.1. Энэ журмын 2.1-д заасан сургалт, үйл ажиллагааны зардлыг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын "Багшийн хөгжлийн зардал"-аас санхүүжүүлнэ.

3.2. Цэцэрлэг, сургуулийн жилийн төсөвт холбогдох хууль тогтоомжийн дагуу батлагдсан багшийн хөгжлийн нийт зардлын 50.0 хувийг энэ журмын 2.1-д заасан сургалт, үйл ажиллагаанд зарцуулна. Энэ зардалд энэ журмын 2.2.11-д заасан урамшууллын зардал хамаарна.

3.3. Энэхүү журмын 2.1, 2.8, 2.9-д заасан сургалт, үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс нэмэлтээр санхүүжүүлж болно.

### **Дөрөв. Бусад**

4.1. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь энэ журмын хэрэгжилтийн тайланг орон нутгийн хэмжээнд нэгтгэж, жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.


4.2. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь багш бүрийн мэргэжлийн хөгжлийн байдал, ажлын гүйцэтгэл болон сургалтын чанарын ахицыг мөшгөх судалгаа хийж, шаардлагатай дэмжлэг, зөвлөн туслах үйл ажиллагааг багшийн хөгжлийг дэмжих төв, орон нутгийн боловсролын газартай хамтран хэрэгжүүлнэ.

4.3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 4.1-д заасан тайланг үндэсний хэмжээнд нэгтгэн дүн шинжилгээ хийж дүгнэлт гарган, цаашид авах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ.

4.4. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны чанарт үнэлгээ өгч, сургалтын үр нөлөөг сайжруулах саналыг тухайн онд багтаан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.5. Хөдөлмөрийн тухай хуульд заасан долоо хоног бүрийн нийтээр амрах өдрүүдэд сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу оролцогчдод олгох нэмэгдэл хөлсийг сургалт зохион байгуулагч тал хариуцна.

Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 125 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль /цаашид "цэцэрлэг, сургууль" гэх/-ийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт /цаашид "мэргэжил дээшлүүлэх сургалт" гэх/ нь боловсролын хөгжлийн чиг хандлагад нийцсэн, багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээ, чадамжийн стандартад суурилсан, тэгш хүртээмжтэй, сонголттой, уян хатан, талуудын хамтын оролцоо, хариуцлага, түншлэлд тулгуурласан, үр ашигтай байна.

1.3. Мэргэжил дээшлүүлэх сургалт нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, суралцагчийн хөгжлийг дэмжихэд багш, удирдах ажилтанд шаардагдах мэдлэг, үр чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.

1.4. Мэргэжил дээшлүүлэх сургалтад цэцэрлэг, сургуулийн багш /цаашид "багш" гэх/, цэцэрлэгийн арга зүйч, эрхлэгч, сургуулийн сургалтын менежер, захирал /цаашид "удирдах ажилтан" гэх/ хамрагдана.

### Хоёр. Багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын зохион байгуулалт

2.1. Мэргэжил дээшлүүлэх сургалтыг орон нутгийн болон үндэсний түвшинд зохион байгуулна.

2.2. Мэргэжил дээшлүүлэх сургалт нь үндсэн сургалт, төрөлжсөн сургалт гэсэн 2 төрөлтэй байна.

2.3. Үндсэн сургалт нь багшийн чадамжийн стандартад заасан шаардлагад суурилсан 4 түвшин, удирдах ажилтны чадамжид суурилсан 3 түвшинтэй байна.

2.4. Багш 5 жил тутамд багшийн чадамжийн стандартын түвшин ахиулах үндсэн сургалтад нийт 4 хүртэлх удаа, удирдах ажилтан нь чадамжийн түвшин ахиулах үндсэн сургалтад тухайн албан тушаалд томилогдон ажилласан 2 дахь жилээс эхлэн 5 жил тутамд нийт 3 хүртэлх удаа тус тус хамрагдана.

2.5. Үндсэн сургалт нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн мэдлэг, идэвхтэй сургалтын арга зүй, ялгаатай суралцахуй, сургалтад технологи, хэрэглэгдэхүүн ашиглах, явцын болон үр дүнгийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, хэрэгжүүлж байгаа суралцахуйн стратегийн үр нөлөөг судлах зэрэг XXI зууны иргэнд шаардагдах чадвар болон удирдахуйн арга барил, манлайлах үр чадварыг дээшлүүлэх хүрээнд шатлан гүнзгийрсэн агуулгатай байна.

2.5.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах хүрээнд тухайн жилийн үндсэн сургалт нь шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг таниулах, хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй, технологийг түгээхэд чиглэнэ.

2.5.2. Журмын 2.5.1-д заасан сургалтыг үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулах бөгөөд бүх багш, удирдах ажилтан аль нэг түвшний сургалтад заавал хамрагдана.

2.6. Үндсэн сургалтыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага доор дурдсаны дагуу зохион байгуулна:

2.6.1. багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийх;

2.6.2.үндсэн сургалтын хөтөлбөрийг багш, удирдах ажилтны албан тушаалын чиг үүрэг, журмын 2.6.1-д заасан судалгаанд тус тус үндэслэн энэ журмын 2.5-д заасан агуулгын хүрээнд боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тусган, сургалт зохион байгуулахаас 1-ээс доошгүй сарын өмнө батлах;

2.6.3.сургалтын хуваарийг жил бүрийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор баталж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага /цаашид "аймаг, нийслэлийн боловсролын газар" гэх/-д хүргүүлэх;

2.6.4.сургалтыг танхимын, танхимын бус, эдгээрийн хосолсон хэлбэрээр, онол-дадлага хослуулан зохион байгуулах;

2.6.5.үндсэн сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтны тухайн сургалтаар судалсан агуулгын хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлж, шаардлага хангасан багш, удирдах ажилтанд цахим гэрчилгээ олгох;

2.6.6. сургалтын хөтөлбөрт журмын 4.1-д заасан саналыг тусган сайжруулах.

2.7.Энэ журмын 2.5.1-д заасан сургалтыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

2.8.Энэ журмын 2.2-т заасан төрөлжсөн сургалт нь багш, удирдах ажилтанд ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд шаардагдах онол, арга зүйн мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн, шатлан гүнзгийрсэн агуулгатай байна.

2.8.1.Төрөлжсөн сургалтын хөтөлбөрийг үндэсний болон орон нутгийн түвшин бүрд тухайн албан тушаалтны ажил, үүргийн онцлог, багш, удирдах ажилтны мэдлэг, ур чадвараас хамааруулан эхний болон ахисан түвшинд шатлан гүнзгийрсэн агуулгаар боловсруулсан байх бөгөөд эхний шатны сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтан ахисан шатны сургалтад хамрагдана.

2.9.Багш, удирдах ажилтан бүр жилд 3 кредит/цагийн багтаамжтай агуулга бүхий төрөлжсөн сургалтад хамрагдана.

2.9.1.Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан багш болон дадлагажуулах үйл ажиллагаанд хамрагдаж байгаа багш нь тухайн жилд энэ журмын 2.13.1-д заасан орон нутгийн түвшний 2 кредит/цагийн багтаамжтай төрөлжсөн сургалтад хамрагдана.

2.9.2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 16.6-д заасан ахлах ангийн сонгон судлах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш тухайн чиглэлээр төрөлжсөн сургалтад хамрагдана.

2.10.Багшид зориулсан төрөлжсөн сургалтыг үндэсний түвшинд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвтэй, орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн боловсролын газар багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвтэй хамтран тус тус зохион байгуулна.

*Тайлбар: Боловсролын ерөнхий хуулийн 12.13-д заасан нэгж гэдэгт -Багшийн хөгжлийг дэмжих үндэсний/бүсийн төв"-ийг хамааруулна.*

2.11.Удирдах ажилтанд зориулсан төрөлжсөн сургалтыг үндэсний түвшинд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн боловсролын газар тус тус зохион байгуулна.

2.12.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь үндэсний хэмжээнд зохион байгуулах төрөлжсөн сургалтын агуулгын чиглэлийг багш, удирдах ажилтны хэрэгцээнд суурилан үндсэн сургалтын агуулгатай уялдуулан жилээр төлөвлөж энэ журмын 2.6.3-д заасан хугацаанд өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулна.

2.12.1.Үндэсний хэмжээнд зохион байгуулах төрөлжсөн сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага багшийн хөгжлийн үндэсний төвтэй хамтран боловсруулж, сургалт эхлэхээс 1-ээс доошгүй сарын өмнө батална.

2.13.Багш, удирдах ажилтан нь жил бүр доор дурдсан төрөлжсөн сургалтад хамрагдана:

2.13.1.багш орон нутгийн түвшинд 2, үндэсний түвшинд 1кредит/цаг;



2.13.2. удирдах ажилтан орон нутгийн түвшинд 1, үндэсний түвшинд 2 кредит/цаг.

2.14. Энэ журмын 2.13-д заасан орон нутгийн түвшинд зохион байгуулах төрөлжсөн сургалтын агуулга, хөтөлбөрийг тухайн орон нутгийн онцлог, цэцэрлэг, сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийн хэрэгцээ, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний дүнд хийсэн шинжилгээ, боловсролын хөгжлийн чиг хандлага, үндэслэн, журмын 2.8-д заасныг баримтлан аймаг, нийслэлийн боловсролын газар, багшийн хөгжлийг дэмжих бүсийн төв хамтран журмын 2.6.3-д заасан хуваарьтай уялдуулан жил бүрийн 02 дугаар сард багтаан боловсруулна.

2.14.1. Энэ журмын 2.14-д заасан агуулга, хөтөлбөрийг аймаг, нийслэлийн боловсролын газар батална.

2.15. Журмын 2.13-д заасан сургалтыг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалт, арга зүй, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

2.16. Энэ журмын 2.9.2-д заасан багшид зориулсан сургалт нь үндэсний түвшинд зохион байгуулах төрөлжсөн сургалтад хамаарна.

2.17. Үндсэн болон төрөлжсөн сургалт нь журмын 2.6.4-д заасан хэлбэрээр зохион байгуулсан сургалт-үйл ажиллагаа болон эзэмшсэн мэдлэг чадвараа багаар хамтран ажиллаж бататгах, ажил үүргээ гүйцэтгэхэд бие даан ашиглаж эргэцүүлэн дүгнэлт гаргах, мэргэжлийн багш нарын бүлгээр хэлэлцэх үйл ажиллагаа гэсэн хэсэгтэй байна.

2.18. Мэргэжил дээшлүүлэх сургалтад энэ журмын 2.5, 2.8-д заасан агуулгаас гадна хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийг таних, үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиглэлээр багш, удирдах ажилтны мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх агуулгыг багтаасан байна.

2.19. Мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг тухайн чиглэлийн судлаач, цэцэрлэг, сургуулийн багш, удирдах ажилтны оролцоотой баг боловсруулна.

2.20. Үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулсан төрөлжсөн сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтанд цахим гэрчилгээ олгоно.

2.21. Багш, удирдах ажилтан нь мэргэжил дээшлүүлэх үндсэн болон төрөлжсөн сургалтад хамрагдсан талаарх мэдээллээ Боловсролын ерөнхий хуулийн 12.12-т заасан цахим системд бүртгэж, аймаг, нийслэлийн боловсролын газрын холбогдох албан хаагч хянан баталгаажуулна.

2.22. Мэргэжил дээшлүүлэх сургалтын талаарх мэдээллийг энэ журмын 2.21-д заасан цахим системд бүртгэн баталгаажуулж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг доор дурдсан байгууллага тус тус хариуцна.

2.22.1. үндсэн сургалт болон үндэсний түвшинд зохион байгуулсан төрөлжсөн сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтны мэдээллийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

2.22.2. орон нутгийн түвшинд зохион байгуулсан төрөлжсөн сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтны мэдээллийг аймаг, нийслэлийн боловсролын газар.

2.23. Мэргэжил дээшлүүлэх сургалтыг энэ журмын 2.21-т заасан цахим системээр зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд систем нь нээлттэй, үнэ төлбөргүй байна.

2.24. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага/боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь мэргэжил дээшлүүлэх сургалтын тайланг үндэсний хэмжээнд нэгтгэж, дараа оны 01 дүгээр сард багтаан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### **Гурав. Мэргэжил дээшлүүлэх сургалтын санхүүжилт**

3.1. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг улсын төсвөөс, төрөлжсөн сургалтыг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүний "Багшийн хөгжлийн зардал"-аас тус тус санхүүжүүлнэ.

3.2.Сургалтын байгууллагын жилийн төсөвт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд батлагдсан багшийн хөгжлийн нийт зардлын 50.0 хувийг энэ журмын 2.2-д заасан төрөлжсөн сургалтад зарцуулна.

3.2.1.Журмын 3.2-д заасан төрөлжсөн сургалтын зардлын 50.0 хувийг үндэсний түвшинд, 50.0 хувийг орон нутгийн түвшинд зохион байгуулах сургалтад тус тус зарцуулна.

3.3.Төрөлжсөн сургалтын хөтөлбөр боловсруулах зардал энэ журмын 3.2-д заасан зардалд багтсан байна.

3.4.Энэ журмын 2.2-д заасан төрөлжсөн сургалтыг боловсролын тухайн түвшинд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

### **Дөрөв. Бусад**

4.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь энэ журмын 2.24-д заасан тайланд шинжилгээ хийж, мэргэжил дээшлүүлэх сургалтын үр дүн, тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний дүн болон сургалтын талаарх сэтгэл ханамжийн тандан судалгааг цахим технологид суурилан хийх зэргээр үндсэн сургалтын чанарт үнэлгээ өгч, сургалтын үр нөлөөг сайжруулах саналыг тухайн онд багтаан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.2.Багш, удирдах ажилтан мэргэжлийн чиглэлээр үндэсний түвшинд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт оролцох, гадаад улс, олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан тохиолдолд тухайн жилийн мэргэжил дээшлүүлэх сургалттай дүйцүүлэн тооцох аргачлалыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан баталж хэрэгжүүлнэ.

4.3.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалт, арга зүйн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтыг тухайн орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагатай хамтран мэргэжил дээшлүүлэх сургалт, мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагаатай харилцан уялдаатай хэрэгжүүлнэ.

4.4.Багш, удирдах ажилтан нь энэ журмын 2.10-д заасан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвөөс хамтран зохион байгуулсан эхний болон ахисан шатны сургалтад хамрагдан амжилттай дүүргэсэн тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Хүүхдийн цэцэрлэгийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам", "Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам"-д заасан холбогдох шалгуурыг тус тус хангасанд тооцно.

4.5.Хөдөлмөрийн тухай хуульд заасан долоо хоног бүрийн нийтээр амрах өдрүүдэд сургалт зохион байгуулах тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу оролцогчдод олгох нэмэгдэл хөлсийг сургалт зохион байгуулагч тал хариуцна.



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/СА

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал, аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтан нарт үүрэг болгосугай.

3.1. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журмыг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулж, үнэлгээ хийх арга зүйн сургалтыг 2025 оны II улиралд багтаан үе шаттай зохион байгуулахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/-т;

3.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд хийсэн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнг боловсролын салбарын мэдээллийн системээр цуглуулах, шинжилгээ хийх програм хангамжийг хөгжүүлэх шийдлийг 2025 оны II улиралд багтаан танилцуулахыг Цахим боловсролын газар /Т.Бат-Эрдэнэ/-т;

3.3. Журмыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулан, үнэлгээний багийг арга зүйгээр хангаж, хөндлөнгийн үнэлгээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт;


3.4. Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ын дагуу байгууллагын гүйцэтгэлийг үнэлэхэд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнг тооцох аргачлал боловсруулж батлуулахыг Боловсролын нэгдсэн бодлогын газар /П.Оюунаа/, Боловсролын үнэлгээний төв /Г.Гантуяа/-д үүрэг болгосугай.;

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н.Нарангэрэл/-т даалгасугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САИД

П.НАРАНБЯЯР



14251 0122



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот


□ 2023 оныг сургалтын байгууллагын  
менежментийг сайжруулах жил болгон зарлах тухай □

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн 2.1.38 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2023 оныг “Сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил” болгон зарласугай.

2. “Сургалтын байгууллагын менежментийг сайжруулах” жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг боловсруулж, батлуулахыг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Цэдэвсүрэн/-д даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142212116



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

「Сургуулийн менежментийг сайжруулахад」  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.1 дэх зорилт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/96 дугаар тушаалаар баталсан “Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө”-ний 3.3 дахь зорилтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах хөтөлбөр арга хэмжээг 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 120 сургуульд үргэлжлүүлэн хэрэгжүүлдсүгэй.

2. Энэ тушаалын 1-д заасан үйл ажиллагаанд хамрагдах ерөнхий боловсролын сургуулийг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн өөрийн хүсэлтээр сонгож, “Сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” ажлын удирдамж баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах, үр дүнг нэгтгэн 2025 оны 08 дугаар сард багтаан танилцуулахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т үүрэг болгосугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн менежментэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 1,200,000,000 (нэг тэрбум хоёр зуун сая) төгрөгийн зардлын 800,000,000 (найман зуун сая) төгрөгийг 2024 оны хөтөлбөр арга хэмжээний 2.1.4 дэх зардлаас, үлдэгдэл 400,000,000 (дөрвөн зуун сая) төгрөгийг 2025 оны улсын төсөвт тусган зохицуулалт хийж тус тус санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга (Х.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

САЙД



П.НАРАНБЯАР

11241 0231



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн "Сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх тухай" А/72 дугаар тушаал, Боловсролын ерөнхий газрын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/4414 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх" үйл ажиллагаанд хамрагдах, бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд хамрагдаагүй, өөрсдөө сургуулийн менежментийг сайжруулах хүсэл эрмэлзэлтэй, шинэчлэл хэрэгжүүлэхээр хүсэлтээ ирүүлсэн ерөнхий боловсролын 120 сургуулийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Сургуулийн менежментийг сайжруулах үйл ажиллагаанд багш, удирдах ажилтнуудыг хамруулж, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх, үр дүнг тооцож, 2025 оны 06 дугаар сард багтаан боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад тайлагнаж ажиллахыг хавсралтад заасан нэр бүхий ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт, үйл ажиллагааны үр дүнд шинжилгээ хийж, орон нутгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлж ажиллахыг холбогдох аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т үүрэг болгосугай.

САЙД

П.НАРАНБАЯР



14241 0414

Боловсролын сайдын  
2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн  
1136 дугаар тушаалын хавсралт

СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХАД  
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМРАГДАХ  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг/ дүүрэг	Сургуулийн нэр
1	Дархан-Уул аймаг	Дархан сумын ерөнхий боловсролын "Од" сургууль
2		Дархан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль
3		Дархан сумын ерөнхий боловсролын 12 дугаар сургууль
4		Дархан сумын ерөнхий боловсролын 15 дугаар сургууль
5		Дархан сумын ерөнхий боловсролын 16 дугаар сургууль
6		Дархан сумын ерөнхий боловсролын 18 дугаар сургууль
7		Дархан сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль
8		Хонгор сумын ерөнхий боловсролын 11 дүгээр сургууль
9		Хонгор сумын ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль
10		Шарын гол сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль
11	Дорноговь аймаг	Айраг сумын ерөнхий боловсролын сургууль
12		Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургууль
13		Даланжаргалан сумын ерөнхий боловсролын сургууль
14		Дэлгэрэх сумын ерөнхий боловсролын сургууль
15		Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль
16		Зүүнбаян сумын ерөнхий боловсролын сургууль
17		Иххэт сумын ерөнхий боловсролын сургууль
18		Мандах сумын ерөнхий боловсролын сургууль
19		Өргөн сумын ерөнхий боловсролын сургууль
20		Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль
21		Сайншанд сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль
22		Сайхандулаан сумын ерөнхий боловсролын сургууль
23		Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургууль
24		Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль
25		Хөвсгөл сумын ерөнхий боловсролын сургууль
26		Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль
27	Дундговь аймаг	Адаацаг сумын ерөнхий боловсролын сургууль
28		Баянжаргалан сумын ерөнхий боловсролын сургууль
29		Говь-Угтаал сумын ерөнхий боловсролын сургууль

30		Гурвансайхан сумын ерөнхий боловсролын сургууль
31		Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургууль
32		Дэлгэрцогт сумын ерөнхий боловсролын сургууль
33		Дэрэн сумын ерөнхий боловсролын сургууль
34		Өлзийт сумын ерөнхий боловсролын сургууль
35		Өндөршил сумын ерөнхий боловсролын сургууль
36		Сайнцагаан сумын ерөнхий боловсролын "Говийн ирээдүй" сургууль
37		Сайнцагаан сумын ерөнхий боловсролын "Хүмүүнлэг" сургууль
38		Сайнцагаан сумын ерөнхий боловсролын "Цэгц билиг" сургууль
39		Сайнцагаан сумын ерөнхий боловсролын "Эрдмийн далай" сургууль
40		Сайхан-Овоо сумын ерөнхий боловсролын сургууль
41		Эрдэнэдалай сумын ерөнхий боловсролын сургууль
42	Өмнөговь аймаг	Даланзадгад сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль
43		Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль
44		Даланзадгад сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургууль
45		Манлай сумын ерөнхий боловсролын сургууль
46		Ноён сумын ерөнхий боловсролын сургууль
47		Номгон сумын ерөнхий боловсролын сургууль
48		Сэврэй сумын ерөнхий боловсролын сургууль
49		Цогт-Овоо сумын ерөнхий боловсролын сургууль
50		Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургууль
51	Сэлэнгэ аймаг	Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль
52		Ерөө сумын ерөнхий боловсролын сургууль
53		Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль
54		Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль
55		Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль
56		Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургууль
57		Орхон сумын ерөнхий боловсролын сургууль
58		Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургууль
59		Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургууль
60		Сайхан сумын ерөнхий боловсролын сургууль
61		Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль
62		Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль
63		Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль
64		Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль
65		Төв аймаг



66		Архуст сумын ерөнхий боловсролын сургууль
67		Баян сумын ерөнхий боловсролын сургууль
68		Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургууль
69		Баянжаргалан сумын ерөнхий боловсролын сургууль
70		Баян-Өнжүүл сумын ерөнхий боловсролын сургууль
71		Баянхангай сумын ерөнхий боловсролын сургууль
72		Баянцагаан сумын ерөнхий боловсролын сургууль
73		Баянцогт сумын ерөнхий боловсролын сургууль
74		Борнуур сумын ерөнхий боловсролын сургууль
75		Заамар сумын ерөнхий боловсролын сургууль
76		Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль
77		Мөнгөнморьт сумын ерөнхий боловсролын сургууль
78		Сүмбэр сумын ерөнхий боловсролын сургууль
79		Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль
80		Эрдэнэсант сумын ерөнхий боловсролын сургууль
81	Багануур дүүрэг	Нийслэлийн ерөнхий боловсролын "Гүн галуутай" сургууль
82		Нийслэлийн ерөнхий боловсролын "Оюуны-Эрин" сургууль
83	Багахангай	Нийслэлийн ерөнхий боловсролын "Хангай" сургууль
84	Баянзүрх дүүрэг	Нийслэлийн ерөнхий боловсролын "Амгалан" сургууль
85		Нийслэлийн ерөнхий боловсролын 102 дугаар сургууль
86		Нийслэлийн ерөнхий боловсролын 126 дугаар сургууль
87		Нийслэлийн ерөнхий боловсролын 127 дугаар сургууль
88		Нийслэлийн ерөнхий боловсролын 132 дугаар сургууль
89		Нийслэлийн ерөнхий боловсролын 133 дугаар сургууль
90		Нийслэлийн ерөнхий боловсролын 137 дугаар сургууль
91		Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль
92		Нийслэлийн ерөнхий боловсролын 147 дугаар сургууль
93		Нийслэлийн ерөнхий боловсролын 155 дугаар сургууль
94		Нийслэлийн ерөнхий боловсролын 158 дугаар сургууль
95		Нийслэлийн ерөнхий боловсролын 164 дүгээр сургууль
96		Нийслэлийн ерөнхий боловсролын 21 дүгээр сургууль
97		Нийслэлийн ерөнхий боловсролын 44 дүгээр сургууль
98		Нийслэлийн ерөнхий боловсролын 48 дугаар сургууль
99		Нийслэлийн ерөнхий боловсролын 68 дугаар сургууль
100		Нийслэлийн ерөнхий боловсролын 69 дүгээр сургууль
101		Нийслэлийн ерөнхий боловсролын 79 дүгээр сургууль
102		Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургууль
103		Нийслэлийн ерөнхий боловсролын 85 дугаар сургууль
104	Нийслэлийн ерөнхий боловсролын 87 дугаар сургууль	
105	Нийслэлийн ерөнхий боловсролын 88 дугаар сургууль	
106	Нийслэлийн ерөнхий боловсролын 92 дугаар сургууль	
107	Нийслэлийн ерөнхий боловсролын 97 дугаар сургууль	
108	Налайх дүүрэг	Нийслэлийн ерөнхий боловсролын "Эрдмийн оргил" сургууль
109		Нийслэлийн ерөнхий боловсролын 103 дугаар сургууль

110		Нийслэлийн ерөнхий боловсролын 160 дугаар сургууль
111	Хан-Уул дүүрэг	Нийслэлийн ерөнхий боловсролын 135 дугаар сургууль
112		Нийслэлийн ерөнхий боловсролын 15 дугаар сургууль
113		Нийслэлийн ерөнхий боловсролын 156 дугаар сургууль
114		Нийслэлийн ерөнхий боловсролын 163 дугаар сургууль
115		Нийслэлийн ерөнхий боловсролын 26 дугаар сургууль
116		Нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургууль
117		Нийслэлийн ерөнхий боловсролын 59 дүгээр сургууль
118		Нийслэлийн ерөнхий боловсролын 60 дугаар сургууль
119		Нийслэлийн ерөнхий боловсролын 7 дугаар сургууль
120		Нийслэлийн ерөнхий боловсролын 89 дүгээр сургууль

-оОо-



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/240

Улаанбаатар хот

Г Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай Г

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.1.3 дахь зорилт, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-ний 5.1, 5.3 дахь зорилт, Засгийн газрын 2021 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 264 дүгээр тогтоолын 5 дахь заалт, 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/200 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлт, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Хөтөлбөр, арга хэмжээний 2023 оны төсвийн хуваарилалт батлах, эрх шилжүүлэх тухай” А/07 дугаар тушаалын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Дээд боловсролын гүйцэтгэлийн үзүүлэлтэд суурилан эрэмбэ, чансаа тогтоох ажлын хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагын шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, сургалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд их дээд сургуулийн үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хавсралтаар баталсан үзүүлэлтийн хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ тогтоох, сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ хийх ажлыг олон улсын болон дотоодын чанарын үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран 2023 оны 08 дугаар сарын 20-ны дотор багтаан зохион байгуулахыг Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/-д даалгасугай.

3. Дээд боловсролын эрэмбэ тогтоох үйл ажиллагаанд шаардагдах 150 /нэг зуун тавин/ сая төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний 3.6-д заасан зардлаас санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэнд зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н.Нарангэрэл/-д даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14231 0960

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2023 оны 05 дугаар сарын 19 өдрийн  
АБЦҮО тушаалын нэгдүгээр хавсралт

Дээд боловсролын сургалтын байгууллагын шалгуур үзүүлэлт

Д/д	Шалгуур	Үзүүлэлт
1	Байгууллагын магадлан итгэмжлэл	Магадлан итгэмжлэгдсэн байдал
2	Суралцагч	Нийт суралцагчийн тоо
3		үүнээс: Идэвхтэй суралцаж байгаа бакалавр оюутны тоо
4		1-р курст суралцаж байгаа
5		Идэвхтэй суралцаж байгаа магистрантын тоо
6		1-р курст суралцаж байгаа
7		Идэвхтэй суралцаж байгаа докторантын тоо
8		1-р курст суралцаж байгаа
Л.Ариунтулга	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын улсын ахлах байцаагч
О.Пүрэвжав	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч
Нарийн бичгийн дарга:	Г.Наранбаатар Боловсрол, шинжлэх ухааны яамны Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн, Улсын ахлах байцаагч

---oOo---



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/343

Улаанбаатар хот

Дээд боловсролын чанарын  
үнэлгээ хийх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.1.3 дахь зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай" 264 дүгээр тогтоолын 5 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай" А/240 дүгээр тушаал, 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн "Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх тухай" А/50 дугаар тушаалын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбийг эцэслэн тогтоох ажлыг олон улсын болон дотоодын чанарын үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан зохион байгуулахыг Боловсролын үнэлгээний төв (Л.Ганбат)-д даалгасугай.

2. Дээд боловсролын эрэмбэ тогтоох үйл ажиллагаанд шаардагдах 299,642,160 (хоёр зуун ерэн есөн сая зургаан зуун дөчин хоёр мянга нэг зуун жар) төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний 3.2.13 дахь зардлаас санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргалд зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл)-д даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

14241 1200



БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ДЭЭД  
БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

## БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны  
гудамж 21 тоот, "Сантис боловсролын төв"-ийн байр

Утас/факс: (976-11) 7011-8486

E-mail: info@eec.mn

2024.09.30 № 01/347

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дээд боловсролын чанарын үнэлгээний  
тайлан хүргүүлэх тухай

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/240 тоот тушаал, 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/434 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ, эрэмбэ тогтоох үйл ажиллагааг зохион байгууллаа.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/50 тоот тушаалаар байгуулагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэлт гаргах" ажлын хэсгээс баталгаажуулсан дата өгөгдөлд суурилсан эрэмбийн тайлангийн хувийг танай газарт цаасаар болон цахимаар илгээлээ.

Эцэслэсэн эрэмбийн үр дүнг Боловсролын үнэлгээний төвийн [highreport.eec.mn](http://highreport.eec.mn) цахим сайтын хаалттай туршилтын талбарт тусгай хандах эрхтэйгээр байршуулсан ба нээлттэй байршуулах бэлтгэл хангагдсан болно.

ЗАХИРАЛ

Л.ГАНБАТ



**ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН  
ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН  
ТАЙЛАН  
2023/ 2024**

**2024.09.27**

## АГУУЛГА

1. ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ .....	3
2. ДБСБ-ЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ, ОРОЛЦОГЧИД .....	3
3. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	4
3.1 ДБСБ-ЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ (УРЬДЧИЛСАН ЭРЭМБИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД) ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	5
3.2 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БАТАЛГААЖИЛТ .....	8
3.3 ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ.....	11
4. HIGH.EEC.MN СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ .....	13
5. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРЭМБЭ ТОГТООХ АРГАЧЛАЛ.....	15
6. ЭРЭМБИЙН ҮР ДҮН.....	20

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ДБСБ-уудад мэдээлэл хүргэх уулзалт.....	6
Зураг 2. ИДС-иудад зөвлөн туслах үйл ажиллагаа .....	6
Зураг 3. Хянан баталгаажуулах үйл ажиллагаа .....	7
Зураг 4. Дотоодын урьдчилсан эрэмбэ зарлах хэвлэлийн бага хурал.....	7
Зураг 5. 2024 онд хийгдсэн үйл ажиллагаа .....	8
Зураг 6 Times Higher Education байгууллагатай хамтын ажиллагаа .....	11
Зураг 7. ДБЧҮ-ний өгөгдөл оруулах систем – high.eec.mn.....	13
Зураг 8. ДБСБ-ын эрэмбийн жагсаалтын вэбсайт.....	14



## **ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

Боловсролын салбарын нэгдсэн статистикаас үзэхэд 2023-2024 оны хичээлийн жилд нийт 1,229,600 гаруй суралцагчтай, эдгээрээс 64 их, дээд сургуульд дипломын, бакалаврын, магистр, докторын түвшинд 145,345 нь суралцаж байна<sup>1</sup>. Нийт суралцагчдын 11.8 хувь нь дээд боловсролын салбарт суралцаж байгаа боловч мэргэжил эзэмших зорилго чиглэл, хувь хүний хөгжлийн орчин, шинжилгээ судалгааны үүрэг, ач холбогдол эрдмийн болон оюуны нөөц чадавхийн хувьд манай улсын боловсролын тогтолцоонд үлэмж байр суурь эзэлдэг салбар юм. Дээд боловсролын салбарын боловсролын үйлчилгээний чанар, үр ашиг, соён гэгээрүүлэх, эрдэмжүүлэх үүрэг, үүнийг дагасан нийгмийн хүлээлт, дэлхийн дахины боловсролд хандах шинэ тутам чиг хандлага зэрэг олон хүчин зүйлүүд энэ салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ДБСБ-уудыг чанартай мэргэжилтэн бэлтгэх, дэлхийн хэмжээний боловсролын үйл ажиллагааг хөтлөн явуулдаг байх бодитой шаардлагыг үүсгэж байгаа юм.

ДБЧУ-ний хүрээнд зохион байгуулагдсан эрэмбэ нь дээд боловсролын байгууллагуудыг үнэлэх, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаа, сургалтын чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар дээд боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа, боловсролын хөтөлбөрүүдийн чанарыг сайжруулах, хэрэглэгчдийг дээд боловсролын сургалтын байгууллагуудын талаар бодит мэдээлэлтэй болж, тохиромжтой дээд боловсролын байгууллага, хөтөлбөрийг сонгоход нь туслах, мэдээллээр хангахад оршиж байна.

### **1. ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ**

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050" баримт бичгийн 2.1-д "Олон улсын шаардлага хангасан ДБСБ-ийн тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болсон байх", 2.1.8-д "Боловсролын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн хяналт шинжилгээг олон улсын жишиг аргачлалаар хийдэг тогтолцоонд шилжиж, төрөөс хараат бус бие даасан институцийг бэхжүүлнэ", түүнчлэн Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөний 5.1-дэх "Дээд боловсролын сургалтын байгууллагын чансаа тогтоож, их дээд сургуулиудыг эрэмблэнэ.., олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу сургалт судалгаагаараа эрэмбэлэгдэх суурь бэлтгэлээ хангах болно" гэсэн зорилго, зорилтуудын хүрээнд ДБСБ-уудын эрэмбэ тогтоох үйл ажиллагааг зайлшгүй хийх хэрэгцээ, шаардлага бий болоод байсан билээ.

### **2. ДБСБ-ЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ, ОРОЛЦОГЧИД**

Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ нь олон талын оролцогчдыг хамран зохион байгуулагдлаа. Манай улсын дээд боловсролын салбарт анх удаа хэрэгжиж буй үнэлгээний ажил байсан бөгөөд БШУ-ны Сайдын тушаалд олон улсын болон дотоодын чанарын үнэлгээний мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар заасны дагуу олон улсын нэр хүнд бүхий байгууллага болох Times Higher Education (THE)

<sup>1</sup> <https://moe.gov.mn/post/134647>

байгууллага, дотоодын зөвлөх үйлчилгээ үзүүлэх Боловсролын чанарын судалгааны хүрээлэн (БЧСХ) зэрэг байгууллагуудтай хамтран ажиллалаа. Зөвхөн эрэмбийн үнэлгээний өгөгдөл мэдээллийг үүсгэх, үүссэн өгөгдөл мэдээллийг дахин нягтлах, дүгнэлт гаргахтай холбоотойгоор хянан баталгаажуулах баг (2023 оны 6 дугаар сард 59 хүний бүрэлдэхүүнтэй 15 баг), гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах комисс (2024 оны 2 дугаар сард А/50 тоот тушаалаар байгуулагдсан 40 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг) бүхий 2 удаагийн баг томилогдон ажилласан. Мөн үнэлгээнд хамрагдаж буй сургалтын байгууллагын холбогдох албад, мэргэжилтнүүдийг татан оролцуулсан өргөн хүрээтэй үнэлгээ, судалгааны ажил байсан. Эрэмбийн үнэлгээнд оролцогчдыг чиг үүргээр нь бүлэглэн дор хүснэгтэд үзүүллээ.

Чиг үүрэг	Оролцогч
Ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх	БШУЯ-ны ДББУЗГазар
Дээд боловсролын салбарын чанарын дата, өгөгдөл болон эрэмбэд ашиглагдах тоон мэдээллийг үүсгэх, их дээд сургуулиудтай хамтран ажиллах, үнэлгээний дэд бүтэц (цахим сайт) үүсгэх, нийтэд мэдээлэх	Боловсролын үнэлгээний төв
Дата мэдээлэлд шинжилгээ хийх, эрэмбэ үүсгэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх	Times Higher Education
Шалгуур үзүүлэлтийг боловсруулах, сургалт хийх, өгөгдлийг боловсруулах, нягтлах, дүн шинжилгээ хийх, эрэмбэлэх	Боловсролын чанарын судалгааны хүрээлэн
Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийн үнэлгээний дата мэдээллийг үүсгэх, системд өгөгдөл оруулах	Их, дээд сургуулиуд, холбогдох албад
Урьдчилсан эрэмбийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, хянан магадлах	БШУ-ы сайдын 2024 оны А/50-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг


### 3. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү зорилго, зорилтуудын хүрээнд БШУ-ны Сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/240 тоот тушаалаар ДБСБ-ын 2023 оны эрэмбэ тогтоох үйл ажиллагааг эхлүүлсэн. Уг тушаалын 1-3 дахь хавсралтаар дээд боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийн болон тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд их дээд сургуулийн үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг баталсан. Уг тушаалд олон улсын болон дотоодын чанарын үнэлгээний мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Боловсролын үнэлгээний төвд хариуцуулсан. Чанарын үнэлгээний ажлын үр дүнг 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр [highreport.eec.mn](http://highreport.eec.mn) цахим сайтаар дамжуулан "Дээд боловсролын сургалтын байгууллагын урьдчилсан эрэмбэ"-ийг БШУ-ны Сайд зарласан.

### 3.1 ДБСБ-ЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ (УРЬДЧИЛСАН ЭРЭМБИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД) ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Боловсрол шинжлэх ухааны Сайдын 2023 оны “Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай” А/240 дүгээр тушаалын хавсралтаар дээд боловсролын сургалтын байгууллагын, сургалтын хөтөлбөрийн болон тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд их дээд сургуулийн үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох чиглэлээр чанарын үнэлгээний шалгуур, үзүүлэлтийг тус тус баталсан.

Батлагдсан шалгуурын дагуу олон улсын болон дотоодын чанарын үнэлгээний байгууллагатай хамтран зохион байгуулахыг Боловсролын үнэлгээний төвд даалгасны дагуу үнэлгээний нэгдүгээр багц үзүүлэлт болох дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний мэдээлэл цуглуулж эхлэхээс эрэмбэ зарлах хүртэл буюу 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдрийн хооронд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



#### - Шалгуур үзүүлэлт болон программ хангамжийн хөгжүүлэлт


Зохион байгуулагчид болон программ хөгжүүлэгчдийн удаа дараагийн уулзалтаар шалгуур үзүүлэлтийн тоон өгөгдлүүдийг системд хэрхэн бүртгэх, системээс дата татах, баталгаажуулах, хялбарчлах /3 багц индикатор, нийт давхардсан тоогоор 920 шалгуур үзүүлэлт/ зэрэг шийдлүүдийг ярилцаж шийдвэрлэсэн. Сэтгэл ханамжийн асуулгыг оролцогчдын хэв шинжид нийцүүлэн боловсруулах ажлууд мөн хийгдсэн.

#### - ДБСБ-уудад эрэмбийн үнэлгээний талаар мэдээлэх

БҮТ-өөс МУ-д үйл ажиллагаа явуулж буй нийт 67 сургалтын байгууллагын захирал, сургалтын алба хариуцсан дарга нартай холбогдон дээд боловсролын чанарын үнэлгээ /ДБЧҮ/ зохион байгуулагдах тухай мэдээлэл хүргэж уулзалтуудыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулж ажилласан. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа албан ёсоор

эхлэх хүртэл ДБСБ-ууд сүүлийн 3 жилээр шаардлагатай баримт бичиг болон тоон мэдээллийг бэлтгэн ажилласан. Мөн мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны хугацаа, хянан баталгаажуулах, зөвлөн туслах багийн чиг үүргийг танилцуулсан.



*Зураг 1. ДБСБ-уудад мэдээлэл хүргэх уулзалт*



**- Зөвлөн туслах хянан баталгаажилтын багуудын үйл ажиллагаа**

ДБСБ-д зөвлөгөө өгөх, дэмжин туслах, системд өгч буй өгөгдлийг нотлох баримтын дагуу хянан баталгаажуулах, зөвлөн туслах үйл ажиллагааг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 07 дугаар сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Зөвлөн туслах, хянан баталгаажуулалт хийх үйл ажиллагааг 2-оос 4 хүний бүрэлдэхүүнтэй 15 баг томилогдож хуваарилагдсан сургууль тус бүр дээр очиж ажилласан. Багууд ДБСБ-ууд дээр очиж, баримт бичигтэй тулгалт хийх, системд мэдээлэл оруулах үйл ажиллагаанд зөвлөн туслах, мэдээллийг оруулж дууссан тохиолдолт тулгалт хийж баталгаажуулах ажлыг хийсэн.

*Зураг 2. ИДС-уудад зөвлөн туслах үйл ажиллагаа*



**- Хянан баталгаажуулах үйл ажиллагаа**

Хянан баталгаажуулах ажлын хувьд их, дээд сургуулиуд мэдээллээ оруулж системийн баталгаажилт товчийг дарсаны дараа хийгдсэн ажил юм. Үндсэндээ 3 үе шаттай баталгаажилт хийгдсэн. Эхний 2 шатанд системд оруулсан мэдээллүүдийг холбогдох нотлох баримтуудтай тулгах, сургуулийн зүгээс мэдээлэл дутуу оруулсан тул нэмэлтээр өгөгдөл оруулах хүсэлт тавьсан бол системийг нээх, (энэ үед тухайн шинээр оруулах мэдээллээс бусад дата хөдлөхгүй байхад анхаарах) сургалтын байгууллагад ажиллаж буй баг хянан магадлагаагаар илрүүлж өөрчлөх шаардлагатай гэсэн мэдээллийг сургуулиар

өөрсдөөр нь засуулах зэрэг ажлууд хийгдсэн. 3 дахь шатанд системд оруулж баталгаажсан мэдээллийг гуравдагч эх сурвалжтай тулган, хянан баталгаажуулалт хийсэн. Тухайлбал Боловсролын Магадлан Итгэмжлэх үндэсний Зөвлөл, WoS, Scopus бүтээлийн сан, IPOM Publish-патентын бүртгэл, БШУЯ-аас ирүүлсэн гарааны компанийн бүртгэлийн жагсаалт, Инновацийн бүтээлийн бүртгэл, шинжээчийн дүгнэлт г.м.

Зураг 3. Хянан баталгаажуулах үйл ажиллагаа



**- ДБСБ-ын урьдчилсан эрэмбэ зарлах**

Эрэмбийг зарлахдаа 61 сургуулиас цугларсан үнэлгээний мэдээллийг (салбар сургуулиудыг оруулаад нийт 227 сургууль), нийт багц 12 шалгуурын (суралцагч, төгсөгч, тэтгэлэг зээл тусламж, оюутанд чиглэсэн үйлчилгээ, багшлах бүрэлдэхүүн, сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээ, сургалтын орчин, хамтын ажиллагаа нийгмийн хариуцлага, санхүү болон оролцогчдын сэтгэл ханамж), 273 үзүүлэлтэд суурилсан. Үүнтэй холбоотойгоор БҮТ-ийн high.ees.mn платформд ДБСБ-иудын сүүлийн 3 хичээлийн жилийн нэгдсэн мэдээлэл орж, давхардсан тоогоор 21,655 багшийн, 385,564 суралцагчийн, 65,180 төгсөгчийн, 6,849 сургалтын хөтөлбөрийн өгөгдөл бүртгэгдсэн байна. Боловсролын чанарын судалгааны хүрээлэн, Боловсролын үнэлгээний төвөөс аргачлалыг боловсруулж олон улсын Times Higher Education (THE) байгууллагаас аргачлалын зөвлөгөө авч МУ-ын ДБСБ-иудыг анх удаа **урьдчилсан байдлаар эрэмблэж** нийтэд мэдээлсэн.

Зураг 4. Дотоодын урьдчилсан эрэмбэ зарлах хэвлэлийн бага хурал



2023 оны 10-р сарын 16-ны өдөр урьдчилсан эрэмбийг БҮТ-ийн <https://highreport.eec.mn/> сайтад нээлттэй байршуулан, БШУЯ-ны хурлын танхимд хэвлэлийн бага хурал хийж, олон нийтэд зарласан.


- **Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал**

БҮТ-ийн Захирлын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/117 тушаалаар БШУЯ-аас 2 мэргэжилтэн, БҮТ-өөс 3 мэргэжилтэн, Боловсролын чанарын судалгааны хүрээлэнгээс 2 гишүүний бүрэлдэхүүнтэй өргөдөл гомдол шийдвэрлэх комисс байгуулсан. Өргөдөл гомдлыг барагдуулахдаа Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэх тухай хууль, Боловсролын үнэлгээний байгууллагын дүрэм, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг мөрдөж ажилласан. Үндэсний биеийн тамирын дээд сургууль, Шинэ Анагаан ухаан их сургууль, Олон улсын эдийн засаг бизнесийн сургууль, МҮИС-иудаас эрэмбэ тогтоохтой холбоотой өргөдөл, гомдол ирснийг комисс хуралдан, тухай бүрт нь хариуг хүргүүлсэн.

### 3.2 ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БАТАЛГААЖИЛТ

Урьдчилсан эрэмбэ зарлагдсаны дараа БШУ-ны сайдын 2024 оны А/50 тоот тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны гүйцэтгэлийн үзүүлэлтийг хянан баталгаажуулах комисс томилогдож, ажлын чиглэл, удирдамж батлагдсан. Дээрх тушаал батлагдсанаар сургалтын байгууллагуудын урьдчилсан эрэмбээр үүсгэсэн мэдээллийг нягтлан баталгаажуулах, системд хөгжүүлэлт хийх, өгөгдлийн бодолтын арга зүйг шинэчлэх, шинэчилсэн эрэмбэ үүсгэх зэргээр олон ажлууд хийгдэх болсон.

Зураг 5. 2024 онд хийгдсэн үйл ажиллагаа



2024 оны А/50 тоот тушаалаар 40 хүний бүрэлдэхүүнтэй 2 ажлын хэсэг томилогдсон ба дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр болсон.

1. БШУ-ы сайдын 2023 оны А/240-р тушаалын хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу ДБСБ-ын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтэд тулгалт хийж баталгаажуулах, үзүүлэлтэд заасан мэдээллийг шинэчлэн бүрдүүлэх, дүгнэлт гаргах
2. Боловсрол сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичгүүд, хууль, тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын хэрэгжилт, дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийн бүртгэл, мэдээлэл баяжилтын явцтай танилцах, бодит байдалд үнэлэлт дүгнэлт өгөх
3. Өмчийн бүх хэлбэрийн ДБСБ-ын Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд оруулсан 2022-2023 оны хичээлийн жилийн статистикийн мэдээ тайланд үнэлэлт дүгнэлт өгөх
4. ДБ-ын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.14 (...статистикийн болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх), Статистикийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6 (статистикийн мэдээлэл, судалгааг батлагдсан буюу зөвшөөрөгдсөн үзүүлэлт, аргачлалын дагуу тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж өгөх) эдгээр заалтын хэрэгжилтийг нягтлах
5. Гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах дүгнэх ажлын явцад шаардлагатай тохиолдолд мэдээллийг нягтлах зорилгоор Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын бүртгэл, хичээлийн хуваарийн баталгаажилт, мөрдөлт, багц цагийн гүйцэтгэл, элсэлт, төгсөлтийн үйл ажиллагаатай холбогдох баримт бичиг, мэдээллийн санд шалгалт хийх зэрэг ажил үүргийг удирдамжаар тодорхойлж өгсөн болно.

Нийт 80 сургалтын байгууллагад (нийслэлд байрлах төв болон орон нутагт байрлах салбар сургуулиудыг оруулаад) ажлын 30 орчим өдөрт багтаан ажиллахаар төлөвлөсөн тул ажлын хэсгийг 2 баг болгон, ажиллах сургууль болон хугацааг тодорхой зааж өгсөн. Төрийн өмчийн томоохон сургуулиуд хөдөө орон нутаг дахь салбар сургуулийнхаа гүйцэтгэлийн үзүүлэлтийн мэдээллийг төв сургууль дээрээ нэгтгэн мэдээлсэн. Өөрөөр хэлбэл орон нутгийн салбар сургуулиуд эрэмбийн мэдээллийг системд оруулах үйл ажиллагаанд үүрэг оролцоо багатай байсан тул орон нутгийн сургуулиуд дээр ажиллаж үнэлгээний мэдээллийг үүсгэх, мэдээлэх үйл ажиллагааг нягтлах шаардлагатай хэмээн үзэж ажилласан болно.

**- Баталгаажилт хийх, дүгнэлт гаргах багийн бүрэлдэхүүн**

Энэ удаагийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь БШУЯам болон харьяа байгууллагуудын төлөөлөл оролцсон өргөн хүрээний баг ажиллав. Салбарын хяналтын ерөнхий байцаагч, ахлах байцаагч нар, ДББУЗГ-ын мэргэжилтэн, шинжээч нар, БЕГ-ийн дээд боловсролын статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүд, БҮТ-ийн ахлах мэргэжилтэн, холбогдох албаны мэргэжилтэн, ШУТСангийн мэргэжилтнүүд зэргээр ажил мэргэжлийн өргөн хүрээний шаардлага, дүгнэлт өгөхүйц баг бүрдэж ажиллалаа. Ажлын хэсгийн 1 дүгээр багийг ДББУЗГ-ын дарга, 2 дугаар багийг БШУ-ы салбарын хяналтын дарга, улсын ерөнхий байцаагч ахлан ажилласан.

Урьдчилсан байдлаар 3 удаагийн зөвлөлдөх уулзалт, эхний сургууль дээр ажилласны дараах уулзалт, явцын дунд болон баталгаажилт дууссаны дараах тоон мэдээллийг дундын драйвт байршуулах, бичгэн тайлан болон дүгнэлт, зөвлөмжийн төслийг хэлэлцэх уулзалтуудыг БШУЯам болон төрийн өмчийн зарим сургуулиудын анги танхимд хийж чиглэлүүдээ нарийвчлан ярилцаж байсан.

Нийт 11 бүлэг шалгуурыг 2 багийн нарийн бичгийн дарга нар гишүүдэд хуваарилан өгч баталгаажуулалтыг хийж ажилласан

**- ДБСБ дээр ажилласан байдал**

Баталгаажилтын 2 багийн хувьд нилээд ачаалалтай, шахуу хуваарьтай ажилласан. 2023 оны VI, VII сард эрэмбийн анхны мэдээллийг үүсгэх багууд нэг сургууль дээр дунджаар 2.5 өдөр ажиллаж байсан ба ихэнх тохиолдолд сургуулийн холбогдох албад, мэргэжилтнүүдээр мэдээллийг бэлтгүүлж <https://high.eec.mn/> сайтад дата, өгөгдлөө оруулж ажилласан бол энэ удаад үнэлгээний багийнхан нотлох баримтуудтай нь тулгах, нягтлахад голлон анхаарч 0.5-1 өдөрт багтааж ажилласан тул сургууль дээр ажиллах хугацаа хангалттай биш байлаа.

11 бүлэг шалгуур нь 246 шалгуурт нарийвчлан задарч байгаа болно. Шалгуур тус бүрийн мэдээллийг баталгаажуулах, сургалтын байгууллагаас гаргаж өгсөн нэмэлт мэдээллийг шаардлага хангаж буй бол хүлээн авах, системд нэмж оруулах, өмнөх эрэмбийн үнэлгээнд тооцуулсан боловч сургууль дээр ажиллахад үнэн бодитой нь нотлогдоогүй бол цуцлах (үл хүлээн зөвшөөрөх) гэх мэтээр хариуцлага мөн хугацаа шаардсан ажлууд ихтэй байсан. Нэг сургууль дээр ажилласан үр дүнгээ тухайн өдөртөө дундын драйвын эксел талбарт шивж оруулах ба үгэн тайланд оруулах тайлбарыг мөн тэмдэглэж байсан.

2 багийн хувьд нийслэлд 28-30 сургууль, орон нутагт 10 орчим сургууль дээр ажилласан. Орон нутгийн сургуулийн мэдээллийг нийслэл дэх төв сургууль нь системд оруулсан тул 2023 оны VI, VII сард явагдсан үйл ажиллагааны талаар ойлголт багатай, ихэвчлэн шалгалт гэж ойлгож хүлээн авч байлаа.

**- Баталгаажилтын үр дүн**

Дээд боловсролын сургалтын байгууллага дээр ажиллахад эрэмбийн үнэлгээнд мэдээлсэн өгөгдөлд тодорхой хэмжээний өөрчлөлт орж байлаа. 2023 оны БШУ-ны Сайдын А/240 тушаалын дагуу 05 сарын 27-ны өдрөөс 08 сарын 15-ны өдөр хүртэл мэдээлэл оруулахад тодорхой шалтгааны улмаас (орон нутгийн мэдээлэл оруулаагүй орхигдсон, хариуцсан мэргэжилтэн амарсан/ажлаас гарсны улмаас дутуу мэдээлэл орсон г.м.) мэдээллээ дутуу оруулсан тул нотлох баримтаар баталгаажуулан нэмж бүртгэх, эсвэл нотлох баримтаар нотлогдоогүй, эсвэл шалгуур үзүүлэлтийг буруу ойлгосны улмаас хамааралгүй мэдээлэл оруулсан г.м. шалтгааны улмаас зарим үзүүлэлтийг хасаж бүртгэх тохиолдолд гарч байв. Мөн 2024 оны ажлын хэсэгт салбарын хяналтын ерөнхий байцаагч, ахлах байцаагч нар, бусад харьяа байгууллагын мэргэжилтнүүд ажилласнаар, нэмэлтээр нотлох баримт гаргуулах (жишээ нь нийгмийн даатгал төлсөн байдал, ШУТ сан, HEMIS-т бүртгэлтэй байдал г.м.) боломжтой болсон. Шалгуур үзүүлэлтийн өгөгдлийг оруулахдаа нэмэлт олон эх сурвалжаас нотолгоог бүрдүүлж ажилласан.

Жишээ нь, төгсөгч шалгуурийн хувьд тухайн сургууль төгсөгчийн мөшгөх судалгааны мэдээллийг урьдчилсан эрэмбийн мэдээлэлд оруулаагүй орхигдуулсан тул нэмж бүртгэх; тэтгэлэг зээл тусламжийн шалгуурийн хувьд 500 км-ээс хол зайтай алслагдсан аймгийн оюутнуудад олгодог унааны хөнгөлөлтийн мэдээллийг нэмэлтээр сургуулиас олгосон тэтгэлэг байдлаар бүртгэсэн тул хасаж бүртгэх; багшлах бүрэлдэхүүний хувьд олонх сургуулиуд цагийн буюу гэрээт багшаа үндсэн багшаар мэдүүлсэн байсныг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, жилийн эхний захирлын А тушаал зэрэг нотлож болох баримт бичгүүдээр нарийвчлан тулгаж хасаж бүртгэх; үндсэн багшаас гэрээт



багшийн ангилалд бүртгэх, захиргаанд ажиллаж буй үндсэн багшийг оруулаагүй орхигдуулсныг нэмж бүртгэх гм. шалгуур бүрт сургуулиуд дээр их бага ямар нэгэн хэмжээгээр өөрчлөлтүүд гарч байсан болно.

Ийнхүү 2 баг баталгаажуулалтыг төлөвлөсөн хугацаандаа хийж гүйцэтгээд ажлын хэсгийн өргөтгөсөн хурлаар эцсийн датаг баталгаажуулан 2024 оны 5-р сарын 16-ны өдөр БШУЯ-ны ДББУЗГ-т хүлээлгэн өгсөн.


### 3.3 ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Манай улсын дээд боловсролын салбарт сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй ДБСБ-ыг эрэмблэх энэхүү ажил анхны удаа, шинэ тутам хийгдэж буй ажил тул олон улсын болон дотоодын мэргэжлийн байгууллага, судлаач, эрдэмтэдийн багтай хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага үүссэн. БШУЯ-аас ирүүлсэн чиглүүлгийн дагуу олон улсын Times Higher Education үнэлгээний байгууллагыг сонгож ажилласан бол дотоодын судлаач, эрдэмтдийн багаас “гүйцэтгэлийн үзүүлэлтийг...хянан хэлэлцэж дүгнэлт гаргах” ажлын хэсэгт (БШУС тушаал А/200, 2023.05.04) мэдээлэл өгч, оролцож ажилласан БЧСХүрээлэнгийн судлаачдын багийг сонгож хамтран ажиллах гэрээ байгуулсан.

**- Олон улсын мэргэжлийн байгууллага Times Higher Education (THE) байгуулагатай хамтран ажилласан үйл ажиллагаа**

2023.08.02-ны өдөр олон улсын Times Higher Education /THE/ байгууллагын экспертүүдтэй анхны уулзалтыг онлайнаар зохион байгуулсан бөгөөд ДБЧУ-ний мэдээлэл цуглуулах процессыг танилцуулсан. Олон улсын экспертүүд зохион байгуулалт болон шалгуур, эрэмбэ чансаа бодох аргачлалыг орчуулж авах, түүнд үндэслэн санал өгөхөөр тохирч шаардлагатай мэдээллийг илгээсэн. 2023 оны 08.07-ны өдөр БҮТ болон THE хоёр байгууллага ажлын 20 хоногийн “Зөвлөх үйлчилгээний гэрээ”-нд гарын үсэг зурсан. Гэрээ дуусгавар болох 2023 оны 10 дугаар сарын 10-ныг хүртэл хугацаанд зөвлөлдөх 3 удаагийн онлайн уулзалт зохион байгуулж, энэ хугацаанд 10 гаруй удаа мэйлээр харилцсан. Мөн THE байгууллагын зүгээс өгөгдөл цуглуулах найдвартай байдал, дүн онооны бодолт, томъёо зэрэгт мэйлээр санал ирүүлэхээс гадна, 2 удаагийн товч тайлан, дүгнэлт ирүүлснийг хүлээн авч, эцсийн боловсруулалтад тусгасан.

Зураг 6 Times Higher Education байгуулагатай хамтын ажиллагаа



**- Дотоодын мэргэжлийн байгууллага Боловсролын чанарын судалгааны хүрээлэнгийн (БЧСҮХ) НҮТББ-тай хамтран ажилласан үйл ажиллагаа**


Боловсролын чанарын судалгааны хүрээлэнгийн судлаачидтай урьдчилсан эрэмбэ зарлах (2023 онд) үйл ажиллагаатай холбоотой дараах ажлуудыг хамтран гүйцэтгэсэн. Үүнд:

- БШУ-ы Сайдын А/240 тоот тушаалын хавсралтаар батлагдсан дээд боловсролын сургалтын байгууллагын шалгуур үзүүлэлт, сургалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд их, дээд сургуулийн үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийн тухай мэдээллийг ДБСБ-уудад хүргэх, таниулах, сурталчлах
- ДБСБ-ын шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах, хянан баталгаажуулах багийг мэдээллээр хангах, ажлын чиглэл, арга зүйг эзэмшүүлэх сургалт
- Эрэмбийн мэдээлэл цуглуулах үндсэн талбар болох систем хөгжүүлэгчидтэй уулзах, системийн хэрэглээний нийцтэй байдлыг хангах уулзалт хийх
- ДБСБ-уудаас high.eec.mn сайтад оруулж буй үнэлгээний мэдээлэл, өгөгдлийн үнэн бодитой байдалд хяналт тавих
- Олон улсын THE байгууллагатай хийх цахим уулзалтуудад байнга оролцох
- Урьдчилсан эрэмбэ зарлахтай холбоотой дата өгөгдлийг нягтлах, бодолт хийх, эрэмбэ үүсгэх, урьдчилсан эрэмбэ зарлах сайтын бэлэн байдлыг хянах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

БШУ-ны Сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/50 тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажлын хэсэг”-ийн үйл ажиллагааны үеэр шалгуур үзүүлэлтийг тайлбарлах, мэдээлэл өгөх, гарын авлагад орсон үзүүлэлт, илрүүлэх хүчин зүйлсийг ажлын хэсгийн гишүүдэд тайлбарлах сургалт хийж, ажлын хэсгийн зарим хуралд оролцож, асуултад тодруулга өгч ажилласан.

БШУ-ны Сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/343 тоот тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбийг эцэслэн тогтоох ажлыг Боловсролын үнэлгээний төвд даалгасан бөгөөд “Боловсролын чанарын судалгааны хүрээлэн” НҮТББ нь уг үйл ажиллагаанд аргазүйн зөвлөгөө өгөхөөр 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдөр 01/1668 тоот гэрээг БҮТ-тэй байгуулсан.


Зөвлөх үйлчилгээний гэрээнд эрэмбийн бодолт, аргачлалтай холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд 2024.09.27-ны өдрийн байдлаар гэрээний гүйцэтгэлийг цаг хугацаанд нь нийлүүлж, бодолт аргачлал, оролцооны тайланг бүрэн хэмжээгээр хүлээн авсан болно.




#### 4. HIGH.EEC.MN СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ

БШУ-ы Сайдын 2023 оны “Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай” А/240 дүгээр тушаалын 1-3 дугаар хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу системийн зураглал, дизайныг гаргаж, богино хугацаанд хөгжүүлж, ашиглалтад оруулсан.

Зураг 7. ДБЧУ-ний өгөгдөл оруулах систем – high.eec.mn



Системийн зураглал хийж, хөгжүүлэхдээ БШУ-ы Сайдын А/240 тушаалын хавсралтын дагуу Байгууллагын гүйцэтгэл, Сургалтын хөтөлбөр болон Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд ИДС-иудын үзүүлэх үр нөлөө гэсэн 3 шалгуур үзүүлэлтээр хөгжүүлсэн. Дотоодын эрэмбийг Байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтэд суурилан тогтоох учир 2023 оны 6-7 дугаар сард ажлын хэсэг ажиллахдаа зөвхөн Байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийн дата өгөгдөл цуглуулж, эцэслэсэн бөгөөд Сургалтын Хөтөлбөр, Тогтвортой хөгжил гэсэн хоёр үзүүлэлтийн хувьд системийн хөгжүүлэлтийн эхний шатанд, үндсэн үзүүлэлтийг оруулсан байдалтай хэвээр байна.



Шалгуур үзүүлэлт бүрийн “дэлгэрэнгүй” цэсээр орж, нотлох баримтын мэдээллийг харах боломжтой. Шалгуур үзүүлэлт бүрийн “тайлан татах” цэсээр, тухайн үзүүлэлтийн нэгдсэн тоон үзүүлэлтийг татах боломжтой.


ИДС-иуд [highreport.eec.mn](https://highreport.eec.mn) системд өөрсдийн сонголтоор, 2 байдлаар дата өгөгдлөө оруулсан.

1. Салбар сургуулийн эрхээр дата өгөгдлөө оруулж, төв эрх дээр зөвхөн тоон үзүүлэлт нь нэгтгэгдэх
2. Төв эрх дээрээ бүх салбар болон төв сургуулийн дата өгөгдлөө нэгтгэж оруулах

Үйл ажиллагаа эхлэхийн өмнө системтэй ажиллах сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд системтэй ажиллах Гарын Авлагыг боловсруулж ИДС-иудад хүргүүлсэн.

Дата өгөгдөл оруулж дууссаны дараа системд бодолтыг оруулан, эрэмбийг тооцох бөгөөд олон нийтэд нээлттэй харуулах вэбсайт нь <https://highreport.eec.mn/> сайт юм.

Зураг 8. ДБСБ-ын эрэмбийн жагсаалтын вэбсайт



БШУ-ны Сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/343 тоот тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбийг эцэслэн тогтоох тушаал гарсны дагуу <https://high.eec.mn/> системийн эрхийг ИДС-иудад сэргээн өгч, дата мэдээллээ цаг тухайд нь оруулах, А/50 тушаалын хэрэгжилтийн хүрээнд ажилласан ажлын хэсгийн хянан баталгаажуулсан мэдээллийн дагуу засах (нэмэх, хасах) үйл ажиллагаа хийгдсэн.

Үүний тулд анх <https://high.eec.mn/> сайтад анх зохиогдсон хувилбарт нь хөгжүүлэлт хийх, боловсронгуй болгох бодитой шаардлага үүссэн. Сайтын хэрэглээний ойлгомжтой байх, ИДС-иудад ашиглахад хялбар байдлыг дэмжихийн тулд хөгжүүлэлтийн багт нийт 18-20 төрлийн өөрчлөлт хийх, засварлах, өргөтгөх саналыг хүргүүлсэн.

- Шалгуур үзүүлэлт бүрээр тоон мэдээллийг татах боломжтой болгох
- Багшлах бүрэлдэхүүн, эрдэм шинжилгээ, тэтгэлэг зэрэг бүх үзүүлэлтүүдийг Excel-ээр нарийвчлан татдаг болгох (нэр, РД гм. дэлгэрэнгүй дотор тайлан татдаг болох) – Дэлгэрэнгүй дотор “Xls татах” цэсийг шалгуур үзүүлэлт бүрд хийх
- Багшийн жагсаалтын багана дээр h-index>10, Wos, Scopus 5 жилд, ОУ төслийн тоо, ОУ мэргэжлийн редакц/тоогоор, ОУ холбоо/тоогоор - мэдээлэл 1-р нүүрэндээ гарч ирдэг, excel-ээр нэг дор татагддаг болгох
- Үзүүлэлтүүд: Дотоодын хамтарсан хөтөлбөрөөр суралцагчийн тоо + Гадаадтай хамтарсан хөтөлбөрөөр суралцагчийн тоо + Цахим болон танхим хосолсон хөтөлбөрт суралцагчийн тоо + Үндсэн хөтөлбөрөөр суралцаж буй нийт гадаад суралцагчдын тоо + Хамтарсан хөтөлбөрөөр суралцаж буй нийт гадаад суралцагчдын тоог гаргахдаа зөвхөн идэвхтэй суралцагчдаас гаргах
- Захиргаанд ажилладаг багшийн бүртгэх цонх нэмэх, үндсэн, гэрээт гэдгээр нь салгаж утга авах гм.

Хэрэглээний хялбар байдлыг дэмжсэн өөрчлөлтийг системийн багтай хэд хэдэн удаа уламжилж хэрэгжүүлсэн бөгөөд туршилт хийж, системийг хүлээж авсан. ИДС-иуд дата оруулах явцад үүсэх асуудлыг шийдвэрлэж, мэдээлэл өгч ажилласан.

## **5. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРЭМБЭ ТОГТООХ АРГАЧЛАЛ**

Дээд боловсролын сургалтын байгууллагууд ихэвчлэн хөндлөнгийн, гуравдагч байгууллагуудаар эрэмбэ тогтоолгодог. Олон улсын их сургуулийн эрэмбэ нь төрийн бодлого болон окутан сурагчид, тэдний гэр бүл, бусад оролцогч талуудад нөлөөлдөг бөгөөд дэлхийд 20 гаруй байгууллагын түгээмэл хэрэглэгдэж байгаа дээд боловсролын эрэмбийн аргачлал хэрэглэгдэж байна. Энэхүү аргачлалыг боловсруулахдаа их сургуулиудын эрэмбэ тогтоодог олон улсын байгууллага болох Times Higher Education байгууллагаас аргагүйн зөвлөгөө авч боловсруулсан болно.

БШУ-ны Сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/50 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны урьдчилсан эрэмбэ тогтооход ашигласан буюу сургуулиудын мэдүүлсэн 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг газар дээр нь очиж танилцан, хянан баталгаажуулсан. Энэ удаагийн эрэмбэ нь гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийн хувьд өөрчлөлтгүйгээр, зөвхөн хянан баталгаажуулсан тоон өгөгдөлд тулгуурлан дахин бодолт хийж, эрэмбийг эцэслэн тогтоох зорилготой болно. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг дөрвөн чиглэлээр ангилсан.

**1. СУРГАЛТ:** 1.1 Багш, суралцагчийн харьцаа 1.2 Хөтөлбөр, багшийн харьцаа 1.3 Доктор зэрэгтэй багш 1.4 Доктор зэрэгтэй багш, ахисан түвшний суралцагчийн харьцаа 1.5 Гэрээт багш 1.6 Ахисан түвшний суралцагч 1.7 Төгсөгчдийн мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхлэлт 1.8 Тэтгэлэгтэй суралцаж байгаа суралцагч 1.9 Элсэлтийн ерөнхий шалгалтын оноо 1.10 Хамтарсан хөтөлбөр 1.11 Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл 1.12 Сургалтын үйл ажиллагааны сэтгэл ханамж

**2. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ:** 2.1. Нэр хүнд бүхий судлаач 2.2. h-индексстэй судлаач багш 2.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл 2.4. Эшлэл 2.5. Үйлдвэрлэлийн газартай хамтарсан эрдэм шинжилгээний өгүүлэл 2.6. Гадаадын эрдэмтэдтэй хамтарсан эрдэм шинжилгээний өгүүлэл 2.7. Суралцагчийн эрдэм шинжилгээний өгүүлэл 2.8. Постдоктор судлаач 2.9.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын орлого 2.10. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулж буй зардал 2.11. Мэдлэг дамжуулалт

**3. ГАДААД ХАРИЛЦАА:** 3.1 Гадаад багш 3.2 Гадаад суралцагч 3.3 Хамтын ажиллагаа 3.4 Англи хувилбартай баримт бичиг 3.5 Англи хэл дээр заагдаж буй хичээл

**4. ОРЧИН, ҮЙЛЧИЛГЭЭ:** 4.1 Дотуур байрны хүрэлцээ хангамж 4.2 Бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн орчин 4.3 Номын сан 4.4 Интернет, WiFi-н хүртээмж 4.5 Мэдээлэл харилцаа технологийн дэд бүтэц 4.6 Тусгай хэрэгцээт суралцагсдад үзүүлэх дэмжлэг 4.7 Оюутны удирдлагатай байгууллага 4.8 Эрүүл мэндийн үйлчилгээ 4.9 Сургалтын орчны талаарх санал асуулга 4.10 Нийгмийн хариуцлага 4.11 Сургуулийн нийгмийн үйлчилгээний сэтгэл ханамж

ДБСБ-ын чанарын үнэлгээ, эрэмбэ бодох аргачлал нь доорх дарааллаар хэрэгжсэн болно.

### 1. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт тодорхойлох, хянах

Хянан баталгаажуулах ажлын хэсэг гүйцэтгэлийн үзүүлэлт цуглуулах явцад сургуулиудаас гарсан саналын дагуу дараах үзүүлэлтүүдийг ангилан цуглуулсан байна. Үүнд:

- Үндсэн багшаас захиргаанд ажилладаг багш
- Үндсэн багшаас захиргаанд ажилладаг доктор

Хэд хэдэн гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг тодорхойлоход үндсэн орон тооны багш, үндсэн орон тооны доктор багшийн тоог ашиглаж буй бөгөөд зарим сургуулиудад доктор багш нар нь хичээл заахгүйгээр захиргаанд тодорхой хугацаагаар томилогдон ажиллаж байгаа тул тэдгээр багш нарын мэдээллийг зарим шаардлагатай түлхүүр үзүүлэлтэд харгалзан үзэх нь зүйтэй юм.


Энэхүү хоёр үзүүлэлт нөлөөлөх гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд:

Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт	Өөрчлөх үндэслэл
1-1. Багш, суралцагчийн харьцаа	Нийт багш нараас захиргаанд ажилладаг багш нарыг хасаж зөвхөн сургалтад оролцдог багш нараар тооцох
1-2. Багш, хөтөлбөрийн харьцаа	
1-4. Доктор багш, ахисан түвшний суралцагчийн харьцаа	
1-5. Гэрээт багшийн эзлэх хувь	
2-9. Нэг багшид ногдох ЭШ, судалгааны ажлын орлого	
2-10. Нэг багшид ногдох ЭШ, судалгааны ажилд зарцуулж буй зардлын эзлэх хувь	
3-1. Гадаад багшийн эзлэх хувь	

Дээр хүснэгтэд дурдсан гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг тодорхойлох аргачлалаас бусад аргачлалд өөрчлөлт ороогүй буюу "Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ тогтоох аргачлал-2023"-д заасан аргачлалын дагуу тодорхойлогдсон болно.

## 2. Тоон өгөгдлийн тархалт байгуулах шалгах, онцгой өгөгдлийг хянах, засварлах

2023 онд ДБСБ-ын урьдчилсан эрэмбэ тогтооход Times Higher Education олон улсын үнэлгээний байгууллагаас тухайн гүйцэтгэлийн үзүүлэлтийн тоон өгөгдлүүдийг сургууль бүрээр харьцуулан судлах зөвлөмж ирүүлсэн. Энэхүү зөвлөмжийн хүрээнд цуглуулсан өгөгдлийн нийцтэй байдлыг үзүүлэлт тус бүрээр тархалт байгуулан шалгасан. Ингэж шалгасны хүрээнд зарим онцгой өгөгдлүүдийг илрүүлэх боломжтой бөгөөд дахин шалгах, нягтлах шаардлага бий болдог. Тухайлбал нийт суралцагсдын дотор тэтгэлгээр суралцаж буй оюутны хувийн тархалтыг байгуулж үзэхэд дараах хэлбэртэй болсон байна.



Энэ графикаас харахад дийлэнх сургууль нийт суралцагчдын 10-с бага хувьд тэтгэлэг олгодог байхад 2 сургууль оюутнуудынхаа 60-с дээш хувьд тэтгэлэг олгосон гэсэн тоон мэдээлэл оруулсан байна.

Энэ зарчмаар онцлох мэдээллүүдийг тархалтын дагуу тодорхойлон хяналтын ажлын хэсэгт уламжлан, хянан баталгаажуулах үйл ажиллагаа явагдсан.

## 3. Тоон өгөгдлөөс хамааруулж сургуулиудыг кластерт ангилах

Сургуулиудын багтаамж нь харилцан адилгүй тохиолдолд зарим үзүүлэлтүүдийг ижил зарчмаар оноожуулах нь зохимжгүй байдаг талаар Times Higher Education байгууллагаас зөвлөмж ирүүлсэн. Тухайлбал том буюу 500 багштай сургуулийн 40% (200) нь доктор, жижиг буюу 50 багштай сургуулийн 40% (20) нь доктор байвал адилхан 40%-н доктор гэж тооцоологдон ижил оноо өгөхөөр байна. Гэтэл том сургуулийн хувь дахь 200 доктор, жижиг сургуулийн 20 доктор нь хүний нөөцийн бүрдлийн хувьд ялгаатай, өөрөөр хэлбэл 200 доктор нь 20 доктороос илүү потенциалтай тул докторын эзлэх хувийг тооцоход 200 доктортой сургууль нь жижиг сургуулиасаа өндөр оноо авах нь зохимжтой гэсэн зөвлөмж өгсөн. Энэхүү зарчимд тулгуурлан а) Суралцагчийн тоо б) Багшийн тоо в) Хөтөлбөрийн тоо гэсэн 3 үндсэн үзүүлэлтээс хамаарч 6 шатлалд ангилсан аргагүйг тодорхойлсон. Хэрхэн ангилсан талаарх үзүүлэлтийг дараах хүснэгтэд харуулав.

Үзүүлэлт	Ангилал үүсгэх тоо /хүртэл/
----------	-----------------------------

	1	2	3	4	5	6
Суралцагчийн тоо	500	1000	2500	5000	10000	10000+
Хөтөлбөрийн тоо	5	10	25	50	100	100+
Багшийн тоо	25	50	125	250	500	500+

Шинэчилсэн өгөгдлийн хүрээнд сургуулиудыг суралцагч, багш, хөтөлбөрийн тооноос хамааруулан кластерт хуваасан. Дээрх 3 үзүүлэлтээс хамаарсан гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг оноожуулахдаа тухайн ангилалд орж буй сургуулиудад ижил томъёоллоор тооцсон.

#### **4. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт бүрийн хувьд кластер бүрд тохирсон үнэлгээний аргачлалыг тодорхойлох**

Times Higher Education байгууллагаас ирүүлсэн хамгийн гол зөвлөгөө нь тухайн үзүүлэлтийг оноожуулахдаа тухайн үзүүлэлтэд тооцсон гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийн утгуудын тархалтаас хамааруулж, хамгийн өндөр үзүүлэлт бүхий сургуульд өндөр оноо, дараагийн хэсэгт хамаарах сургуульд дараачийн шатлалт оноо, хамгийн бага үзүүлэлттэй сургуульд харгалзах бага оноо өгөх зарчмаар оноожуулах нь зүйтэй гэсэн зөвлөгөө байсан. Энэхүү зарчим нь хамгийн сайнд нь бүрэн бүрэн оноо өгөх буюу уралдуулах зарчим юм. Үүний тулд тухайн тооцоолсон KPI-н давтамжийн график буюу гистограмыг байгуулах шаардлагатай бөгөөд шинэчилсэн өгөгдлүүдийн хувьд гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт бүрд гистограмыг байгуулсан. Оноог шугаман эсвэл шаталсан онооны систем ашиглан бууруулах зарчмаар тодорхойлох зөвлөмжийн хүрээнд энэ удаагийн үнэлгээнд шаталсан онооны системийг ашигласан.

#### **5. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт бүрийн үнэлгээнд суурилан ДБСБ бүрийн эцсийн эрэмбийг тодорхойлох**

Times Higher Education байгууллагатай хамтран тодорхойлсон 39 гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг нийт 4 үндсэн багцад ангилсан. Үүнд 1. Сургалт, 2. Эрдэм шинжилгээ, 3 Гадаад харилцаа, 4.Орчин, үйлчилгээ болно. Сургалт багцад нийт 12KPI, Эрдэм шинжилгээ багцад 11KPI, Гадаад харилцаа багцад 5KPI, Орчин үйлчилгээ багцад 11KPI харгалзаж байна. Энэ удаагийн эрэмбэ тогтоох үйл ажиллагаа нь 2023 онд тодорхойлсон урьдчилсан эрэмбийн өгөгдлийг хянан баталгаажуулсны хүрээнд дахин тодорхойлох үйл ажиллагаа тул гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийн нэр, түүнийг тодорхойлох аргачлалд өөрчлөлт ороогүй. Харин гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийн тархалт яаж өөрчлөгдсөнөөс хамааруулж онооны шаталсан схем өөрчлөгдсөн.

39 гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт тус бүрдээ ач холбогдлоос хамаарсан авах хамгийн их оноотой бөгөөд үүнийг гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт тус бүрээр сургуулиудыг харьцуулан оноожуулсан. Түүний дараа эцсийн эрэмбийн үнэлгээг тодорхойлохдоо 4 багцын ач холбогдлоос хамааруулан багцын хувийн жинг тодорхойлсон. Олон улсын эрэмбэ тогтоох байгууллагуудын ашиглаж буй багцын хувийн жинг дараах хүснэгтэд харуулав.



№	QS World University Rankings@	Times Higher Education World University Ranking	Academic Ranking of World Universities (ARWU)	Монгол улсын ДБСБ-ын эрэмбэ тогтоох
1.	Academic reputation (40%)	Teaching 30%	Alumni 10%	Teaching (40%)
2.	Employer reputation 10%	Research 30%	Highly cited researchers (20%)	Research (30%)
3.	Student-to-faculty ratio (20%)	Research citations (30%)	Papers in Nature and Science (20%)	International outlook (10%)
4.	Research citations per faculty member (20%)	Industry income (2.5%)	Papers indexed (20%)	Environment(Academic reputation) (20%)
5.	Proportion of international faculty (5%)	International outlook (7.5%)	Per capita performance (10%)	
6.	Proportion of international students (5%)		Awards (20%)	
	100	100	100	100

Дээрх хүснэгтээс харахад олон улсын эрэмбийн аргачлалд Эрдэм шинжилгээтэй холбогдох үзүүлэлтийн эзлэх хувийн жин харьцангуй өндөр байна. Тухайлбал Times Higher Education байгууллагын олон улсын эрэмбэ тогтооход ашиглаж буй аргачлалд Эрдэм шинжилгээтэй холбогдох үзүүлэлтийн эзлэх хувийн жин 60%-с дээш байна. Монгол улсын хувьд 2023 оны эрэмбэ тодорхойлохдоо Эрдэм шинжилгээний үзүүлэлтийг өндөр хувийн жинтэйгээр тодорхойлохыг оролдсон боловч уг багцад хамаарах үзүүлэлтээр оноо авсан сургуулиудын тоо харьцангуй бага байсан. Дийлэнх сургуулиуд нь сургалт давамгайлсан үйл ажиллагаа эрхэлж байсан тул Сургалтын багцын эзлэх хувийн жинг 40%, Эрдэм шинжилгээний багцын эзлэх хувийн жин 30%, Гадаад харилцаа 10%, Орчин, үйлчилгээ 20% байхаар тогтсон. Ер нь дараачийн эрэмбэ тогтоох үйл ажиллагаанд олон улсын жишгийн дагуу Эрдэм шинжилгээний үзүүлэлтийн эзлэх хувийн жинг өсгөх шаардлагатай. Энэхүү багцын эзлэх хувийн жинг Монгол улсын бодлого, өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан дотооддоо тодорхойлохыг Times Higher Education байгууллагаас зөвлөсөн.

Олон улсын үнэлгээний Times Higher Education байгууллага нь их сургуулиудын эрэмбэ (rank) тогтоодог байгууллага бөгөөд энэхүү байгууллага нь зарим үнэлгээний байгууллагуудаас давхар гаргадаг их сургуулиудын чансаа (rating)-г тусгайлан авч үздэггүй буюу гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт бүрийг эрэмбийн хүрээнд хамааруулан тодорхойлдог. Иймээс Монгол улсын хүрээнд хийгдсэн энэ удаагийн үнэлгээ нь зөвхөн "эрэмбэ" гэсэн агуулгаар хийгдсэн бөгөөд QS зэрэг байгууллагын гаргадаг чансааны үзүүлэлтүүд нь энэхүү эрэмбийн үзүүлэлтүүдэд агуулагдсан болно.

Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт тус бүрээр авсан онооноос 4 үндсэн багцын нийлбэр оноог тодорхойлж, дараа нь 4 багц хооронд хувийн жинг дээр дурдсаны дагуу оноон нийлбэрчилж эцсийн оноог гарган ихээс бага утга руу эрэмбэлэн жагсаалтыг гаргасан.

## 6. Эрэмбийн системд байрших үзүүлэлтүүдийг тодорхойлох

Эрэмбийн системд 2023 оны урьдчилсан эрэмбийг зарласан жишгийн дагуу нийт онооноос авсан онооны эзлэх хувь, 4 багц бүрийн нийт онооноос авсан онооны хувь болон тухайн багц доторх гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт бүрийн тухайн үзүүлэлтээр авах хамгийн их онооноос авсан хувийг тооцоолж, эрэмбийн системд хүлээлгэж өгсөн.

Гүйцэтгэлийн 39 түлхүүр үзүүлэлт бүрийн тодорхойлолт болон үндэслэл, зорилго, түүнчлэн өгөгдлийн эх үүсвэр, тооцсон хугацаа, томъёолол болон математик томъёог Хавсралтаас үзнэ үү.

Эрэмбэ тогтоох үйл ажиллагаанд дээд боловсролын салбарын гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг дүгнэхдээ харьцуулан дүгнэх зарчимд тулгуурлагдана. Өөрөөр хэлбэл бодит гүйцэтгэлийн утгууд нь судалгаанд хамрагдаж буй бусад сургуулиудын аль хэсэгт хамаарч буйд тулгуурлан харгалзах гүйцэтгэлийн үнэлгээ буюу оноо тодорхойлогдоно. Сургуулиудын харьцуулсан утгууд буюу тархалтад тулгуурлан хамгийн өндөр хэсэгт хамаарч буй сургуулиуд нь хамгийн өндөр оноог авна. Харьцуулсан утгаар хамгийн бага хэсэгт хамаарах сургуулиуд нь хамгийн бага оноо авна. Энэхүү зарчим нь судалгаанд хамрагдаж буй сургуулиудад ялгаатай оноо өгч, эрэмбэ үүсгэх үндсэн зарчим болж байна. Эндээс үзэхэд өндөр эсвэл бага үзүүлэлт бүхий сургуулиудын нийлбэр үнэлгээг абсолют утгаараа маш сайн, эсвэл маш муу гэж дүгнэхэд өрөөсгөл бөгөөд тухайн судалгаанд хамрагдсан сургуулиудын хүрээнд л маш сайн эсвэл муу гэж үнэлэгдэж буй харьцангуй үзүүлэлт юм. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг 4 багцад хуваан тус тусад нь үнэлгээ өгч буй хэдий ч тухайн багц үзүүлэлт бүрийн нийлбэр үнэлгээнд эзлэх хувийн жингүүд чухал нөлөөтэй юм. Монгол улсын ДБСБ-ууд нь өнөөгийн нөхцөл байдалд сургалт давамгайлсан үйл ажиллагааг түлхүү явуулж буй тул тухайн багцын гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийн тооноос үл хамааруулан Сургалтын багц үзүүлэлтийн нийлбэр үнэлгээг нийт эрэмбийн эцсийн үнэлгээний 40%, Эрдэм шинжилгээ-30%, Гадаад харилцаа-10% болон Орчин, үйлчилгээний багцыг 20% байхаар авч үзсэн болно. Цаашид олон улсын аргачлалын нийтлэг жишгийн дагуу эрдэм шинжилгээний эзлэх хувийн жин нэмэгдэх нь зүйн хэрэг юм. ДБСБ-уудын урьдчилсан эрэмбэ тогтоох энэхүү аргачлалыг цаашид улам боловсронгуй болгох шаардлага бий.

Боловсролын чанарын судалгааны хүрээлэнгийн судлаачдын бэлтгэн ирүүлсэн ДБСБ чанарын үнэлгээний эрэмбэ тооцох аргачлалын гарын авлагыг тус тайлантай хавсарган хүргүүлнэ.

## **6. ЭРЭМБИЙН ҮР ДҮН**

ДБСБ-ийн хянан баталгаажуулсан өгөгдөлд тулгуурлаж, дахин бодолт хийсэн үр дүнг нэгдсэн дүн, сургалт, эрдэм шинжилгээ, гадаад харилцаа, орчин үйлчилгээ гэсэн бүлэг үзүүлэлтүүдэд хамаарах түлхүүр үзүүлэлтийн үр дүнгийн хамтаар Тайлангийн төгсгөлд хүснэгтлэн үзүүллээ.

БШУС-ын А/50 тушаалын ажлын хэсгийн хянан баталгаажуулсан эцсийн дата өгөгдлийн үр дүнд бодсон эрэмбэ нь 2023 оны урьдчилсан эрэмбээс ялгаатай гарч байна. Энэ нь тайлангийн 3.2-т дурдсан үйл ажиллагаа, хүчин зүйлстэй холбоотой бөгөөд эрэмбийн бодолт, үндсэн аргачлалд өөрчлөлт ороогүй болно.

1. Нэгдсэн дүн

Эрэмбэ	Сургуулийн нэр	Сургалт	Эрдэм шинжилгээ	Гадаад харилцаа	Орчин үйлчилгээ	Нийт
1	МУИС /Монгол улсын их сургууль/	85.6	95.0	41.4	78.3	82.5
2	АШУУИС /Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль/	87.6	83.3	52.9	78.3	81.0
3	ШУТИС /Шинжлэх ухаан технологийн их сургууль/	86.8	72.1	37.1	81.7	76.4
4	МУБИС /Монгол улсын боловсролын их сургууль/	88.4	62.9	58.6	76.7	75.4
5	ХААИС /Хөдөө аж ахуйн их сургууль/	70.4	62.5	37.1	75.8	65.8
6	Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль	65.6	39.6	51.4	82.5	59.8
7	Санхүү, эдийн засгийн их сургууль	87.2	28.3	37.1	61.7	59.4
8	Отгонтэнгэр их сургууль	73.6	42.1	40.0	65.8	59.2
9	Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль	70.8	41.3	25.7	77.5	58.8
10	ХУИС /Хүмүүнлэгийн ухааны их сургууль/	75.6	43.8	41.4	55.8	58.7
11	СУИС /Соёл урлагийн их сургууль/	70.0	32.9	51.4	75.0	58.0
12	Мандах их сургууль	72.4	31.7	44.3	60.8	55.1
13	ДХИС /Дотоод хэргийн их сургууль/	76.0	6.3	27.1	85.8	52.2
14	Олон улсын Улаанбаатарын их сургууль	71.2	17.5	51.4	62.5	51.4
15	ҮБХИС /Үндэсний батлан хамгаалахын их сургууль/	60.8	27.5	25.7	80.0	51.1
16	Сити их сургууль	52.4	40.4	52.9	60.0	50.4
17	ИЗОУИС /Их засаг олон улсын их сургууль/	56.4	10.0	74.3	78.3	48.7
18	Этүгэн их сургууль	72.0	11.7	31.4	65.8	48.6
19	Ач анагаах ухааны их сургууль	58.8	28.3	38.6	59.2	47.7
20	Улаанбаатар эрдэм их сургууль	56.8	27.9	52.9	55.8	47.5
21	Шинэ монгол технологийн дээд сургууль	57.6	35.4	11.4	63.3	47.5
22	МУИС /Монголын үндэсний их сургууль/	55.2	20.8	55.7	67.5	47.4
23	Оточ манрамба их сургууль	44.0	42.9	35.7	65.8	47.2

24	Эм Ай Ю дээд сургууль	47.6	15.4	78.6	70.8	45.7
25	Идэр их сургууль	63.2	6.7	65.7	56.7	45.2
26	Удирдлагын академи	54.4	33.3	14.3	57.5	44.7
Мэргэжлийн их сургуульд тавих 3 тусгай шаардлын магистрын зэрэг олгох хөтөлбөрийн тоо-3, шинэглэх ухааны нэг чиглэл дараасан хөтөлбөрийн аалж хувь-78%, ахисан түвшний суралцагчийн эзлэх хувь-70%, докторын зэрэгтэй үндсэн багшийн аалж хувь-49%, И-индексстэй үндсэн багшийн аалж хувь-13%, нэг багшид ногдох эрдэм шинжилгээний ажилд зарцуулж бүтэц зардал >1 их (1,694 000 төгрөг) үзүүлэлтүүд тус тус шаардлага хангасан. Олон улсын эрдэм шинжилгээний бүтээлийн санд бүртгэлтэй бүтээлийн тоо-3, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн дотоодын сэтгүүлд үзүүлсэн өгүүллийн тоо-4 зэрэг үзүүлэлт шаардлага хангаагүй байна.

### ДҮГНЭХ НЬ:

Технологийн дээд сургууль нь дээд боловсролын сургалтын байгууллагад тавих нийтлэг шаардлагыг 95%, мэргэжлийн их сургуульд тавих тусгай шаардлагыг 75% биелүүлдэг байх тул МЭРГЭЖЛИЙН ИХ СУРГУУЛИЙН ШАЛГУУРЫГ **ХАНГАСАН** гэж дүгнэв.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ



Ж.АРИУНБОЛД

## ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

№

2025 оны 05 сарын 07 өдөр

**Хэлэлцсэн асуудал:** Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтийн дүгнэлтийг хэлэлцэх.

**Хуралын ирц:** Ж.Ариунболд, Л.Лхагвасүрэн, Ч.Лодойравсал, Б.Очирхуяг, Б.Дамдиндорж, Т.Намнан, Лхагвасүрэн, Ж.Цэцэгмаа, Б.Нэмэхбаатар, Я.Эрдэнэсүрэн, Б.Мягмарренчин нарын бүрэлдэхүүнтэй, нийт гишүүдийн 11 буюу 73% ирцтэй хуралдав.

- Б.Мөнхбаяр гадаадад томилолттой тул цахимаар санал өгөв.
- С.Нямзагд – чөлөөтэй.

Хуралыг Сайдын зөвлөх Д.Гантулга нээв.

Ж.Ариунболд: Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дээд сургуулиудыг 2025 оны 6 дугаар сарын 15-аас өмнө их сургууль болон коллеж болгон шилжүүлэх ажлыг бүрэн гүйцэтгэх шаардлагатай. Энэ хүрээнд ажлын хэсэг ажиллаж, дүгнэлтээ боловсруулсан бөгөөд одоо Дээд боловсролын зөвлөлөөр хэлэлцэж, олон нийтэд танилцуулахаар төлөвлөж байна. Хуулийн хугацаа тулгарсан тул ажлыг яаравчлан гүйцэтгэж байгаа.

Хоёр дахь асуудал нь сайдын өгсөн гол чиглэлтэй холбоотой. Энэ чиглэл нь сургуулийг шууд хаах, академик эрх чөлөөнд халдах бус, зөвлөмж, дүгнэлт гаргах замаар тодорхой шалгуур, шаардлагыг ил тод тавьж, түүнийг хангаж буй тохиолдолд дэмжин ажиллах бодлого баримтаж буйг онцолсон. Бидний зүгээс ч энэ бодлогын хүрээнд ажиллаж байна.

Дээд боловсролын байгууллагуудыг ангилал ажлын эхний шатны судалгааг 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн. Энэхүү процесс дараах байдлаар явагдсан. Эхлээд ажлын хэсэг байгуулагдсан. Үүний дараа нийт 30 гаруй дээд сургуульд хуваарилан ажилласан бөгөөд ажлын хэсэг хоёр багт хуваагдсан. Нэгийг нь би өөрөө ахалж, нөгөө багийг Энхтөр дарга ахалсан. Нарийн бичгийн үүргийг Дээд боловсролын газрын шинжээч Номинцэцэг болон мэргэжилтэн Д.Ганцэцэг нар гүйцэтгэж ажилласан.

Ажлын явцын талаар товч танилцуулъя. Бүх сургуульд очиж, нийтлэг 16 шаардлага, тусгай 10 шаардлага гэсэн нийт 26 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн. Ажлын хэсгийн гишүүд тухайн чиглэлээрээ дагнан ажилласан. Жишээлбэл, МУИС дээр хөтөлбөрийн үнэлгээг нэг гишүүн хийсэн бол, ШУТИС дээр мөн ижил чиглэлээр үнэлгээ хийгдсэн.

Дүгнэлтийг гаргахдаа бүх мэдээллийг Excel дээр нэгтгэж, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан. Номинцэцэг, Д.Ганцэцэг нар мэдээллийг нэгтгэн дүгнэлтийг боловсруулсан. Техникийн зохицуулалтын хувьд бүгдэд танил болсон гэж үзэж байна.

Дүгнэлтийн хувьд нийт 3 ангилалтай: Бүрэн хангасан, Хангасан, Хангаагүй

Ийнхүү өнөөдрийн хурлын хүрээнд бэлтгэл ажил хангагдсан бөгөөд дүгнэлтийг Д.Ганцэцэг танилцуулна. Протоколын бичвэрийг Номинцэцэг боловсруулна.

Д.Ганцэцэг: Техникийн зохицуулалтын үнэлгээний аргачлалыг танилцуулав. Дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 32 дээд боловсролын сургалтын байгууллага, шинээр сургууль байгуулах ангилал тогтоох хүсэлт гаргасан 3 буюу нийт 34 дээд

боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоосон ажлын хэсгийн дүгнэлтийг дээд боловсролын зөвлөлд танилцууллаа. /нарийн бичиг/

#### ХЭЛЭЛЦСЭН:

1.ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ИХ СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын үнэлэх боломжгүй, Судалгааны их сургуульд санал ирүүлсэн 38%-ийг хангасан. Мэргэжлийн их сургуулийн шаардлагын 80% хангасан. Мэргэжлийн их сургуулийн 10 шаардлагын 8 шаардлагыг биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Мэргэжлийн их сургууль"*

Ж.Ариунболд: Сургууль бүгдийг сонсцоод явах уу. Яаж явах вэ гучаад сургууль байгаа. Бүгдийг сонсоод явна гэвэл мартчих байх .

Ч.Лодойравсал: Зарим нь онцгой, зарим адил байгаа учир яриад явъя.

Ж.Ариунболд: ШУАИС дээр 2024 онд Монгол улсын засгийн газраас байгуулагдсан. Энэ сургууль байгуулагдаад ерөөсөө шинээр нээсэн сургууль, суралцагч байхгүй, хөтөлбөр хэрэгжүүлээгүй, БМИҮЗ-өөс 10 хөтөлбөрийн санал ирсэн. Ихэнх хөтөлбөр нөхцөлтэйгээр магадлан итгэмжлэгдсэн. Засгийн газрын тогтоол гарсан бид иймд коллеж болгох боломжгүй байна. Техникийн зохицуулалтад төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа сургуулиудыг коллеж болгож болгохгүй мэргэжлийн болгоно гэсэн заалт байгаа, дараагийн судалгааны, сургалтын, мэргэжлийн их сургууль гэсэн ангиллаас хамгийн бага шалгууртай нь "мэргэжлийн их сургууль" байна. Тэгээд та бүхний саналыг сонсьё. Тэмдэглэл дээрээ нэмэлт саналаа бичээд яваарай.

Ч.Лодойравсал: Цаашид бид яах вэ. Шинэ сургууль хүсэлт гаргахад яг энэ шиг нөхцөл үүснэ. Бид шалгаж чадахгүй, цаашид зохицуулалт хууль эрх зүйн хувьд яаж шийдэгдсэн байгаа вэ. Шийдэгдээгүй бол шийдэх гарцыг харж шийдэхгүй бол болохгүй байх. Мэргэжлийн их сургууль гээд тавихаар ерөөсгөл, эсвэл хүсэлт тавьснаас хойш хэдий хугацааны дараа шалгах ёстой вэ энэ зохицуулалтыг яриад явъя. Хэрвээ зохицуулалт байхгүй бол шийдэж өгөх нь байна. Нэг сургууль хүсэлт өглөө тэр үед бид эхлээд шалгах юм уу эсвэл хэсэг хугацааны дараа шалгах юм уу.

Ж.Ариунболд: Техникийн зохицуулалтын дагуу сургууль 4 жил тутам хүсэлтээ өгөөд ангиллаа тогтоож болно. Шинээр байгуулагдаж байгаа сургуульд орчин нөхцөлийг үзээд явуулж байгаад 4 жилийн дараа буюу тухайн сургууль төгсөлт хийсний дараа буцааж ангилал тогтоох зохицуулалт техникийн зохицуулалт дээр байгаа. Өөрөөр хэлбэл 4 жилийн дараа дахин хүсэлт өгөөд явна гэсэн үг. Энэ сургууль нэг онцлог нь төрийн сургууль мөн техникийн зохицуулалт гарахаас өмнө Засгийн газрын тогтоол батлагдсан учир зөрчилтэй байна.

Ч.Лодойравсал: засгаар ороход зэрэглэл байгаагүй

Ж.Ариунболд: байгаагүй

Я.Эрдэнэсүрэн: Энэ ажлын хэсэгт орж ажилласан. Шинжлэх ухааны академи их сургууль дээр ажилласан. Гол онцлог нь Засгийн газрын тогтоолтой, сургалт хийхээр төлөвлөлт хийсэн. Барилга байгууламж барихаар төсөв тавигдаад явж байна. 4 жилийн дараа сургалт нь яваад нэг төгсөлт хийгээд тэр хооронд орчин нөхцөлөө бүрдүүлээд дахиад дүгнэх боломжтой. Энэ сургуулиас бусад нь урьд нь сургалт явуулж байсан учраас асуудалгүй. Багш нарын бүрдүүлэлт хүрээлэнгийн багш ажилтан байна.

Ж.Цэцэгмаа: Судалгааны их сургууль гэж орсон биз дээ. Ямар түвшний сургалт явуулах вэ.

Я.Эрдэнэсүрэн: Ахисан түвшний сургалт, багш нь хүрээлэнгийн ажилчид байгаа

Б.Очирхуяг: Шинжлэх ухааны чиглэл гэдгийг яаж тодорхойлсон бэ.

Д.Ганцэцэг: Мэргэжлийн чиглэлийн индексийн эхний 2 орон буюу ерөнхий чиглэлээр авсан.

Т.Намнан: мэргэжлийн их сургууль гэж үзэхээр доктор мэргэжил гэж үзэх үү. Төрийн албаны зөвлөлөөс ахисан түвшний мэргэжлийг мэргэжил гэж үзэхгүй гэдэг. Бакалавр бэлдэхгүй тийм ээ

Д.Ганцэцэг: тийм

Т.Намнан: Лодой зөвлөхийн хувьд хугацааны хувьд тогтохгүй бол шалгуурыг даваад шууд их сургууль болчихно гэж байхгүй тэгэхээр эрхлэх зөвшөөрлийг олгочоод 4 жилийн дараа өгөхгүй бол болохгүй байна.

Ж.Ариунболд: Ийм нөхцөл байдал үүсэж байна. Одоо ингээд ангилал хийхгүй бол энэ сургууль үйл ажиллагаа явуулах боломжгүй. Дөнгөж 2024 онд байгуулагдсан.

Т.Намнан: тусгай зөвшөөрөл гарсан уу.

Номинцэцэг: Тусгай зөвшөөрөл гараагүй.

Л.Лхагвасүрэн: төрийн ангилалтай болохоор бас ингэж байх шиг байна.

Я.Эрдэнэсүрэн: үйл ажиллагаа эрхлэхийн өмнө заавал ангилал тогтоолгох ёстой гэж шаардсан. Тэгэхээр хүсэлтийг үндэслэж тогтоолгох ёстой болоод байна. Цаашид ангилал заавал тогтоолгож байж сургалтын үйл ажиллагаа эрхлэх

Ж.Цэцэгмаа: Судалгааны их сургууль гэж гарсан юм чинь ангилал тогтсон юм биш үү

Б.Очирхуяг: Тэр үед ийм ангилал гараагүй байсан.

Ж.Цэцэгмаа: Гэхдээ судалгааны их сургууль гээд хуульд орсон байсан

Ж.Ариунболд: Судалгааны их сургуулийг Монгол Улсын Засгийн газраас УИХ-д өргөн бариад хууль батлагдаж байж үйл ажиллагаа явна. Энэ сургууль журам батлагдахаас өмнө болсон учраас зөрүүтэй байна.

Ж.Цэцэгмаа: ШУА дээр байгуулагдаж байгаа юм чинь судалгааны их сургууль биш үү

Ж.Ариунболд: Нэрийг нь тэгж өгсөн болохоос энэ бол БЯ-д харьяалагдаж байгаа. ШУА-ийн их сургууль гэж оноосон нэр. Харин тэр хүрээлэнг түшиж явна.

Б.Очирхуяг: Мэргэжлийн их сургууль гэдгээс өөр шийдэл байхгүй юм байна. Цааш нь явъя.

Ж.Ариунболд: та бүхэн саналаа бичээрэй. Дэмжинэ, дэмжихгүй гэдгийг, нэмэлт саналтай бол саналаа бичээрэй.

**2. ШИНЭ МОНГОЛ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ:** нийтлэг шаардлагын 95% хангасан, Сургалтын их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 50%-ийг хангасан. Мэргэжлийн их сургуулийн шаардлагын 63% хангасан. Мэргэжлийн их сургуулийн 10 шаардлагын 5 шаардлагыг биелүүлсэн.  
*Ажлын хэсгийн дүгнэлт: "Мэргэжлийн их сургууль"*

Ж.Ариунболд: 80-аас дээш хангасан гэсэн үнэлгээ нь нийтлэг шалгуур болон тусгай шаардлагын дундаж үзүүлэлтээр гарч байгаа.

Ж.Цэцэгмаа: Бакалаврын хэдэн хөтөлбөр хэрэгжүүлж байна вэ.

Я.Номинцэцэг: 10 хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Д.Ганцэцэг: Өмнөх жил урьдчилсан магадлан итгэмжлэлд ороод элсэлт аваагүй хөтөлбөр байна. Бакалаврын 2, магистрын нэг хөтөлбөр идэвхгүй байна.

Ж.Цэцэгмаа: оюутны тоо хэд байна вэ.

Я.Номинцэцэг: Бакалавр 355, магистр 52

Б.Очирхуяг: заавал биелүүлэхийг яаж үнэлж байгаа юм бэ. Заавал биелүүлэх зүйл байхгүй байхад хангаж байна гэж үзэх юм уу эсвэл дунжийн 80% юм уу

Ж.Ариунболд: Дээд боловсролын сургалтын байгууллагад докторын хөтөлбөр угаасаа олгоогүй. Докторын хөтөлбөр эрхэлдэггүй. Докторын төгсөгч байхгүй учраас тэр заалтыг хассан. Дээд сургуулиуд бүгд тийм. Бүх сургуулиуд яг адил байгаа.

Я.Эрдэнэсүрэн: Дараагийн удаа 4 жилийн дараа шалгаад явах боломжтой болно гэсэн үг

Ч.Лодойравсал: үндсэн зүйл нь нийтлэг шаардлагаа бүрэн хангасан байх ёстой. Үүний хэдэн хувийг хангасан бэ гэдгээр шийдэж байна уу

Ж.Ариунболд: одтойг заавал биелүүлэх ёстой.

Ч.Лодойравсал: аан за. Нийтлэг шаардлагынхаа 80%-аас дээш хангах юм байна.

Ж.Ариунболд: тийм

Д.Ганцэцэг: 90%-аас дээш хангасан байх юм бол бүрэн хангасан, 80-90% бол хангасан гэж үзнэ.

Ж.Ариунболд: та бүхэн саналаа бичээрэй

**3.БОЛОВСРОЛ, СОЁЛ ЭРХ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ:** нийтлэг шаардлагын 90% хангасан, Сургалтын их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 50%-ийг хангасан. Мэргэжлийн их сургуулийн шаардлагын 75% хангасан. Мэргэжлийн их сургуулийн 10 шаардлагын 6 шаардлагыг биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Мэргэжлийн их сургууль"*

Ж.Цэцэгмаа: энэ шинэ сургууль уу. ямар чиглэлийн сургалт явуулдаг вэ.

Д.Ганцэцэг: Хуучин сургууль. Боловсрол, урлаг, менежментийн чиглэлээр сургалт явуулдаг.

Ж.Ариунболд: Цааш явъя. Одоо энэ дээр тайлбар өгье. Техникийн зохицуулалтын 3.4 дээр заасан төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүл байгаа сургуулийг их сургууль гэж үзнэ гэж баталсан. Үүнд Төмөр замын дээд сургууль, Үндэсний тагнуулын академи, Монгол Улсын консерватор зэрэг дээр үйлчилнэ. Бид энэ сургууль дээр та бүхний санал аваад авсан саналаа нэгтгээд зөвлөмж, дүгнэлт санал зөвлөмжийг энэ сургуулиудад хүргүүлнэ. Зарим сургууль дээр хаагдах коллеж байгаа шалгуур хангахгүй коллежид хугацаа өгөөд түүнийг биелүүлсэн байх ёстой гэж явна. Тэдгээр сургуулиудад хугацаа өгөөд түүнийг биелүүлсэн байх ёстой гэж шаардана.



**3.ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД СУРГУУЛЬ:** нийтлэг шаардлагын 100% хангасан, мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 75%-ийг хангасан. Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлж буй мэргэжлийн их сургуулийн 4 шаардлагын 3 шаардлагыг биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Мэргэжлийн их сургууль"*

Я.Эрдэнэсүрэн: Энэ сургууль дээр эрдэм шинжилгээ тал дээр ОХУ-ын өгүүлэл web of science дээр ОХУ-ын сэтгүүлд хэвлэгддэг. Ер үйл ажиллагаа нь цэгцэрсэн чамбай байсан.

Ч.Лодойравсал: хангаагүй зүйл нь аль нь вэ

Д.Ганцэцэг: сүүлийн нэг жилд магистрын хөтөлбөрт элсэлт аваагүй. Өнгөрсөн хичээлийн жилд элсэлт аваагүй, докторын зэрэгтэй багшийн тоо, web of science-д бүртгэлтэй өгүүллэгийн тоо хангаагүй. Үүнд манайх ОХУ-тай хамтарч ажилладаг. Манай толгой компани ОХУ байгаа иймд ороост өгүүлэл нийтлүүлдэг. Энэ нь шалгуур хангахгүйд хүргэж байна гээд 5 өгүүлэл нэр өгсөн. Гэхдээ бид энд баталгаажсан тоогоор авч үзсэн.

Ч.Лодойравсал: 75 хувь гэж юу билээ

Я.Номинцэцэг: үзүүлэлт нь өөрөө "хувь" гэж байгаа учраас хувиар илэрхийлсэн

Ж.Цэцэгмаа: 75%-аас дээш хангаж байгаа юу

Д.Ганцэцэг: хангаж байгаа

Т.Намнан: Шинжлэх ухааны чиглэл гэж яаж авсан. Тээвэр шинжлэх ухааны салбар болох уу. Шинжлэх ухааны салбар, мэргэжлийн салбар гээд 2 тусдаа байгаа

Д.Ганцэцэг: Бид мэргэжлийн чиглэлийн ерөнхий чиглэлийг барьж ангилсан. Тооцоолол хийхэд хэцүү, сургуулиудад хатуу байна.

Б.Дамдиндорж: сүүлийн 3 жилд хэвлүүлсэн өгүүлэл 26 юм уу

Ж.Цэцэгмаа: Эднийх магадланд орж байсан. Багш нар гэхэд зэрэглэл байхгүй байсан. Яг л байна. Эрдэм шинжилгээний хувьд учир дутагдалтай байсан яг гарсан байна. Мэргэжлийн талдаа бол сайн байсан.

Я.Эрдэнэсүрэн: Эд наргүй бол төмөр зам явахгүй. Хувь хувьсгалын компаниуд бүгд эднийхээс авдаг.

Лхагвасүрэн: Яах аргагүй мэргэжлийн сургууль байна. Төрийн ачаа үүрч яваа.

Ч.Лодойравсал. Мэдээж бид Төмөр замын дээд сургуулийг хааж чадахгүй тэрүүгээр явах байх. Гэхдээ зөвлөмж дотроо тусгаж өгөх хэрэгтэй. Эрдэм шинжилгээг хийж болно. Заавал Орос дээр хийх албагүй. Төмөр замын судалгааны үр дүн ямар ч газар хэрэгжүүлэх боломж байгаа. Тэгэхээр зөвлөмж дотроо шахсан зөвлөмж өгсөн дээр байх.

**4. ҮНДЭСНИЙ ТАГНУУЛЫН АКАДЕМИ:** нийтлэг шаардлагын 100% хангасан, мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 38%-ийг хангасан. Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлж буй мэргэжлийн их сургуулийн 4 шаардлагын 3 шаардлагыг биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Мэргэжлийн их сургууль"*

Ч.Лодойравсал: Энэ сургууль дээр дээд байгууллагаас их сургуульд зөвшөөрсөн бичиг байвал зүгээр байна.

Я.Эрдэнэсүрэн: засгийн газрын сургууль гэсэн бичиг байсан

Ч.Лодойравсал: санаа нь дээд байгууллага зөвшөөрсөн гэсэн байвал яаманд зүгээр

5.ДАРХАН ДЭЭД СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 65% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 38%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 64% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж", хугацаатай үүрэг өгөх.*

Ж.Ариунболд: Хуульд нэг зүйл байна. Дээд сургуулийг их сургууль эсвэл коллеж болгоно гэж заачихсан. Бид энэ сургуулиудыг коллеж болгож байж салбарын хяналт руу явуулах хаах нээх асуудал явуулахгүй бол бидний ажлын хэсэг хаах боломжгүй. Коллеж дээр 3 шалгуурын 2-ыг хангасан. Коллеж гэдэг дээр саналтай байна.

Ж.Цэцэгмаа: Оюутны тоо хэд вэ

Д.Номинцэцэг: 708 оюутан

Д.Ганцэцэг: оюутны тоог ДБУМС-д бүртгэлтэй тоогоор авсан. Багшийн тоог яг НДШ, хичээлийн хуваарь, цагийн гүйцэтгэлийг бариад баталгаажуулсан.

Лхагвасүрэн: Коллеж дээр бас асуудалтай. Коллеж болгочоод хугацаа өгч явъя гэж байгаа юм байна.

Ж.Ариунболд: Коллеж болгочоод хугацаа өгөөд явъя. Дараа нь салбарын хяналт руу явуулах эрх зүйн орчин бүрдээд байна. Гэтэл бид очоод хаах боломж байхгүй байна.

Лхагвасүрэн: Сайжруулах гэдэг хувилбараар явъя. Тэгэхгүй бол хаах гэдгээр явах нь хэцүү юм байна.

6.МОНГОЛ ХЯТАДЫН ХАМТАРСАН ОЛОН УЛСЫН ДЭЭД СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 85% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 50%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 100% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Ж.Цэцэгмаа: Монгол оюутан суралцаж байна уу.

Д.Ганцэцэг: 297 оюутан суралцаж байна. Үүний 90% хятад оюутан

7.КИНО УРЛАГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 53% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 25%-ийг хангасан. Мэргэжлийн их сургуулийн 10 шаардлагын 2 шаардлагыг биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж", хугацаатай үүрэг өгөх*

Ж.Цэцэгмаа: Монгол оюутан суралцаж байна уу.

Д.Ганцэцэг: 297 оюутан суралцаж байна. Үүний 90% хятад оюутан

Ж.Ариунболд: коллежийн шалгуурыг түрүүнийх шиг 3 үзүүлэлтээс 2-ыг хангаагүй байна.

8.ОЛОН УЛС СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 68% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 38%-ийг хангасан. Коллежийн шаардлагыг 100% биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

9.ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 95% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 75%-ийг хангасан. Мэргэжлийн их сургуулийн 8 шаардлагын 6 шаардлагыг биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Мэргэжлийн их сургууль"*

Ж.Ариунболд: хуучин төрийн сургууль байсан. Мэргэжлийн их сургуулийг хангасан.

Д.Ганцэцэг: эднийх дэргэдээ хүнсний үйлдвэртэй, лаборатори ажиллуулдаг учир эрдэм шинжилгээ, судалгаа ажлаас олох орлого, зардал өндөр байсан.

10.ХУИС-ИЙН ХАРЬЯА ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ нийтлэг шаардлагын 80% хангасан, мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 50%-ийг хангасан. Коллежийн 3 шаардлагын 3 шаардлагыг биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

11. ШИНЭ МОНГОЛ ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 94% хангасан, Коллежийн шаардлагын 50% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж", хугацаатай үүрэг өгөх*

Ж.Ариунболд: Японы Жайка байгууллага коосэн хөтөлбөр хэрэгжүүлж буй сургуулиудад хөрөнгө оруулалт хийх гэж байгаа. Гэтэл энэ ШМТДС-ийн харьяанд байсан. Одоо тусдаа болох хүсэлттэй. Гол тавьж байгаа шаардлага нь тусдаа Статус байх тохиолдолд хөрөнгө оруулалт хийнэ гэсэн. Түүнээс биш 10 жил болсон технологийн коллеж юм.

Т.Намнан: Коосэн хөтөлбөр нь "коллеж"-оор явах уу. Коллеж гэдэг ангиллаар явах уу

Ж.Ариунболд: тийм коллеж гэсэн ангилалд авч үзнэ.

Ч.Лхагвасүрэн: Энэ хувь яасан бэ, хангахгүй байна гэхээр

Ч.Лодойравсал: Коосэн коллежийг ер нь яах ёстой вэ хангаагүй сургуулийг дэмжиж боломжгүй, бас дэмжихгүй байж болохгүй болж байна.

Ж.Ариунболд: Миний хэлээд байгаа бол санаа нь технологийн 6 коллежийг дэмжиж хөрөнгө оруулалт татах, Японы эзэн хаан ирэх үед хөрөнгө оруулалтыг татах асуудал байна. Эдгээр Коллеж дээр хувь хүрэхгүй байгаа тохиолдолд хугацаатай үүрэг өгөх нөхцөл үүсээд байна. Үүнд та бүхний санаа оноо хэрэгтэй байна.

Д.Ганцэцэг: Бид нарыг очихын өмнөх 7 хоног, 4 доктор багш авсан байсан. Гэхдээ бид шалгуураар 3 буюу түүнээс дээш сар ажиллаагүй учир доктор багшийн тоонд оруулж тооцоогүй.

Ч.Лодойравсал: Энэ сургууль дээр магистрын хөтөлбөр хэрэгжүүлэхгүй учир тооцохгүй гэж үзэх үү.

Ж.Ариунболд: тийм тооцохгүй

Мегмаринчин: тэгвэл 2 үзүүлэлтээс гэж явах юм байна.

Я.Эрдэнэсүрэн: бид 2 улирлын хичээл эхэлсний дараа очсон тул хагас авч үзэх боломжтой. Жилийн дараа тэр хүмүүс тогтвортой ажиллавал шалгуур хангана

Ч.Лодойравсал: Коосэн коллежийн хувьд магистрын хөтөлбөрийг оруулж тооцох боломжгүй юм байна. Докторын багш авсан байсныг харгалзаж үзээд гэж тэмдэглэлд оруулах, үүнийг харгалзаж үзээд дахин шалгаад "коллеж"-ийн шалгуур хангуулах

Б.Нэмэхбаатар: хэдэн оюутантай вэ.

Я.Номинцэцэг: 421 оюутан

Б.Нэмэхбаатар: Коосэн хөтөлбөр онцлогтой юм. 9 ангиас төгссөн суралцагчийг 5 жил сургалт явуулаад дэд бакалавр цол олгодог. Яг ур чадварт суурилсан сургалт явуулж

байна. 60 орчим хувийг Японы компани авчхаад байна. Японы инженерийг бэлдэж өгөөд байна. Ур чадвар өндөртэй төгсдөг. Энийг шууд хүчингүй болгоно гэвэл бас асуудал үүснэ. Тэгэхээр хүчингүй болгох гэхээр коосэн хөтөлбөрөө хаяад явна гэхээр боломжгүй.

Ж.Ариунболд: бид хугацаатай зөвлөмж чиглэл өгөх боломж байна.

Б.Очирхуяг: Дараагийн удаа коллеж орж ирвэл яах вэ. Дараа нь коллеж орж ирэхээр яах вэ. Коллежоос доошгүй байх тохиолдолд яах вэ. Дараагийн удаа "коллеж" гэж орж ирвэл яах вэ хаах гэж болох юм уу

Я.Эрдэнэсүрэн: техникийн зохицуулалтад өөрчлөлт оруулах ёстой юм болов уу.энэ ангилалын дүгнэлтийг үндэслээд салбарын хяналт руу явуулах

Я.Номинцэцэг: Техникийн зохицуулалтын 5.10 дээр байгаа. 80-аас доош байх юм бол хангаагүй бол эрх бүхий байгууллага руу шилжүүлэх боломжтой. Нөхцөл шаардлагаа хангаагүй бол дараагийн шатны байгууллага руу шилжүүлнэ.

12. СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ нийтлэг шаардлагын 79% хангасан, коллежид санал ирүүлсэн, шалгуурын 100%-ийг хангасан. Коллежийн 3 шаардлагын 3 шаардлагыг биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

13. ШУТИС-ИЙН ХАРЬЯА ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 94% хангасан, Коллежийн шаардлагын 50% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж", хугацаатай үүрэг өгөх*

Ч.Лодойравсал: Ер нь коллеж дээр зохицуулалт бодох юм байна.

Б.Очирхуяг: Ер нь хугацаатай үүрэг өгөх юм байна.

14. ШУТИС-ИЙН ХАРЬЯА ЭРДЭНЭТ ЦОГЦОЛБОР ДЭЭД СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 100% хангасан. Коллежийн шалгуур хангаж байгаа. Дүгнэлт нэгтгэсний дараа ШУТИС-ийн салбар сургууль болох хүсэлт өгсөн.

*Ажлын хэсгийн дүгнэлт: "салбар сургууль"*

Ж.Ариунболд: Сайд эрдэнэт ажиллах үед ЭТӨҮГ нь энэ сургууль хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. ШУТИС-ийн өмнөговь салбарт Оюу толгой хөрөнгө оруулалт хийх гээд байдаг, нөгөөх нь ГОК хөрөнгө оруулалт хийх гээд байдаг. Ангилалын дагуу коллеж болговол хөрөнгө оруулалт хийхгүй гэдэг үндэслэл хэлсэн. Энэ 2 сургууль засгийн тогтоол оруулж салбар сургууль больё коллеж болохгүй гэсэн санал ирсэн.

Т.Намнан: Харьяа сургууль төвөгтэй байна. Харьяалж байгаа их сургуулиас нөөцөө аваад явж боломжтой. Одоо засгийн газрын тогтоолоор тусад нь гаргаад явчихаар бас хэцүү болж байна. Орон нутагт засгийн газрын бодлогоор том төсөл явж байгаа үед хамгийн чухал болж байна. Энэ ангиллаар явбал бид ШУТИС-ийн салбар больё гэж байгаа юм. Хэрвээ ингэж үнэлэх байсан бол бид үндсэн шалгуураа ганцаараа хангаад явах боломжтой гэж байна. Аймаг орон нутгийн удирдлагатай уулзахаар уг нь орон нутагтаа харьяа байвал орон нутгаас дэмжээд явах боломжтой. Харин гараад явчихвал дэмжихэд төвөгтэй гэсэн нөхцөл байдал үүсэж байна. Харьяа сургуулийг одоо байгаа тогтолцоогоор нь авч явах, тусад нь салгаж үнэлэх нь зарим талдаа зохимжгүй байна гэж байсан байр суурьтай байна.

Ч.Лодойравсал: Танайх салбар гэдгээ дэмжвэл бид санал өгөх шаардлагагүй. Хэдүүлээ зураас тавиад явчих уу.

Ж.Ариунболд: сургуулийн удирдах зөвлөл хуралдаад засгаар оруулах юм байна. Хэрвээ их сургууль болговол ШУТИС-ийн харьяа их сургууль гэж бас гарах нь

Лхагвасүрэн: Өмнөговь бас адилхан. Саяхан байгуулагдсан ШУА шиг байгаа

**15. ЭНЭРЭЛ ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ:** нийтлэг шаардлагын 68% хангасан, Коллежид санал ирүүлсэн, шалгуурын 50%-ийг хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж", хугацаатай үүрэг өгөх.*

Б.Дамдиндорж: Хүний их эмч бэлдэж байна уу.

Мягмарринчин: Эм зүйн чиглэл давамгайлсан сургалт явуулж байсан. Ажиллаж байгаа хүмүүс мэргэжил дээшлүүлэхээр сурдаг гэж байсан

Лхагвасүрэн: Техникч бэлдэх коллеж юм байна.

Б.Дамдиндорж: Нийгмийн эрүүл мэнд судлаач бол том мэргэжил, энэ мэргэжил коллежид бэлдэхгүй.

Я.Эрдэнэсүрэн: Энэ сургууль ТЗ тааруулаад коллеж больё.

Ч.Лодойравсал: Ажлын хэсгийн дараагийн шатны байгууллага шилжүүлнэ гэдэг нь юу вэ.

Я.Эрдэнэсүрэн: Коллеж гэдэг ангилал өгье. Гэхдээ хугацаатай үүрэг даалгавар өгье гэсэн үг.

Номинцэцэг: Коллеж болгохын дараагийн шатны байгууллагад шилжүүлэх ёстой. Бид хангахгүй байгаа юм чинь хангаж байна гэж дүгнэлт гаргаж болохгүй. Дараагийн байгууллага хугацаатай албан шаардлага өгөөд гүйцэтгэлээ тооцоод энэ зөрчил арилсан байна гээд бид нарт ирүүлбэл мэдээллээ өөрчилж болно. Эсвэл магадгүй ирэх хичээлийн жилээс тоон мэдээлэл өөрчлөгдвөл тэр үед хүсэлтээ гаргаад явах боломжтой.

Ч.Лодойравсал: Гол нь дэмжээгүй байдаг. Дараагийн шатны байгууллага руу шилжүүлэх юм байна. Дэмжиж шилжүүлэх үү дэмжээгүй шилжүүлэх юм уу.

Я.Номинцэцэг: Заавал шаардлагаа хангаагүй учир дараагийн шатны байгууллага руу шилжүүлэе гэсэн байна. Тэгэхээр энд байгаа эцсийн дүгнэлтийг дэмжих эсэх байхаа

Ж.Цэцэгмаа: Коллежийг дэмжинэ гэх юм биш үү

Я.Номинцэцэг: саналын томьёолол тэр байна. Тэр нь дээр санал өгье.

Ж.Ариунболд: Энэ бол дээд сургууль статус нь коллежид очиж байна. Коллеж гэдэгт санал

**16. ЧИНГИС ХААН ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ** *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Ж.Ариунболд: 2020 оноос манай яамнаас сургуулиудыг хаасан шийдвэр гаргасан. Энэ шийдвэр дээр шүүхэдсэн. Энэ сургууль ялсан. Манайх буцаагаад заргалдаагүй. Шалгуур тавихаар хангаагүй гэхдээ энэ сургууль Монгол Хятадын хамтарсан сургуультай багш, байр нь нэг. Нэгэнт шүүхийн шийдвэр гарсан бол бид хэрэгжүүлэх ёстой. Тэгээд энэ сургуулийн удирдлагуудтай уулзаад нэг бүрэлдэхүүнд орохоор тохирсон.

Я.Эрдэнэсүрэн: Ер нь нэг анхаарах зүйл нь Хятадын ЭДҮ группийн үйл ажиллагаанд хяналт тавих. Хувийн 5, 6 сургууль дээр гарч байна. Улаан канттай сургууль бүр манайх гэж байна. Цаашид яам анхаарах хэрэгтэй. Монгол бизнест хөрөнгө оруулалт илүү хийсэн.

17. Техник, технологийн дээд сургууль нийтлэг шаардлагын 95% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 75%-ийг хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Мэргэжлийн их сургууль"*

18. Үндэсний биеийн тамирын дээд сургууль нийтлэг шаардлагын 100% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 87.5%-ийг хангасан. Мэргэжлийн их сургуулийн 8 шаардлагын 6 шаардлагыг биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Мэргэжлийн их сургууль"*

Ч.Лодойравсал: Жинхэнэ мэргэжлийн их сургууль байна.

Ж.Ариунболд: Үзүүлэлтээ ер нь өндөр хангасан байна.

Б.Очирхуяг: "Х\*1" гэдэг нийн ард мөнгөн дүн биш үзүүлэлтээр тавьсан дээр байна. Цаашид 1 дахин гэдэг үзүүлэлт тавьж явбал зүгээр юм байна.

Б.Дамдиндорж: Багш нь хэд вэ. Хориод багштай их сургууль гэж байх уу.

Я.Номинцэцэг: үндсэн багш 20, магистрт 112, бакалаврт 372

Б.Дамдиндорж: 20 багштай их сургууль гэдэг чинь

Ж.Ариунболд: Хуульд журамд байгаа шаардлагуудаа хангаж байна гэсэн үг.

19. ХӨДӨЛМӨРИЙН НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 75% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 38%-ийг хангасан. Мэргэжлийн их сургуулийн 10 шаардлагын 6 шаардлагыг биелүүлсэн. Коллежийн шаардлагыг 100% биелүүлсэн. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Ч.Лодойравсал: Цаашид ажлын хэсгийн санал тусгайлан бичих хэрэгтэй юм байна Коллеж болохыг дэмжээд салбарын хяналт руу шилжүүлнэ гэж үзэх юм байна.

Я.Номинцэцэг: Цаашид бид салбаруудыг тусад нь авч үзэхгүй бол тусдаа барилга, үйл ажиллагаа явуулж байна.

Ж.Ариунболд: Энэ сургууль хөдөлмөрийн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэж байгаа юм байна. Үйлдвэрчний эвлэлийн дэргэдэх сургууль. Бидний энэ үзүүлэлт маш бага хэрнээ цөөхөн сургууль их сургууль болж байна. Их сургууль дотроо мэргэжлийн их сургууль, судалгааны их сургуулиа ч хангахгүй байна. Их сургууль гэдэг дээр анхаарах биш харин мэргэжлийн гэдэг зүйл дээр анхаарах. Мэргэжлийн их сургууль болох бол тухайн мэргэжлээр дагнана гэсэн үг. Тэгэхээр их сургууль гэдгээсээ илүү мэргэжлийн гэдэг зүйл дээр анхаарах. Тухайн мэргэжлийн чиглэлээр доктор бэлдэнэ гэсэн үг

Ч.Лодойравсал: хөтөлбөрийн мэдээлэл өгнө үү

Номинцэцэг: 5 бакалавр, 2 магистрын хөтөлбөр, индекс нь хөдөлмөр нийгмийн аюулгүй байдал, нийгмийн ажил

Лхагвасүрэн: Увсад овоо хэдэн хүн сурдаг биз дээ.

Ж.Цэцэгмаа: Мэргэжлийн их сургууль болбол шинэ хүсэлтээ тухайн чиглэлээр зөвшөөрөл өгнө гэсэн үг үү

Ж.Ариунболд: Мэргэжлийн чиглэлээ дагнаж сургалт явуулна. Мэргэжлийн ангилал чиглэл зөвхөн энэ ангилал дээр байгаа

Ж.Цэцэгмаа: Энд та нар нэлээн өсгөж байна. Их сургуулиудыг бас дээшээ өсгөх байх да.

Я.Эрдэнэсүрэн. Хүсэлт өндөр өгсөн байна.

Б.Очирхуяг: Салбар гэвэл хуулийн этгээд үзэж байна. Хэрвээ ШУТИС -ийн өмнөговь, эрдэнэт салбар болголоо. Дахиад очиж үзэх юм уу. Одоо үнэлгээнд буураад ирэхээр энэ сургууль салбар болно гэж гээд байна тэгэхээр түүнийг сайн харах хэрэгтэй байна. Цаашид салбарыг үзвэл баруун бүс, зүүн бүсийг бас үзэх үү. Салбар бол бүрэлдэхүүн сургууль шүү.

Ч.Лодойравсал: та нар хоёр салгаж байна. Салбар үзүүлэлтийг авч үзээд сургуулийн үнэлгээг гаргах гэж байна. Ингэж салгавал энэ сургууль шаардлагаа хангахгүй. Цаашид бүтнээр нь үзэх нь зөв. Та нарын санааг юу гэж дүгнэж байна вэ гэвэл бүтнээр үзвэл унаж байна, салбараа болиулбал тэнцэх юм байна гэж ойлгож байна. Салбарын үзүүлэлт нийлүүлж үзээд хүрэхгүй байна. Иймд зөвлөмж нь Увс дахь салбарыг хаавал коллежийн шалгуур хангах юм байна. Санал юу гэж гарах вэ гэхээр Увс салбарыг хаах юм бол коллежийн шаардлага хангах юм байна

Ж.Ариунболд: МУИС дээр очихоор судалгааны, сургалтын, мэргэжлийн их сургууль дээр үнэлнэ. Ховд, Дорнод их сургууль шалгуур хангаагүй МУИС өөрсдийгөө сургалтын их сургууль гэж үнэллээ гэж бодвол бол шаардлагаа хангахгүй МУИС мэргэжлийн их сургууль болно. Тиймд салбар сургуулиа сайжруулахгүй бол хувь унана гэсэн үг.

Ч.Лодойравсал: салбараа сайжруулахгүй бол хувь унана, босго дөнгөж давах тохиолдолд салбараа хааж байж үзүүлэлт хүрэх гээд байна. Салбарууд хувийг унагаад байна.

Я.Эрдэнэсүрэн: Салбар, харьяа хоёрыг бас бодохоор юм байна.

Т.Намнан: Харьяа сургууль гэж хуульд байгаа юм чинь орон нутгийг хөгжүүлэх хүрээнд энд яригдах учраас харьяа сургуулийн үнэлэх өөр үнэлэмж гаргаж ирэх хэрэгтэй болж байна. Тэгэхгүй бол энэ асуудал манайд ч гэсэн гарч ирнэ.

Я.Эрдэнэсүрэн: Та хэд үнэлгээ хийх ажлын хэсэгт чиглэлд энэ зөвлөл зөвлөмж өгвөл бас сайн байна. Их сургуулийг үнэлнэ. Ямар ч сургууль дээр очиход нэг өдөр бүтэн ажилласан. 2 өдөр болж байна. Цаашид их сургууль 10 өдөр ажиллах байх

Ч.Лодойравсал: Бид зөв томъёолбол салбарыг хаах уу. Эсвэл сайжруулах зүйл нь шийдэгдэнэ.

20. ЭМ АЙ Ю ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 85% хангасан, Сургалтын их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 0%-ийг хангасан. Мэргэжлийн их сургуулийн шаардлагын 50% хангасан. Мэргэжлийн их сургуулийн 8 шаардлагын 4 шаардлагыг биелүүлсэн. Коллежийн шалгуурыг 100% хангасан. Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"

21.ХҮРЭЭ МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 80% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 25%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 100% хангасан. Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"

22.ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА МОНГОЛ КООСЭН КОЛЛЕЖ нийтлэг шаардлагын 88% хангасан, Коллежид санал ирүүлсэн, шалгуурын 100%-ийг хангасан. Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"

23.АВАРГА ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ нийтлэг шаардлагын 85% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 13%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 67% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Ж.Ариунболд: 2.1.6 шалгуур хангаагүй. Бакалавр зэрэгтэй багш багшилсан тул ийм асуудал үүсэж байна.

Лхагвасүрэн: Гавьяат тамирчин чинь доктортой бараг дүйцэхгүй юу. Бөхийн уурхай шүү дээ

Ж.Цэцэгмаа: Тамирчны тухайд бол тийм. Хэдэн оюутантай вэ.

Я.Номинцэцэг 362 бакалавр, 51 магистр

Ж.Ариунболд: Бакалавр багш хичээл оруулсан учраас шалгуур хангаагүй гэж үзэж байна. Ганц багш ажиллуулсны төлөө коллеж шалгуур хангахгүй байна гэх хэцүү

Я.Номинцэцэг: энэ хичээлийн жил 5 бакалавр багш багшилж байна. Өнгөрсөн хичээлийн жилд 4 багш багшилж байна. Нийт үндсэн багш 15 багш

Лхагвасүрэн: тэр нь СӨБ уу. Бөх бол дүүрч СӨБ гэдэг чинь чухал байна

Ж.Ариунболд: СӨБ-ийн хөтөлбөр хэрэгжиж байна уу

Я.Номинцэцэг: бүртгэлтэй 10 оюутантай, өмнө нь бүртгэгдсэн идэвхгүй оюутан байх магадлалтай

Б.Нэмэхбаатар: Бат-эрдэнэ аварга бол манайх шиг олон олимп, дэлхийн аварга төрүүлсэн сургууль байхгүй гээд байдаг. УИХ гишүүн байхдаа ашиг сонирхлын зөрчил гээд холдсон. Эхнээс хэлээд оролцоогүй, олимпын медалийг тоолоод үзээрэй сургуулийн ур чадвар, чансаа манайхаас гарна шүү

Лхагвасүрэн: бид үгүй гээд хэлбэл маш олон гавьяат гарч ирнэ

Б.Мягмарренчин : Энэ сургууль хүний гар хүрээгүй удсан байсан. Заал бол үнэхээр хэцүү. Коллеж болгоё. Орчноо сайжруул гээд зөвлөмж өгөөд явъя.

24.МОН-АЛТИУС ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 70% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 25%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 67% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Ж.Ариунболд: Энэ сургууль 2.1.6 шалгуур хангаагүй, систем хангаагүй байна.

Я.Номинцэцэг: заавал биелүүлэх шаардлага хангаагүй учраас бид ийм санал өгч байна

Ч.Лодойравсал: аль аль нь шаардлагаа өгвөл удирдлагын мэдээллийн системийг мөнгөтэй бол худалдаад аваад шийдэж болно. Бакалаврын зэрэгтэй багшийг халаад магистр багш авч болно. Иймд нөхцөлийг өгөөд шаардлагаа тавивал биелэх боломжтой асуудал байна.

25. ИЗОУИС-ИЙН ХАРЬЯА ДҮРСЛЭХ УРЛАГ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 85% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 25%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 100% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Я.Номинцэцэг: ИЗОУИС-аас салах хүсэлт өгсөн.



Ж.Цэцэгмаа: коллеж болно сална гэсэн хүсэлт өгсөн

Я.Номинцэцэг: салахаар бол бид хамт тооцсон асуудлыг салгаж үзнэ.

26.САНХҮҮ БИЗНЕСИЙН ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 53% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 25%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 67% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Я.Эрдэнэсүрэн: Багш оюутны тоо хэд вэ

Я.Номинцэцэг: 11 үндсэн багштай, бакалаврт 76, магистр 30

27.ХАНГАЙ ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 80% хангасан, Сургалтын их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 13%-ийг хангасан. Мэргэжлийн их сургуулийн шаардлагын 50% хангасан. Мэргэжлийн их сургуулийн 8 шаардлагын 4 шаардлагыг биелүүлсэн. Коллежийн шалгуурыг 100% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Ж.Ариунболд: Энх-амгалан сайдын үед бодлогоор хиймэл оюун ухааны хөтөлбөрийг дэмжсэн. Хэдэн багш бакалавр зэрэгтэй байна вэ.

Я.Номинцэцэг: энэ хичээлийн жилд 3 багш бакалавр байна. Нийт 42 багштай

28.УРЛАХ ЭРДМИЙН ДЭЭД СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 50% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 39%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 67% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"-ийн шалгуур хангаагүй*

29.ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСНИЙ ДЭЭД СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 40% хангасан, Судалгааны их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 0%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 67% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"-ийн шалгуурыг хангаагүй*

30.НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 33% хангасан, Коллежид санал ирүүлсэн, шалгуурын 50%-ийг хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"-ийн шалгуурыг хангаагүй*

31.МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОР: нийтлэг шаардлагын 95% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн. ТЗ-ийн 3.4 заасны дагуу мэргэжлийн их сургуульд тавьсан шалгуурын 50%-ийг хангасан. Коллежийн шаардлагын 75% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Мэргэжлийн их сургууль"*

Ж.Ариунболд: энэ сургууль ДБ-ын тухай хууль дээр тусгай заалт байгаа. Энэ сургууль мэргэжлийн их сургууль мөнөөс мөн. ЕБС-ээс эхлэн явж байгаа. Энэ сургуулийг мэргэжлийн их сургууль, Консерватор гэдгээр хуулийн нэр томъёогоор явах санал хэлсэн.

Ч.Лодойравсал: Нэг бол Консерватор гэж тусдаа ангилал гаргаж ирэх ёстой. Эсвэл бид Консерватор гэдэг малгайн дор бүх түвшин багтаг байдлаар тусгах. Ер нь эвдэж болохгүй

32.МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРЫН ХАРЬЯА ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ХӨГЖИМ БҮЖГИЙН КОЛЛЕЖ: нийтлэг шаардлагын 85% хангасан. Коллежийн шаардлагын 50% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Б.Очирхуяг: шаардлага хангахгүй байгаа сургуулийг дэмжих гээд байна уу. Сургууль ямар хүсэлттэй байсан бэ. Шалгуур хангахгүй байхад хангаж байна гээд ачаалах гээд байна.

33. ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ САЛБАР СУРГУУЛЬ: нийтлэг шаардлагын 65% хангасан, Мэргэжлийн их сургуульд санал ирүүлсэн, шалгуурын 50%-ийг хангасан. Коллежийн шалгуурыг 67% хангасан. *Ажлын хэсгийн дүгнэлт: "Коллеж"*

Ж.Ариунболд: За ажлын хэсгийн дүгнэлттэй танилцлаа. Багцлаад аваад үзвэл тусгай чиг үүрэг гээд 4 сургууль, ШУТИС-ийн харьяа гээд 2 сургууль дээр дараа нь шийдвэр гарна. Плехановын сургуулийг сайд үлдээгээрэй гэсэн. Ямар учир байна гэхээр Путин ирээд хөрөнгө оруулалтын асуудал ярьсан. Тийм учраас үлдээсэн. 2 улсын асуудал байгаа учраас үлдээлээ. Ер нь эдгээр үзүүлэлтийн цаад утга нь юунд тулгуурлаж байна вэ гэхээр Times higher education дээр тулгуурлаж эрэмбийн асуудлыг авч үзсэн. Олон улсын жишиг үзүүлэлтээс 5 дахин доогуур үзүүлэлт гэтэл энэ үзүүлэлтэд манай сургууль хүрэх боломж харагдахгүй байна гэхдээ мэргэжлийн их сургууль бусад ангиллаас бага үзүүлэлттэй байгаа. 33 сургуулиас 9 сургууль мэргэжлийн сургууль, бусад нь коллеж болох дүр төрх харагдаж байна. Энэний дараа их сургуулийн ангилал тогтооход ямар түвшинд ажиллах вэ гэдэг зүйл бас яригдана. Бид нар хаана гэхээс илүү коллеж болгоод болохгүй зүйлээ засаад явах зэрэгт төрийн дэмжлэг байх хэрэгтэй гэж үзэж байна.

Я.Эрдэнэсүрэн: ажлын хэсгийн гишүүнээр ажилласан хүний хувьд энэ дүгнэлтийн ангилал хангатай гарсан байна. Цаашид хөгжлийг дэмжих асуудал нь сургуулийн үйл ажиллагаанаас хамаарна. Дараагийн ээлжид их сургуулийн хувьд салбар, харьяа сургуулийн хувьд хэрхэн ажиллахад яаж ажиллах талаар та бүгд санал өгвөл дараа нь ажиллах түвшинд санал өгвөл зүгээр байх

Ч.Лодойравсал: хэрвээ тэгвэл салбар сургууль үзүүлэлтэд нөлөөлөх учир салбар сургуулийг хаах санал гарч магадгүй. Очирхуяг захирлын хэлдэг засгаас хүчээр нийлүүлсэн сургууль байна. Тухайн сургууль болилоо гэж чадахгүй учраас тооцогдоно. Энэ сургууль аттестатчилалд орсон байгаа. Бүгд магадлаад, аттестатчилагдсан хэр нь яагаад мэдээллийн систем гэдэг дээр асуудал үүсэж байна вэ

Ж.Ариунболд: их сургуулиудыг өөрсдийн үнэлүүлээд авсан. Одоо үргэлжлээд явна. Энэ жилдээ заавал хийнэ. Тэгж байж эрэмбэ тогтооно. Коллежоо хооронд нь, их сургуулиа хооронд нь

Лхагвасүрэн: явсаар байгаад төрийн хэд маань үлдэх юм байна даа. Тэртэй тэргүй явсаар байгаад коллеж болж байна. Улсын хэдэн сургууль маань ноён нуруугаа авч яваад бусад тохиолдолд яах вэ. Тэгэхээр дээд түвшнээ чанга бариад хувийн сургуулиа хаагаад явах

Б.Нэмэхбаатар: ажлын хэсэг нэлээн бодитой ажилласан байна. Гарч байгаа дүгнэлт аль аль талаа бодолсон байна. Саяхан болтол 170 орчим байсан бол одоо жаран хэд гээд цөөрсөн, зөв голдирол руу явж байна. Хувийн их сургууль цаашид нэгдэж нийлэх тал руу асуудал бас яригдаж байна.

Ж.Ариунболд: дээд сургууль коллеж хоёр ялгаагүй. Нэрийг нь сольсон болохоос биш хэрэгждэг ажил явагдаж байгаа. 2023 онд хууль гарсан. 2024 онд техникийн зохицуулалт батлагдсан. Сургууль сүүлийн жилд хамгийн өндөр өсөлт гарч ирсэн. Одоо та бүгдийн шийдвэрийг нэгтгээд сайдад танилцуулна. Эцсийн шийдвэрийг сайд гаргана.

Я.Эрдэнэсүрэн: энэ шийдвэрийг зарлахаас өмнө политехник коллеж, коллеж <sup>3</sup>хорын таниулсан мэдээлэл цацах хэрэгтэй байна.

**САНАЛЫН НЭГТГЭЛ:**

**Мэргэжлийн их сургууль**

1. Монгол улсын консерватор
2. Төмөр замын дээд сургууль

3. Үндэсний Тагнуулын Академи
4. Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль
5. Техник, технологийн дээд сургууль
6. Технологийн дээд сургууль
7. Үндэсний биеийн тамирын дээд сургууль
8. Шинжлэх Ухааны Академийн их сургууль
9. Шинэ монгол технологийн дээд сургууль

#### Коллеж

1. Монгол улсын консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж
2. ШУТИС-ийн харьяа Технологийн коллеж
3. Аварга дээд сургууль
4. Дархан дээд сургууль
5. Мон-Алтиус дээд сургууль
6. Монгол Хятадын хамтарсан олон улсын дээд сургууль
7. ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх урлаг, дизайн, технологийн дээд сургууль
8. Кино урлагийн дээд сургууль
9. Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль
10. Олон улс судлалын дээд сургууль
11. Санхүү бизнесийн дээд сургууль
12. Соёл-Эрдэм дээд сургууль
13. Урлах эрдмийн дээд сургууль
14. Хангай дээд сургууль
15. Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль
16. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Хүмүүнлэгийн дээд сургууль
17. Хүрээ мэдээлэл холбоо, технологийн дээд сургууль
18. Эдийн засгийн үндэсний дээд сургууль
19. Эм Ай Ю дээд сургууль
20. Энэрэл дээд сургууль
21. Монгол Коосэн технологийн коллеж
22. Шинэ Монгол технологийн коллеж

#### Салбар

1. ШУТИС-ийн харьяа "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль
2. ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль
3. Чингис хаан дээд сургууль /МХХОУДС-ийн бүрэлдэхүүн/

Танилцсан. Ажлын хэсгийн ахлагч

Ж.АРИУНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн. Нарийн бичиг

Д.ГАНЦЭЦЭГ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН АНГИЛАЛ ТОГТООХ  
ТУШААЛ БАТАЛГААЖУУЛСАН АЛБАН ТУШААЛТАН

Гүйцэтгэсэн	Нэр	Албан тушаал
баталсан	П.Наранбаяр	Боловсролын сайд
хянасан	Х.Батжаргал	Төрийн нарийн бичгийн дарга
хянасан	Г.Донров	Сайдын зөвлөх
хянасан	Б.Алтансүх	ТУЗГ-ын дарга
хянасан	Э.Гансүх	Хуулийн хэлтсийн дарга
хянасан	Ж.Ариунболд	ДБГ-ын дарга
Боловсруулсан	Д.Ганцэцэг	гэрээт ажилтан



## Approvals

Report • Printed on August 5, 2025

Approved

### Төсөл - КУДС

Танд албан бичгийн төсөл хянуулахаар ирлээ. # Nd

Хаана, хэнд: КУДС

Товч утга: Кино урлагийн дээд сургууль

Ирсэн бичгийн холбоос:

Бусад холбоос:

Тайлбар, хүсэлт: хянан баталж өгнө үү

Боловсруулсан: [Ганцэцэг Данзан]

Холбоос линк:

[https://m.mongolaneducation.sharepoint.com/\\_layouts/15/Compliance/RECEIVED/3306889XUWLD91K2.../KUM%20%D0%A1](https://m.mongolaneducation.sharepoint.com/_layouts/15/Compliance/RECEIVED/3306889XUWLD91K2.../KUM%20%D0%A1)

Log: \*

\*\*Таны цуцалсан тоо: \*\* 0

Хянасан албан тушаалтнууд:

**Ариунболд Жаалжав 5/28/2025 9:27 PM**

**Энхтөр Гансүх 6/2/2025 3:42 PM**

**Алтансүх Бавуудорж 6/3/2025 12:59 PM**

**Гантулга Доноров 6/3/2025 4:16 PM**

**Батжаргал Ханджав 6/3/2025 4:45 PM**

---

#### ▼ Attachments



Коллеж-КУДС

<https://m.mongolaneducation.sharepc>

Final status: Approved



Approved by  
Наранбаяр Пүрэвсүрэн  
Батлав

6/5/2025, 4:07:14 PM



Requested by  
Ганцэцэг Данзан

6/5/2025, 2:40:44 PM



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/312

Утгаартай хэл

Мэргэжлийн их сургуулийн ангилалд  
хамруулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, Боловсролын ерөнхий хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 253 дугаар тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт"-ийн 3.4, 5.5, Боловсролын сайдын 2025 оны А/07 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт, Дээд боловсролын зөвлөлийн 2025 оны 05 сарын 07-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Монгол улсын консерваторыг мэргэжлийн их сургуулийн ангилалд хамруулсугай.
- 2.Ангилал шинэчлэн тогтоосонтой холбогдуулан холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол улсын консерваторын захирал (Ц.Шаравцэрэн)-д үүрэг болгосугай.
- 3.Тусгай зөвшөөрөлд холбогдох өөрчлөлтийг хийж энэхүү тушаалын хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Дээд боловсролын газар (Ж.Ариунболд)-т үүрэг болгосугай.
- 4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

П.НАРАНБАЯР



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/293

Угтаандаа хэл

Коллежийн ангилалд хамруулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, Боловсролын ерөнхий хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 253 дугаар тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт"-ийн 5.5, Боловсролын сайдын 2025 оны А/07 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт, Дээд боловсролын зөвлөлийн 2025 оны 05 сарын 07-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Кино урлагийн дээд сургуулийг коллежийн ангилалд хамруулсугай.

2. Ангилал шинэчлэн тогтоосонтой холбогдуулан холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Кино урлагийн коллежийн захирал (Ж.Содбилэгт)-д үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөлд холбогдох өөрчлөлтийг хийж энэхүү тушаалын хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Дээд боловсролын газар (Ж.Ариунболд)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

П.НАРАНБАЯР

42

14251 0830



ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН АНГИЛАЛ ТОГТООСОН ТУШААЛ

№	Сургалтын байгууллага	ангилал	Тушаалын дугаар
1	Техник, технологийн дээд сургууль	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/309
2	Монгол улсын консертавтори	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/312
3	Үндэсний биеийн тамирын дээд сургууль	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/308
4	Төмөр замын дээд сургууль	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/313
5	Үндэсний Тагнуулын Академи	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/295
6	Технологийн дээд сургууль	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/322
7	Шинэ монгол технологийн дээд сургууль	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/314
8	Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/323
9	Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/297
10	ШУТИС-ийн харьяа "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль	Мэргэжлийн их сургууль	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/311
11	Монгол Коосэн технологийн коллеж	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/316
12	Шинэ Монгол технологийн коллеж	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/315
13	Эм Ай Ю дээд сургууль	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/318
14	Хангай дээд сургууль	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/321
15	Хүрээ мэдээлэл холбоо, технологийн дээд сургууль	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/303
16	ШУТИС-ийн харьяа Технологийн коллеж	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/296

17	Энэрэл дээд сургууль	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/320
18	Соёл-Эрдэм дээд сургууль	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/310
19	Монгол Хятадын хамтарсан олон улсын дээд сургууль /Чингис хаан ДС/	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/317
20	Кино урлагийн дээд сургууль	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/293
21	ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх урлаг, дизайн, технологийн дээд сургууль	Коллеж	Боловсролын сайдын 2025 оны 06 сарын 05-ны А/304
